



МАУБХ

МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХОЛБООНЫ СЭТГҮҮЛ

Улаанбаатар хот

Хэвлэл №8


Дугаар №8

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ

2023 он VI сар

МАУБХ-ны X хуралд Зоригдсан дулаар

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛҮҮД

6. МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТОГЛОЦОО, ЭМЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ШИНЭ ҮЗЭЛ БАРИМТЛАА
15. АНАГААХЫН БИОЛОГИЙН ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙН СУДАЛГАА
18. АНАГААХЫН БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ СУУРЬ ЭРДМИЙН СУРГАЛТАД ОЮУТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ
23. АНАГААХЫН ОЮУТНЫ ЦАХИМ СУРГАЛТЫН ҮЕИЙН ХАНДАЛТ БОЛОН СУРЛАГЫН АМЖИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА
27. АНАГААХЫН СУРГУУЛИЙН ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА
32. ИХ СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС
41. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ ДЭХ УДИРДАХ АЖИЛТАНТАЙ ХОЛБООТОЙ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУДАЛСАН ДҮН
44. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАРЫН ЗАРИМ АСУУДААД
50. ОЛОН МЭРГЭЖЛИЙН БАГТ ХАМТРАН СУРАЛЦАХУЙН АРГЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР НЭВТРҮҮЛСЭН ҮР ДҮН
56. ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, НИЙГЭМ-ЭРҮҮЛ АХУЙН МОНИТОРИНГИЙН АСУУДААД
61. СУРАЛЦАХАД ҮҮСЭЖ БҮЙ БЭРХШЭЭЛД НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН НЬ
66. ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛААД ТУЛГУУРЛАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДААД
72. ҮР ДҮНД СУУРИЛСАН СУВИЛАХУЙН ХӨТӨЛБӨРӨӨР ТӨГСӨГЧ ОЮУТНЫ ЦОГЦ ЧАДАМЖИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ
76. "ХӨДӨЛМӨР ЗАСАЛ" ХӨТӨЛБӨРИЙН ТУСЛАХ ТЕХНОЛОГИЙН ЛАБОРАТОРЫН ХЭРЭГЦЭЭ
82. ХӨХНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ТАЛААРХ СУВИЛАГЧИЙН МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ НЬ
86. ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖ" ЧИГЛЭЛЭЭР СУРАЛЦАГЧДЫН ДИНАМИКТ НӨЛӨӨЛӨХ БОЛОВСРОЛЫН СЛБАРЫН ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

90. МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХОЛБОО IX ХУРАЛ
91. АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН ХУРАЛ
94. АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДАЛЛЫН ХӨГЖИЛ
97. ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ



Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбооны Х хуралд Зориулав

“АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ” сэтгүүлийн редакцын зөвлөл

Ерөнхий редактор:

Ц.Лхагвасүрэн Академич, Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор

Сэтгүүлийн редакцын зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Д.Отгонбаяр АУ-ны доктор, профессор

Редакцын зөвлөлийн гишүүд:

Д.Амарсайхан АУ-ны доктор, профессор

Н.Сүмбэрзул Анагаах Ухааны Академийн гишүүн, АУ-ны доктор, профессор

Д.Цэрэндагва Анагаах Ухааны Академийн гишүүн,
Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор

Д.Дүнгэрдорж Академич, Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор

Н.Хүрэлбаатар АУ-ны доктор, профессор

Н.Баасанжав Академич, Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор

М.Амбага Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор

Д.Нацагдорж Буддын гүн ухааны гэвш

Б.Батсэрээдэнэ АУ-ны доктор, профессор

Л.Цэрэндулам Эм зүйн ухааны доктор, профессор

Б.Оюунгоо АУ-ны доктор, профессор

Б.Солонго АУ-ны доктор, дэд профессор

Хаяг: Зоригийн гудамж-3, Ш/Х-48-111, Улаанбаатар-210648, Монгол улс

Утас: 7013-1372

Албан ёсны вэб хуудас: www.mmea.mn

Цахим шуудан: otgonbayar@mmea.mn

Эх бэлтгэсэн: М.Бадмаараг, А.Индра, Д.Отгонбаяр

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХОЛБОО

Монгол оронд ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хувийн хэвшлийн сургуулиуд байгуулагдах боломж нээлттэй болж, ЭМШУИС-аас гадна 1991 онд “Оточ Манранба”, 1998 онд “Ач”, 2000 онд “Монос”, 2001 онд “Энэрэл”, 2004 онд “Этүгэн” зэрэг анагаах ухааны сургуулиуд байгуулагдан улсын 4, хувийн хэвшлийн 4 сургууль нэгдэн Монголын Анагаах Ухааны Боловсролын холбоо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагыг анх 2001 оны 3-р сард ЭМШУИС-ийн захирал академич Ц.Лхагвасүрэнгийн санаачилгаар анх үүсгэн анагаах ухааны боловсролыг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой үйл явдал болсон юм. Холбоо нь Монгол Улсын Эрүүл Мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэн гаргаж байгаа төрийн болон төрийн бус өмчийн анагаахын их, дээд сургуулиудын сургалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний чиглэлээр байгуулагдсан цагаас хойш тасралтгүй 21 жил үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Одоо Холбооны тэргүүнээр Монголын Анагаах Ухааны Академийн ерөнхийлөгч, академич Ц.Лхагвасүрэн, гүйцэтгэх захирлаар АУ-ны доктор, профессор Д.Отгонбаяр нар ажиллаж байна. Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбооны үндсэн үүрэг бол Монгол улсад анагаахын боловсрол олгодог сургуулиудын үйл ажиллагааг холбож нэгтгэх, төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтаар анагаах ухааны боловсрол олгож байгаа процессыг үнэлж дүгнэх, үйл ажиллагааг хооронд нь нэгтгэх, чанарыг ахисан түвшинд хүргэх, явдал юм.

Холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн НЭГДҮГЭЭРТ төрийн ба төрийн бус анагаахын сургуулиудыг нэгтгэж сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, оюутны мэдлэгийг үнэлэх үнэлгээг боловсронгуй болгох, сургалтын аргазүйг сайжруулах, өөрчлөх, шинэчлэх сургалтын агуулга бүтэц зохион байгуулалтыг олон улсын түвшинд хүрэх асуудлын санаачилж, өөрийнхөө ололт туршлагыг бусдад хүртээх, ХОЁРДУГААРТ Монголын анагаах ухаан боловсролын тогтолцоо болоод түүний өнгө төрхийг илэрхийлж байгаа сургуулийн багш судлаачдыг олон улсын боловсролын холбооны хурал чуулганд оролцуулж, цаашид олон улсын чанартай Анагаахын Боловсролын сургалт, хурал зөвлөгөөнд оролцож мэдэж сурсан зүйлээ бусдад сургуулийнхаа багш, мэргэжилтнүүддээ хүртээх, түгээх, таниулах өөрөөр хэлбэл оюуны хөрөнгө оруулалтыг бусдадаа хүртээх хамтдаа хөгжих, хамтдаа бүтээх зорилгыг агуулж байгаа болно.

Монголын Анагаах Ухааны Холбооны үйл ажиллагаа нь байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэл 2 жил тутамд үндэсний хэмжээний хурлаа 10 дахь удаа зохион байгуулж байгаа бөгөөд энэ салбарын судлаачдын бүтээлийг нийтийн хүртээл болгодог “Анагаах Ухааны Боловсрол” сэтгүүлийнхээ 8 дахь дугаарыг хэвлүүлээд байна.

Монголын Анагаах Ухааны Боловсролын холбооны анхдугаар хурлыг 2003 оны 4-р сарын 1-2-нд хийж, уг хурлаараа зохион байгуулалтын асуудал хэлэлцэж МАУБХ тэргүүнээр профессор Ц.Лхагвасүрэн, гүйцэтгэх захирлаар дэд профессор Т.Алтанцэцэг, нарийн бичгийн даргаар сургалтын албаны арга зүйч Н.Сүмбэрзул нарыг сонгосон байна. МАУБХ-ны анхдугаар хуралдааныг “Шинэ зуун- шинэ сургалт” уриан дор зохион байгуулж, бүрэлдэхүүн сургууль, харьяа коллежуудын 30 гаруй төлөөлөгч оролцжээ.

МАУБХ-ы II хурлыг 2005 оны 4 сарын 13 өдөр “Сургалтын дэвшилтэт арга технологи” сэдвийн дор ЭМШУИС-д зохион байгуулж, ЭМЯ, БСШУЯ, НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ-аас нийт 60 гаруй удирдах

ажилтан оролцсон нь ихээхэн онцлог байжээ. Өөрөөр хэлбэл анагаах ухаан өөрөө боловсролын асуудлаа бие даан явуулах академик эрх чөлөөг эдэлж эхэлсэн үе гэж дүгнэж болох юм. АУБХ-ны II хуралд оролцогсдоос Анагаах Ухааны Боловсролын Холбоо, түүний харьяа сургуулиуд багш нар, анагаахын сургуулиуд болон коллежуудын оюутнуудад хандан зөвлөмж гаргасан байна. Сурталтанд асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, оюутан төвтэй, өргөн сонголттой зэрэг дэвшилт арга барилыг өргөн нэвтрүүлэх зорилгоор олон улсын чанартай сурган заах арга зүйн семинар Япон, Америк, Солонгос зэрэг орны эрдэмтэдтэй хамтран 6 удаа, сургуулийн төвшинд 15 удаа бүгд 21 сургалт семинар зохион байгуулсан байна. Хурлаар зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МАУБХ-ы ҮЗ-ийн даргаар Д.Амарсайхан, тэргүүнээр Ц.Лхагвасүрэн, гүйцэтгэх захирлаар ЭМШУИС-ийн Сургалтын албаны дарга Д.Цэрэндагва нарыг санал нэгтэй сонгов.

МАУБХ-ны III хурлыг 2007 оны 04 сарын 04-ны өдөр “Мэргэжлийн боловсролын ирээдүйн чиг хандлага, тулгамдсан асуудал, тэргүүлэх чиглэл, хэтийн зорилт” сэдвээр зохион байгуулж, 29 байгууллагын 75 багш, судлаачид оролцлоо. МАУБХ нь албан ёсны сэтгүүлийг ЭМШУИС үүсгэн байгуулагдсаны 65 жилийн ой, МАУБХ-ны IV хуралд зориулан анх 2007 оны 4 дүгээр сард нийтийн хүртээл болгосон. ЭМШУИС-ийн 65 жилийн ойг тохиолдуулан, ЭМШУИС-ийн сургалтын албатай хамтарч Монголд анх даа Анагаах Ухааны Боловсрол Судлалын олон улсын хурлыг 2007 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Гадаад Хэргийн Яамны хурлын дугуй танхимд амжилттай зохион байгуулсан.

МАУБХ-ны IV хурлыг 2009 оны 05 сарын 05-ны “Нэг стандарт-нэгдмэл хөтөлбөр” сэдвийн хүрээнд өдөр зохион байгуулж, БСШУЯ, ЭМЯ, ДЭМБ байгууллага, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын 60 гаруй төлөөлөгчид оролцов. Хурлаар “Шилдэг боловсрол судлаач” шагнал бий болгосон

МАУБХ-ны V хурлыг 2011 оны 04 сарын 01-ны өдөр “Даяарчлал ба анагаах ухааны боловсрол судлал” сэдвээр Нүхт Корпорейт цогцолборт зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн 15 их дээд сургууль, ДЭМБ, ЭМЯ, Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл, Боловсролын Хүрээлэн зэрэг 28 байгууллагын 120 боловсрол судлаач, эрдэмтэд, зочид төлөөлөгчид оролцов. 2011 онд МАУБХ-ы ҮЗ-ийн даргаар Ц.Лхагвасүрэнг, тэргүүнээр Д.Цэрэндагвыг, гүйцэтгэх захирлаар Д.Отгонбаяр нарыг сонгов.

МАУБХ-ны VI хурлыг 2012 оны 4 сарын 07-ны өдөр “Анагаах Ухааны Боловсролын хөгжил, Сургалт-Судалгаа-Стандарт сэдвээр “Их тэнгэр” цогцолборт зохион байгуулаа. Хуралд төрийн болон төрийн бус өмчийн 16 их, дээд сургууль, төрийн болон олон улсын байгууллагын 133 боловсрол судлаач, эрдэмтэд, зочид төлөөлөгчид оролцож, АУ-ны Боловсрол судлалын чиглэлээр мэдлэг, туршлагаа хуваалцлаа. Энэ удаагийн хурлаар МАУБХ-ы үйл ажиллагаанд тогтмол үр бүтээлтэй оролцож ирсэн гишүүн сургуулиудад батламж гардуулав.

МАУБХ-ны VII хурлыг 2013 оны 04 сарын 12-нд “Анагаах Ухааны Боловсролын Үнэлгээ-Одоо ба Ирээдүй” сэдвээр Этүгэн дээд сургуульд зохион байгуулж 10 гаруй их, дээд сургуулийн 120 гаруй судлаачид оролцов.

МАУБХ-ны VIII хурлыг 2015.04.24-ны өдөр “Анагаахын Боловсролын Тулгамдсан асуудлууд” сэдвээр Шинэ Анагаах Ухаан Дээд сургуульд зохион байгуулав.

МАУБХ-ны IX хурлыг Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбоотой хамтран “Анагаахын Боловсролын Чанар- Магадлан Итгэмжлэл” сэдвээр МАУБХ-ны IX дүгээр хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “Corporate Convention Center”- ийн Улаанбаатар танхимд амжилттай зохион байгууллаа. Тус хуралд МАУБХ-ны гишүүн сургуулиуд болох “АШУУИС”, “Ач” АУИС, “ЭЗШУИС”, “Оточ манрамба” АУИС, “Шинэ Анагаах Ухаан” ИС, “Энэрэл” ДС, “МҮИС”, Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл зэрэг байгууллагуудын төлөөлөн оролцож, илтгэл хэлэлцүүлж, харилцан туршлагаа солилцлоо. Энэ удаагийн хурлын үеэр ИАЗОУИС-ийн Анагаах ухааны сургууль албан ёсоор холбооны гишүүн сургуулиар бүртгэгдэж батламжаа гардан авав. Хурлаас гарсан санал, зөвлөмжийн дагуу Анагаахын сургуулиудад бэлтгэж байгаа мэргэжил тус бүрийн хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаар МАУБХ-ноос санаачлан нээлттэй хэлэлцүүлгүүдийг гишүүн сургуулиудыг хамруулан зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

МАУБХ-ны X хурал 2023 оны 06 сарын 16-ны Баасан гаригт “ХУВЬСАЖ БҮЙ ДЭЭД БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖИЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ” сэдвийн хүрээнд “Corporate Convention Center”-ийн View Event танхимд зохион байгуулагдаж байна.

Түүнчлэн Холбоо нь төрийн захиргааны төв байгууллагууд болон олон улсын төслийн байгууллагын захиалга болон төслийн дагуу хэд хэдэн төсөл захиалгыг амжилттай хэрэгжүүлээд байна. Тухайлбал Монгол Улсын Эрүүл Мэндийн Яамын захиалгаар Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам, Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбоотой байгуулсан гэрээний дагуу үндсэн 6 мэргэжлийн үүнд: Хүний их эмч, Уламжлалт анагаахын их эмч, Нүүр амны их эмч, Эм зүй, Сувилагч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх Дээд Боловсролын Стандартыг гишүүн сургуулиудын төлөөллөөс бүрдсэн 31 хүний бүрэлдэхүүнтэй баг хамтран ажиллаж Стандартчилал хэмжилзүйн газрын Боловсрол, соёлын стандартчиллын дэд хорооны 2012 оны 12 сарын 10-ны өдрийн хуралдаанаар хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эм зүй, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх анагаах ухааны дээд боловсролын стандартуудыг хэлэлцүүлэн дэмжигдэж, 2012 оны 12 сарын 20-ны өдөр Монгол Улсын Стандартчилал Хэмжил Зүйн Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэн баталгаажуулж Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх Анагаахын Дээд боловсролын үндэсний стандартыг 6 мэргэжлийн чиглэлээр хэрэгжүүлж эхлээд байна. Мэргэжлийн стандарт боловсруулах ажлын хэсэгт Монгол улсад тухайн чиглэлийн эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэн төгсгөдөг тухайн үеийн ЭМШУИС-ийн салбар болон бүрэлдэхүүн сургууль, Ач анагаах ухааны дээд сургууль, Этүгэн анагаах ухааны дээд сургууль, Монос анагаах ухааны дээд сургууль, Оточ манрамба дээд сургууль, ЭМЯ, Стандартчилал хэмжилзүйн газрын төлөөлөл бүхий 31 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажилласан болно.

МАУБХ нь 2013 онд ЭМШУИС-тай хамтран Азийн Анагаах Ухааны Боловсролын Холбооны VII хурлыг 2013 оны 6 сарын 9-12-ны хооронд “Анагаахын Боловсролын Үнэлгээ Одоо ба Ирээдүй” сэдвээр эх орондоо анх зохион байгуулж, тус хуралд 13 орны 300 орчим боловсрол судлаачид, эмч мэргэжилтнүүд анагаахын боловсролын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн талаар харилцан мэдлэг, туршлага солилцсон юм. Азийн Анагаах Ухааны Боловсролын Холбоо нь 2001 онд байгуулагдсан бөгөөд эгнээндээ Азийн 50 гаруй АУ-ны Боловсрол олгодог их дээд сургуулийг нэгтгэсэн сайн дурын байгууллага юм. Тус холбооны хурал нь 2 жилд нэг удаа зохион байгуулагддаг бөгөөд ээлжит 7-р хурлыг өөрийн сургууль дээрээ зохион байгуулах эрхийг МУ-ийн ЭМШУИС авч Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбоотой хамтран амжилттай зохион байгуулаад байна.

ОРШИЛ ҮГ



Анагаах ухааны боловсрол судлаач эрхэм нөхөд өө...

Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбооны ээлжит X хуралд оролцож байгаа мэргэжил нэгтэй эрхэм хүндэт та бүхнийхээ амар мэндийг ирэн мэндчилье.

Монгол улсад эмч мэргэжилтэн сургаж бэлтгэдэг их дээд сургуулиудын эрдэмтэн профессор,багш нар та бид сургалтыг боловсронгуй болгож сайн мэргэжилтэн бэлтгэн гаргах ажил үйлсдээ шамдан зүтгэж хамтран ажилладаг сайхан уламжлалтай билээ. Их сургуулийн хамгийн чухал үйл ажиллагаа бол хичээл сургалтын ажил юм. Анагаах ухааны боловсролыг хөгжүүлэн түүчээлэх явдал бол их сургуулийг бүх талаар нь хөгжүүлэх гарц нь болно.

Энэ удаагийн хурлаараа “ХУВЬСАЖ БУЙ ДЭЭД БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖИЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ” сэдвийн хүрээнд хамтын оюун бодлоо нэгтгэн анагаах ухааны боловсрол судлалын чиглэлээр шинэ сонин мэдээг дуулгаж, арга туршлагаа харилцан ярилцаж, хуваалцах гэж байгаадаа баяртай байна. Цаг хугацааны эрхээр сургалтын арга технологи,чиг хандлага зогсолтгүй хувьсан шинэчлэгдэж эрчтэй хөгжиж байгаа нь бид бүхнийг тасралтгүй суралцахад хүргэж байна.

Бид дэлхий ертөнцийн хөгжил дэвшлээс мэдэж суралцахаас гадна монголчууд бид өөрсдөөсөө, ухаант мэргэдээсээ суралцах ёстойг ухаарсаар байна. Энэ удаагийн хуралд оролцогсод харилцан бие биеэсээ суралцах боломж олдож байгаа нь тустай хэрэг. Хуралд илтгэл хэлэлцүүлж,туршлагаа ярьж хуваалцсан бүх хүнд талархал илэрхийлье.

Бид хамтын оюун ухаанаа зузаатган эвлэлдэн ажилласны хүчинд монголын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулж, эх орныхоо хөгжилд тус дэм болох учиртай. Анагаахын сургуулийн бүх мэргэжлийн багш нар бүгдээрээ Анагаах ухааны боловсрол судлалд суралцаж хамтран зүтгэж байж амжилтад хүрэх учиртай.

Та бүхэндээ ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Академич Цэрэнхүүгийн Лхагвасүрэн

2023.06.16

МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО, ЭМЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ШИНЭ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ц.Лхагвасүрэн¹, О.Болорсайхан²


¹АШУУИС-ийн зөвлөх, Академич, АШУ-ны доктор, профессор

²АШУУИС, БАС, ХУЧ-ын АУ-ны доктор, дэд профессор


Дэлхий дээр их сургууль хэмээх эрдмийн эх уурхай одоогоос 1000 орчим жилийн өмнө Европ-д анх үүссэн бол Монгол оронд XVI зууны сүүлээр Түшээт хан аймгийн Баатар вангийн хошуу, одоогийн Булган аймгийн Хутаг Өндөр сумын Намнангийн нурууны өвөрт Сэлэнгэ мөрний хойд дэнжид 1585 онд Лувсанчойдог ламын байгуулсан хүрээ нь Манба дацан байжээ¹. Ийнхүү Монгол оронд эмч бэлтгэх анхны дэг сургууль болох манба дацан одоогоос 438 жилийн тэртээ байгуулагдсан байдаг.

Дэлхий нийтийн боловсрол судлаачид боловсролын 5 үндсэн загвар байна. Энэ нь АНУ, Англи, Франц, Герман, Япон улсын боловсролын систем юм. Дэлхийн аль ч орны боловсролын систем эдгээр боловсролын системийн төсөөтэй хувилбар байдаг гэж үзэж байна. Аль ч орны боловсролын загварыг судалсан түүнийг шууд хуулбарлалгүй тухайн орныхоо түүхэн болон эдийн засаг, улс төр, хүн ардын соёл, боловсрол, ёс зүйн өвөрмөц онцлогийг заавал тооцож үзэх ёстой юм^[2].


Монгол Улсын Боловсролын Систем



Хүний хөгжлийн индекс нь хүний чадавхын хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлдэг.



Монгол Улс 2022 онд өрсөлдөх чадвараар 63 улсаас 61 дүгээрт эрэмбэлэгдэж, өрсөлдөх чадварын ерөнхий оноогоор 36.2 болж өмнөх оноос буурчээ. Өрсөлдөх чадварыг энгийнээр тайлбарлавал хүмүүсийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын чанарыг хангахын тулд өөрийн нөөц бололцоо, чадамжаа хэрхэн уялдаатай ашиглаж байгааг харуулах үзүүлэлт юм.



Хүмүүн капиталыг ерөнхийд нь хүмүүсийг бүтээмжтэй байхад нь тусалдаг мэдлэг, ур чадвар болон бусад хувийн шинж чанаруудын нөөц гэж тодорхойлж болно. Албан (сургуулийн өмнөх боловсрол, албан ёсны сургуулийн тогтолцоо, насанд хүрэгчдийн сургалт) болон албан бус боловсрол, ажлын байран дээр суралцах, ажлын туршлага хуримтлуулах нь хүмүүн капиталд

хөрөнгө оруулалт хийж буй хэрэг юм*.

Хүн боловсрол эзэмшинэ гэдэг нь өөртөө эзэн байх чадвар төдийгүй насан туршдаа сурч боловсрох шаардлага тулгарч байна. Үүнтэй адил эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд насан туршдаа суралцах үйл явц юм. Эмч мэргэжилтнийг бэлтгэх тогтолцоог дэлхий нийтээрээ нэгэн хэв

маягаар явуулах биш харин улс орон, анагаахын сургуулиуд өөр өөрсдийн онцлог хэв маягийг харгалзан сайн иргэнийг бэлтгэхийг илүүд үзэх болжээ. Мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх дээд боловсролын тогтолцоонд төр засгийн бодлого шийдвэр, шинжлэх ухаан үйлдвэрлэл, соёл, гэр бүл, нийгэм хамт олны оролцоо нэн чухал. Боловсрол эзэмшсэн хүний амьдралын чанар ба нийгэмд эзлэх түүний байр суурь, боловсролын чанар ба төгсөгчдийн ажил эрхлэлт, боловсрол ба шинжлэх ухаан, боловсрол ба улс орны нийгэм, эдийн засгийн өсөлт хөгжилт, боловсрол ба эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт (боловсрол ба гэрлэлтийн нас, боловсрол ба гэр бүл дэх хүүхдийн тоо) гэх мэт. Эндээс харахад боловсрол судлал нь зөвхөн боловсролын салбарын, тэр дундаа сургалт эрхлэх сургуулиудын чиглэлийн эрдэмтдийн судалгааны хүрээгээр хязгаарлагдах биш (суралцагч, сургалтын сэтгэц судлал, агуулга, хөтөлбөр судлал, сурах бичиг, сургалтын арга зүй, үнэлгээ, сургалтын орчин...г.м.), харин одоо нийгмийн шинжлэх ухааны бараг бүх салбарын эрдэмтдийн оролцоо бүхий өргөн хүрээний судалгаа, шинжилгээний үйлс болж байгаа байдал харагдаж байна. Учир нь боловсрол өнөөдөр нийт хүн амыг төрөхөөс нь насны эцэс хүртэл нь тасралтгүй хөгжүүлдэг, тухайн үеийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан нийгмийн амьдралын бүх хүрээг хамарч иргэнээ хөгжүүлж, төлөвшүүлдэг суурь шинжтэй институц боллоо^[9].

ЮНЕСКО-оос боловсролыг хөгжүүлэх 4-5 тулгуур ойлголт (мэдэх, суралцахуй, бүтээх, хүн болох, хамтран амьдрах) байдгийг тодорхойлсон байна. МУ-ын Засгийн газар Мэргэжлийн дээд боловсролыг 1996-2030 онд хөгжүүлэх зорилтыг 3 үе шаттайгаар тодорхойлж Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл нь эрдэм боловсрол болохыг МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар 2020 онд баталсан ажээ.

Аливаа орны боловсролын системд хийгдэж байгаа өөрчлөлтийн эх сурвалж, хөдөлгөгч хүч нь нийгэмд гарч байгаа боловсролын шинэ эрэлт хэрэгцээ түүнийг урьдчилж ухаарч мэдэрсэн хүмүүсийн оюун санаанд гарч байгаа шинэлэг үзэл санаа байдаг^[10].

МУ-д эмч бэлтгэх сургалтыг Уламжлалт АУ-ны, ЗХУ-ын, Европ болон АНУ-ын хэв маягуудтай харьцуулан эргэцүүлж үзсэний үндсэн дээр Монголын үндэсний эрдэм соёл, уламжлалд үндэслэсэн өөрийн онцлог бүхий загварыг монгол эрдэмтдийн оюун ухаанаар бүтээсэн болно. Оюутанд хүн болох ухаан буюу амьдрах ухаанд суралцуулсны үндсэн дээр эмч мэргэжил эзэмшүүлэхийн чухлыг онцгойлох болсон. Манай төгсөгчид бие даасан хараат бус сэтгэхүйтэй, манлайлагч, сайн иргэн байх ёстой хэмээн тодорхойлсон. АУБ судлаач эрдэмтэн профессор багш нар “Монгол үндэсний үзэл баримтлалд суурилсан эмч бэлтгэх сургалтын загвар” хэмээх



номыг бүтээсэн нь чухамдаа МУ-д эмч бэлтгэх тогтолцоог өөрийн орны онцлогтой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал хэмээн онцолж байна. Манай судлаач эрдэмтдийн дэвшүүлж байгаа үзэл баримтлал нь “Тэгш дүүрэн” гэх загварт суурилсан болно.

Амьдрах ухаанд суралцахуйн үндэсний жишиг загварыг боловсруулах үндэслэл

Хүн төрөлхтний хөгжлийн түүхийн аливаа хөгжил дэвшил өнгөрсөн, одоо, ирээдүйн хэлхээн, дотоод мөн чанар, гадаад дүр төрхийн зохистой нэгдэл, дэвшилтэт болон уламжлалт соёл, зан заншлын харилцан уялдаанд урагшлан хөгжсөөр иржээ. Эх газрын эрс тэс уур амьсгал бүхий 4 улиралд, тэр тусмаа монголчууд газар зүйн янз бүрийн бүс нутагт байгаль дэлхийнхээ зан араншинд хүн, малтайгаа зохицон нийцэж амьдарсаар ирсэн. Нэг ёсондоо хорвоо ертөнцийн түгээмэл хуулийг өдөр тутмын амьдрал ахуйдаа хамгийн бүтээлчээр хэрэглэж, хамгийн энгийнээр, хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүйгээр аж төрсөөр ирсэн ард түмэн юм. Амьдрахуйн цөлх ухааны хүчээр ийнхүү мянга мянган жилээр оршин тогтносон хэрэг. Үеэс үед амьдралын арга ухаан нь нарийсан боловсорч, түүнийгээ ном сударт бичин сан хөмрөг болгон хадгалахаасаа илүү ой санамждаа хадгалах арга зам нь илүү ихээр хөгжсөн байдаг. Монгол хүн бол Монгол Улсын юугаар ч зүйрлэшгүй гол баялаг мөн. Он тооллын уртын урт замыг туулж, байгаль, экологийн болон соёл иргэншлийн асар хүнд шалгуурыг давж, нүүдэлч малчин удмаа ч, Монгол гэсэн гал голомтоо ёс сахин хадгалсаар ХХ зуунтай золгосон. Тэд хүн байхуй, монгол гэр бүлийг авч явахуй, нэгдсэн эзэнт Монгол улсыг байгуулах, төрийн ёсыг дээдлэн хүндлэхүй, ахчлах дүүчлэх дэг горимыг эрхэмлэхүй, монгол хэл бичиг, соёл, уламжлалын зүй жамыг тогтоохуй, үр хүүхэд, үе удмаа сурган хүмүүжүүлэхүй, эрдэм оюуныг шүтэхүй, хүн, малын эрүүл энхийг сахих, эмгэгийг анагаахуй, хувцас хунар, хоол хүнс, гэр орноо үйлдвэрлэхүй, спорт тоглоом наадмыг зохион бүтээж бие бялдрыг хөгжүүлэхүй, дуу хуур, бүжгийн монгол аялгуу, хөдөлгөөнөөр цэнгэхүй зэрэг амьдралын ухаалаг болоод баялаг хэв загварыг хүн төрөлхтний түүхэнд бүтээжээ (Ц.Балхаажав. 2016). Нүүдлийн соёл иргэншилтэй уялдан шавилан суралцахуйгаар оюуны шилдэг бүтээлүүд, амьдрах ухааны арвин их мэдлэг,

туршлагыг үеэс үед баяжуулан хөгжүүлж, түгээн дэлгэрүүлдэг байжээ. Шинийг эрэлхийлсэн хөгжлийн хөтөч нь эрдэм мэдлэгтэй, өндөр ёс суртахуун хүмүүжилтэй, эх оронч хүмүүн байдаг нь хүн төрөлхтний олон зуун жилийн түүхээр нотлогдсон билээ. Монгол хүн бие даан ажиллах чадвар өндөртэй, амьдрах арга ухаан сайтай, аливаа үзэгдлийг ажиглан таних, учир холбогдлыг харж олох гярхай нүдтэй, үзсэн харснаа ой санамждаа баримжаалан цэгцтэйгээр хадгалах, цээжлэн тогтоох ой ухааны чадвар сайтай хүмүүс хэмээн үзэх үндэстэй (Ц.Лхагвасүрэн. 2019). Монголчууд боловсрол олгох уламжлалт арга ухаанаа дорно дахины онол сургаалын үндсэн дээр буюу Буддист үзэл баримтлалыг үндэс болгон сурах, сургах тодорхой зарчмуудыг боловсруулсан байдаг. Хүний оюун ухааныг дээдэлж, бичиг үсгийн боловсролыг эрхэмлэх үзэл санаа нь Монголчуудын сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний нэг чухал ололт болно. Монголд олон зууны турш тасралтгүй үргэлжилсэн, уламжлалт соёлоо хадгалан хойч үедээ өвлүүлэн залгамжлуулах гол төв нь “гэрийн шавь сургалт” байж Монгол үндэстний соёл, зан заншил, эх хэл бичиг, урлаг утга зохиолын өв санг хадгалан хөгжүүлэх, хүүхдийг Монгол төлөвөөр нь хүмүүжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Орчин цагийн боловсрол түгэн дэлгэрэхээс өмнө Монгол оронд хүн ард, хүүхэд залууст “Гэрийн шавь сургалт” нь суралцагчдад дөрвөн аргын тоо, үндэсний бичиг үсгийн унших бичих дадлага чадварыг олгох зорилготой байв. Монголчуудын гэрийн сургуулийн сургалтын зохион байгуулалт нь аж ахуй эрхлэлтээ дагасан шинжтэй бөгөөд а/ өрхийн сургалт, б/ хот айлын сургалт, в/ саахалтын сургалт гэсэн харьцангуй ялгаатай байжээ. Өрхийн сургалт нь гэрийн сургуулийн хамгийн түгээмэл хэлбэр байж ихэвчлэн шавь нь багшийн гэрт очиж ном заалгах уламжлал нийтлэг байсан ч чинээлэг, язгууртан зарим өрхийн сургалтад гаднаас багш залж ирүүлэн хүүхдэдээ бичиг үсэг, ажил мэргэжил заалгах явдал байлаа. Хичээллэх хугацаа, цаг үе нь ямар ч байж болох ба сургалтын арга, зарчим нь ихээхэн нээлттэй, чөлөөтэй байхын зэрэгцээ суралцагч нэг бүртэй ганцаарчлан ажиллах боломжтой учраас үр дүн нь харьцангуй сайн байдаг. Хот айлын сургалтын хувьд хамрах хүүхдийн тоо арай олон бөгөөд тэдгээр айлын үе тэнгийн хүүхдүүдийг цуглуулан нэг багш хичээл заана. Харин зун болоход малчин

айлууд ойр саахалтаар зусаж аж ахуйгаа хамтран эрхэлдэг учраас саахалтын сургалт нь ихэвчлэн зуны цагт явагддаг. Уламжлалт сургуулийн зохион байгуулалтын хэлбэрүүд яваандаа нийгмийн хөгжлийг дагаад олон хэлбэр, хэв маягтай болж хөгжсөнөөр түр сургууль, дамжаа, гэрээт сургууль зэрэг хэлбэрүүд бий болжээ. Түр сургууль гэдэг нь бичиг үсэгт тайлах сургалт байсан бөгөөд хугацааны хувьд 3 сараас хэтрэхгүй, уншуулж сургахыг гол болгоно. Харин дамжаа нь ажил мэргэжил олгох зорилготой байсан бол гэрээт сургуулийн хэлбэр нь харьцангуй хожуу үед үүссэн, суралцагч ба сургагч нарын хооронд ам хэлцэл хийх, эсвэл бичгээр үйлдэн сургалтын хугацаа, үр чадварыг тохиролцон явуулах сургалт юм. Ийнхүү гэрийн шавь сургалт бол тусгай олон нөхцөл шаардахгүй, хамгийн хямд, сурах сургах хоёр хүний чин сэтгэл нийлсэн байх тул чанартай явагддаг байлаа. Монголчууд үр хүүхдээ бага балчир гэж ялгахгүйгээр хэр чинээнд нь таарсан энгийн хөдөлмөрт оролцуулан хөдөлмөрийн сайхныг багаас нь мэдэрүүлдэг байв. Хөлд орж алхах үеэс ойр зуурын зүйлийг зөөлгөж энд тэнд тавиулах, 3-4 насанд нь аяга шаазан угаалгах, хурга ишиг эргүүлэх, 5-6 наснаас нь хурга ишиг, тугал хариулах, аргал түүлгэх, айраг цагаа бүлүүлэх, даага унуулах зэрэг нүүдэлчдийн аж амьдралын нэн тэргүүний хэрэгцээт дадал чадварыг олгож ирсэн байна. Монголчууд ном эрдэмтэй хүн болох хүүхдийг багаас нь шинжин тогтоогоод гэрийн сургуулиар ном зааж ирсэн уламжлалтай. Хүүхдийн оюун билгийг нээгдүүлж, бичиг үсэг, ёс зүйн хүмүүжил сургах, баатарлаг зоригтой болгох, аж төрөх чадварыг олгох зэрэг хүмүүжлийн олон талтай аргыг бий болгосон. Аливаа хөдөлмөрийг хэрхэн гүйцэтгэхийг хий хоосон номлох биш харин өөрийн биеэр үзүүлж дагуулан дуурайлган сургадаг байсан нь монгол гэрийн хүмүүжлийн гол онцлог давуу тал байлаа. Монгол хүүхдүүд шаардуулж шавдуулахгүйгээр эцэг эх ахмад хүмүүсийг даган дуурайж хөдөлмөрлөсөөр амьдралын ухаанд суралцагч байжээ. Монгол хүний эрхэм сайхан чанарыг илтгэсэн хүнлэг энэрэнгүй, ахан дүүсэг, төлөв даруу, хөдөлмөрч хичээнгүй, зоригтой, намба ёсорхог, ухаалаг, уужим сэтгэл нь монгол ардын сурган хүмүүжүүлэх арга ухааны үр дүн юм. Буруу үйлийг жигшүүлж, цэвэрч нямбай байдалд сургахын хамт багаас нь зөв боловсон харьцаанд сурган, цээрлэх ёсыг таниулж ёс заншил

сургахын тулд аягаа зөв барих, хоол ундаа зөв идэж сурах, ах эгчээ авгайлах (гуайлах), худал хэлэхгүй байх, шударга ёсыг эрхэмлүүлэх, ахмад хүмүүсээс эмээх, тэднийг хүндэтгэх асрамжлах, дүү нараа асрах, хараалын элдэв үг хэлэхгүй байх, хүнийг муу хэлэхийг цээрлэх, томчуудын ярианд оролцохгүй байх, ахмад хүний урдур хойгуур гарахгүй байх, ирсэн гийчний морийг аргамжих, эмээлэж өгөх, зочны идээнээс авахгүй байх, ахмад хүн, ээж аавын үг сургаалыг авдаг байх, хүн орж ирэхэд цай аяглаж, идээ тавих, хэлдэг хэлдэггүй үгийг ялгах, мал адгуустай ширүүн харьцахгүй, хооллож услах, зэл, гадас, уурга зэргийн дээгүүр алхаж гишгэхгүй байх зэрэг арга ухаанд сургадаг. Улмаар эрдэм мэдлэгийг баяжуулж, оюуныг хөгжүүлэхийн тулд үлгэр домог, зүйр үг, хэл зүгшрүүлэх үгийг тогтоолгох, зөв хэлүүлэх, малын зүсийг нүдлүүлж өнгө мэдүүлэх, тоо тоолуулах, цээжээр тоо бодуулах, бичүүлэх, уншуулах, байгалийн зүй тогтол болон мал амьтны ааш зангаар цаг агаарыг шинжих ухааныг эзэмшүүлж байв. Монгол Улсад эрт дээр үеэс хөгжиж ирсэн уламжлалт оношилгоо, эмчилгээ нь өвөг дээдсийн олон зууны баялаг туршлагыг хуримтлуулсан, арга ухааны охь дээж нь юм. Монгол Төвөд анагаах ухааны мэдлэг дадлагад суурилсан оношилгоо, эмчилгээний арга засал, түүний дотор эмийн бэлдмэлийн арвин их сан, эмчилгээний онцгой, өвөрмөц аргуудын зүй зохистой баялаг туршлагуудыг уламжлуулсаар бидний үед иржээ. Монгол эх нутаг маань мал аж ахуйн орон учраас амьтныг анагаах ардын арга ухаан өргөн дэлгэрсэн нь хүн эмнэлэг хөгжихөд дөхөм байсан. Монголчууд нүүдлийн соёл иргэншилтэй, байгальтайгаа ойрхон амьдарч байсан хийгээд эрдэс, амьтан, ургамлын гаралтай эмийг гайхалтай онож олж хэрэглэж амжилтад хүрч, арвин туршлага хуримтлуулсан ард түмэн. Орчин үед уламжлалт анагаах ухааныг өрнийн анагаах ухаантай уялдуулан, зохистойгоор зэрэгцүүлэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байна. Анагаах ухааны чиглэлээр дээд боловсролын үйлчилгээ үзүүлж буй сургалтын байгууллагын өмнө их сургуулиа төгсөн, эмч эмнэлгийн мэргэжилтэн болон гарч буй төгсөгчид өнөөгийн эрүүл мэндийн салбарын хэрэгцээ шаардлагыг хэр хангаж байна вэ гэдэгт байнга анхаардаг. Сайн мэргэжилтэн байхын зэрэгцээ амьдрал хэрхэн хөлөө олж байна, хамт олонтойгоо хэрхэн нийцтэй ажиллаж байна, хүмүүжил төлөвшил

ямар түвшинд байна, ёсзүй, ёс суртахууны хэм хэмжээг хэрхэн сахиж ажиллаж байгаа бол гээд олон зүйлд бид санаа тавьдаг. Ялангуяа даяаршил, тасралтгүй төгөлдөршил, ухаалаг технологийн үсрэнгүй хөгжлийн эринд, тогтворгүй, тодорхойгүй, төвөгтэй орчинд мэргэжилдээ дур сонирхолтой ажиллаж, хүн ардын эрүүл энхийн манаанд өргөсөн тангарагтаа үнэнч зогсохын зэрэгцээ өөрсдийн амьдралаа хэрхэн авч явж байна, аз жаргалтай амьдарч байна уу, монгол өв уламжлал, соёл, зан заншлаа улам баяжуулан хөгжүүлж, үрс хойчоо эх оронч, шударга үнэнч, хөдөлмөрч, бүтээлч иргэд болгон хүмүүжүүлж чадаж байна уу зэрэг олон асуудалд санаа тавин ажиллаж байна. АШУҮИС-ийн 80 жилийн түүхэнд хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын хөтөлбөрөөр оюутны хөгжилд тал бүрээс анхаарч ирсэн баримт олонтой.

Ирээдүйн эмч мэргэжилтнийг амьдралд, ажил бэлтгэхээс гадна “Оюутан залуусыг эх орондоо хязгааргүй хайртай цаг ямагт урагш тэмүүлж насан турш тасралтгүй суралцан, ард олныхоо эрүүл мэндийг сахин хамгаалах их үйлсэд биеийн хүч, мэргэжлийн чадвар, сэтгэлийн хайр, энэрэхүйн дээд бүхнээ зориулах үзлийг төлөвшүүлэхийн төлөө” бүхий л багш сурган хүмүүжүүлэгчид онцгой анхаарч ажиллажээ^[3].

Оюутан суралцагчийг ажил, амьдралд бэлтгэхэд чухалчлан анхаарч АУДС-д элсэгчдийг “Асрагчийн дадлага” бүтэн жил хийлгэж байхаар шийдвэр гарч 1990-ээд оны дунд үе хүртэл үргэлжилсэн. Их дээд сургуульдээрх бүхий л үйл ажиллагаа, суралцагчийн оролцож буй аливаа хичээл, дугуйлан, сургуулийн орчин тэр чигтээ ёс суртахууны төлөвшил олж авдаг гол газар. Ийм ч учраас тус их сургуулийн оюутны сурлага, хүмүүжил, сахилга, хамт олны соёл, хөдөлмөрийн чиглэлээр хийж гүйцэтгэж байсан ажил, үйл ажиллагаатай уялдуулан дараах шалгуур үзүүлэлтээр үнэлдэг байсан байна.

Анагаах ухаанд суралцан, профессор багш нарын зааж сургаснаар түмний хайр хүндэтгэлийг хүлээсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн болохын зэрэгцээ амьдрах ухаанд давхар суралцах нь өнөөгийн оюутан бүрийн үүрэг юм. Амьдрах ухааныг бид ухаант ардаасаа, мэргэдийн үг сургаал, бүтээл туурвилаас, эрдэмтэн багш нар, хамтран суралцагчдаасаа суралцдаг. Өндөр боловсролтой хүн бүхэн ухаантай гэсэн үг огт биш. Мэдлэг амьдрах ухаан хоёр тэс өөр зүйл. Тодорхой

чиглэлээр эзэмшсэн мэдлэг, ур чадвар ажил эрхлэн, амьдрал ахуйгаа дээшлүүлэхэд хэрэгтэй, харин амьдрах ухаан бол алдахгүй амьдрахад тус болно. Мэргэжлийн чадвартай, боловсролтой ч амьдралдаа алдаж олон, аз жаргалтай амьдрах боломжоо алдах нь энүүхэнд. Анагаахад олон жил суралцан эзэмшсэн мэдлэг, чадварыг баялаг болгон хувиргах, хамт олонтойгоо эвсэг, тэдний хайр хүндлэлийг татан, сэтгэл өөдрөг ажиллах, улмаар үр хүүхдээ аз жаргалтай, эх оронч иргэд болгон хүмүүжүүлэхэд ухаан тусалдаг. Дэлхийн анагаах ухааны сургуулиудын сургалтад суурь болон хэрэглэгдэж буй CanMed-ийн зарчмуудыг үндэслэн АШУҮИС өөрийн төгсөгчдийн заавал эзэмшсэн байх цогц чадамжийн жагсаалтыг боловсруулсан гаргасан бөгөөд түүнд төгсөгч бүр идэвхтэй харилцагч, чадвартай хамтрагч, манлайлагч, эрүүл мэндийн зөвлөгч, тасралтгүй суралцагч байхыг анагаахын мэргэжилтэн байхтай эн тэнцүү авч үзсэн. Сургалтын нэгдмэл хөтөлбөрийг хэрэгжүүлж, эмч бэлтгэх сургалтын арга технологид үсрэнгүй өөрчлөлт гарсан бөгөөд үүнийг дагаад шинэ зууны иргэнийг давхар төлөвшүүлэх шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Иймээс өмнө нь явагдаж байсан хүмүүжлийн ажлыг чанарын шинэ түвшинд гаргах, XXI зууны монгол улсын иргэнийг хүмүүжүүлэн өсгөх амаргүй зорилт урган гарсан юм. Бусад орны туршлагаас харахад хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаагаар тухайн улс орон, үндэстний уламжлал, өв соёл, зан заншлыг оюутнуудад таниулан сурталчилж, эх оронч иргэн болон төлөвшүүлэхэд анхаарч байна.

Японы их дээд сургуулиуд клуб, дугуйлан, кендо, жүдо, айкидо, карате гэх мэт үндэстний спорт, цайны ёслол садо, уран бичлэг калиграфийн шодо, цэцгийн урлагийн кадо зэрэг арга хэмжээгээр соёл, уламжлал, зан заншлаа сурталчилж, оюутнуудыг төлөвшүүлж байна. Энэ бүхэнд ахмадаа хүндэтгэх зарчим хатуу үйлчлэх бөгөөд тэднийг семпай гэж нэрлэн үүрэг даалгаврыг нь үг дуугүй даган биелүүлдэг, семпай нар нь ч үлгэр дуурайлал үзүүлдэг.

АНУ-ын Харвардын их сургууль спортын 42 багтай бөгөөд спортын арга хэмжээнд нийт оюутны 80 гаруй хувь нь хамрагддаг. Хөгжил, урлаг, сэтгүүл зүй, нийгмийн үйлчилгээ, олон улс, жүжиг, бүжиг, улс төр, мэргэжил, соёлын чиглэлээр оюутны өөрийн 450 гаруй байгууллага тус их сургуулийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг

байна. Түүнчлэн агаар, арми, тэнгисийн цэргийн бэлтгэл офицерын сургалтыг эрхлэн явуулдаг ба тэр нь нийтийн албанд ажилласан жилд тооцогддог. Эдгээр бүх үйл ажиллагаагаар оюутан суралцагчдын хөгжил төлөвшилд нөлөөлөн, тэднийг эх оронч иргэн болгон хүмүүжүүлэхэд их дээд сургуулиуд өөрсдийн хувь нэмрээ оруулдаг байна.

Хүний ихэмчийн мэргэжил эзэмших ээртөгсөлтийн өмнөх сургалтын “Анагаах ухаан” хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудыг амьдрах ухаанд сургах ажлыг академич Ц.Лхагвасүрэн, профессор Н.Сүмбэрзул, дэд профессор О.Болорсайхан нарын зэрэг эрдэмтэн судлаачид, багш нар 2019 оноос эхлэн санаачлан, АШУУИС-ийн захирал профессор Н.Хүрэлбаатар болон удирдлагын баг тэрхүү санаачилгыг сайшаан дэмжиж бодит ажил болгосон. Тэдгээр эрдэмтдийн дэвшүүлсэн Оюутныг амьдрах ухаанд суралцуулах “Тэгш дүүрэн” үндэсний жишиг загварыг АШУУИС-д хэрэгжүүлж эхлээд байна.

“Хүний эрдэмд сурсан хүнд номын эрдэм зааж өг” гэсэн мэргэдийн сургаалыг үндэслэн эрдэм боловсрол олгодог монгол үндэсний арга ухааныг уламжлан манай их сургуулийн эрдэмтэн профессор багш нар суралцахуйн загварыг “гурвалжингаас тэгш дүүрэнд шилжих зарчим”-ыг баримтлан дараах байдлаар томъёолж байна.

Энэхүү загварын үндсэн дээр албан бус боловсрол, Оюутны хөгжлийн хөтөлбөрөөр “Амьдрахад суралцах” төдийгүй мэргэжлийн буюу анагаах ухаанд суралцаж хичээллэж байна.

“Тэгш дүүрэн” загварыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын албан хөтөлбөрөөс гадна хүмүүнлэг иргэний нийгмийн суурь чадварт суралцуулах нийгмийн сайн үйлсийн аян, судалгааны арга зүйд суралцуулах эрдэм шинжилгээ судалгааны ажил, олимпиад, төсөл хөтөлбөр, эрдмийн чуулган, гоо зүй, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох, төлөвшүүлэх соёл, урлагийн дугуйлан, спортын секц, уралдаан тэмцээн, хөдөлмөрч, бүтээлч иргэн болгон хүмүүжүүлэх цагийн ажил, хөдөлмөр, дадлага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод мөн түүнчлэн суралцагчдын өөрсдийн үүсгэл санаачлагчаар байгуулагдсан клуб, нийгэмлэгийн үйл ажиллагаа нь чухал үүрэгтэй болж байна.

Суралцахуйн “Тэгш дүүрэн” хэмээх үзэл баримтлал:

- Их сургууль нь сайн эмч мэргэжилтэн бэлтгэхийн сацуу тэднийг амьдрах чадвартай, хариуцлагатай, сайн иргэн болгон төлөвшүүлэх ёстой.
- Оюутан хүн анагаах эрдэмд шамдахын зэрэгцээ амьдрах ухаанд суралцах шаардлагатай.



Зураг 1. Анагаах ба Амьдрах ухаанд суралцах үндэсний жишиг загвар

Энэхүү жишиг загвараар оюутан суралцагчид маань анагаах ухаанд суралцахаас гадна амьдрах ухаанд суралцаж, их сургуульд элсэн орсон өдрөөсөө эхлэн эх оронч, эрүүлийг үлгэрлэгч, бүтээгч, тасралтгүй суралцагч, хүн байх, хариуцлагатай иргэн байх, хичээнгүйг төгөлдөржүүлэгч байх, сайн эцэг эх байх ухаанд суралцана. Амьдрах ухаанд хүн насан туршдаа суралцах бөгөөд АШУУИС-ийн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон түүний дараах сургалтуудад энэхүү жишиг загвар хамрах юм. Амьдрах ухаанд суралцах нь анагаах ухаанд суралцахаас хавьгүй өргөн ойлголт бөгөөд тэр бүгдийг өөртөө багтааж байдаг^[10].

Суралцах бүхий л хугацаандаа академик сургалтын зэрэгцээ хүний эрдэмд суралцахыг эрхэм болгосон юм. Оюутан өөрийгөө хөгжүүлэх, зорилготой, мэдрэмжтэй, овсгоотой, эрэл хайгуулч байх зэрэг чадваруудыг эзэмших нь онцгой чухал. Оюутан, багш, судлаачид хамтдаа хөгжинө, хамтдаа суралцана, гэдэг нь Их сургууль хөгжинө, эх орон гэсэн үг.

Монголын буддын их, бага 5 ухаан бол хүнийг гэгээрүүлэх зорилготой байсан хэмээн үзвээс зохилтой. Энд буддын шашныг дэмжих тухай яриагүй. Амьдрах ухаан, гэгээрэх ухаан, шинжлэх ухааныг зөв зохистойгоор эзэмших нөхцөл бололцоог олгох явдал бол манай боловсролын бодлогын нэг чухал чиглэл байх ёстой болоод байна. Монголын боловсролд ялангуяа хөдөөгийн сургуульд хүүхдийг сургахын зэрэгцээ хөдөө орон нутгийн ажилд оролцуулах, байгаль дэлхий, нүүдлийн аж ахуй, соёл, уламжлал, зан заншил зэрэгтэй танилцах боломжоор хангаж амьдрах ухаанд давхар сургаж шаардлагатай байсан.

Шинэчлэл, хөгжил гэдэг нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн хэлхээсэнд эргэцүүлэн санаж, дүгнэлт хийж, алдаанаасаа суралцаж, хийж бүтээсэн амжилтаа үргэлжлүүлэн аливаа зүйлд өргөн цар хүрээтэйгээр сэтгэж, хандаж, амьдрахыг хэлдэг. Агуу сэтгэгч В.Инжиннааш “Үндсээ үл мэдэх нь адгуус буюу, өвөг юугаа үл мэдэх нь мал буюу, нүд бий бөгөөтөл түүх юугаа үл мэдэх нь сохор номин буюу, мэдэлтэй оюун ухаан бөгөөтөл язгуур юугаа үл мэдэх нь мунхаг буюу” гэсэн байдаг.

Чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн төдийгүй монгол хүний үнэт чанарыг шингээсэн тийм

иргэнийг төлөвшүүлэх нь чухал болж байна. Монголчуудын бий болгосон мэдлэг ухаан, түүх, соёл, шашин, зан заншил, ёс суртахууны мэдлэг ухааны язгуур нийлбэр цогцсыг Монгол хүний үнэт зүйл хэмээн үзэж байна. Монгол хүний үнэт зүйл (үнэлэмж)-ийн агуулга

- Эх хэлний үнэлэмж (Монгол хүн хэчнээн олон хэл сурч, хэчнээн хугацаанд харь оронд амьдарлаа ч монгол хэлээ үл мартаж, үр хүүхдэдээ сургах)
- Эх түүхийн үнэлэмж (Монгол хүн бүр эх орныхоо түүхийг сонирхох, судлах, бахархах эрмэлзэлтэй байх, ураг удам, нутаг усныхаа түүхийг сурвалжлан бүтээх)
- Соёлын үнэт зүйл (Монгол хүний бүсдаас ялгарч буй хэв шинж, өвөрмөц эрхэм зүйл, аж төрөх ёс, мэдлэг ухаан бүхнээ мэдэрч хойч үедээ өртөөлөн үлдээх)
- Ёс заншлын үнэлэмж (Мэндлэх, хүндлэх ёс, найр наадам, цагаан сар, хурим найрын зэрэг ёс заншлаа өвлөн үлдээх, өртөөлөн дамжуулах)
- Буддын гүн ухааны ёс суртахууны үнэлэмж (үйлийн үрийн төлөөсгүй байх)

Энэ хүрээнд ерөнхий боловсролын түвшинд хөтөлбөрийн шинэчлэлийг хийж буй бөгөөд тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна. Ерөнхий боловсролын сургуульд 2019 оноос эхэлсэн Иргэний ёсзүйн боловсрол хичээлээр (1-12-р анги)

- Бага боловсролын түвшинд монгол хүн болж төлөвших (өөртэйгөө ажиллах)
- Суурь боловсролын түвшинд Монгол иргэн болон хүмүүжих (бусадтай харилцах)
- Бүрэн дунд боловсролын түвшинд Эх орныхоо эзэн монгол хүн болсон байх (эх оронч үзэл, хүмүүжилтэй болсон байх) зорилгыг дэвшүүлсэн байна.

Техник технологи аж үйлдвэрийн хурдтай хувьсал өөрчлөлт, нийгмийн хэрэгцээ шаардлагаар хүн бүр л хөгжиж дэвжихийг хүсэж буй энэ дижитал хөдөлмөрийн эрин үед хамгийн үнэ цэнтэй, үнэт зүйл бол хүний эрүүл мэнд байдаг. Тухайн улс орны хөгжил нь эрүүл мэндийн салбарт ажиллаж буй мэргэжилтэн, тэднийг бэлтгэж буй сургууль, багш нарын олон жилийн нөр их хөдөлмөртэй шууд холбоотой юм. Анагаахын эрдмээс суралцаж

буй оюутан бүр бие махбод, сэтгэл санаа, оюун ухаан, төрөлх чадавх тодорхой эрч хүчтэй байдаг. Тухайн их сургуульд суралцагсдын төрөлх чадавх нь улс орны хөгжилд үнэлж баршгүй үнэт зүйл, баялаг капиталыг бий болгодог.

Ахмад эрдэмтэн Х.Балхаажав гуай “Хүн болж төлөвшихийн 4 суурь ойлголт байдаг. Хүнтэй хөдөлмөр, мэдлэг, соёл, хүмүүжил дөрөв салшгүй хамт төрдөг. Энэ дөрөв цуг л байх хэрэгтэй аль нэг нь л дутагдахад өв тэгш байх боломжгүй. Хөдөлмөр нь аж төрөхийн гол арга хэрэгсэл, мэдлэг гэдэг нь ухаарлын жолоо, соёл гэдэг нь гоо зүй сайн сайхны чиг баримжаа, хүмүүжил гэдэг зөв буруугийн залуур. Энэ 4 нэгдмэл байж өв тэгш байна, аль нэг нь доголдоход өв тэгш байх боломжгүй. Үл мэдэхээс мэдэх, мэдэхээс чадах, чадахаас бүтээх, бүтээхээс хөгжих гэдэг ийм жамыг дагаж явдаг. Аль нэгийг алгасаад хийх боломжгүй. Хүүхдийг ийм логик сэтгэлгээнд заавал сургах хэрэгтэй.” хэмээн өгүүлсэн нь өнөө ч үнэ цэнтэй юм^[11].

Мэргэжилтэн бэлтгэх бакалаврын боловсролын хөтөлбөр нь дараах гурван зүйлд багтана.

1. Хувь хүн болон нийтлэг үнэт зүйл, хандлага төлөвшилийг гол болгосон “ҮНЭТ ЗҮЙЛ”-Д СУУРИЛАХ
2. Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хэмжигдэхүйц тодорхойлсон, хэрэгжүүлэх агуулга, арга зүй нь үнэлгээ нь “ҮР ДҮНД СУУРИЛСАН” байх
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тасралтгүй, уялдаа холбоотой, уян хатан, нээлттэй, хүртээмжтэй, сонгох боломжтой, бие даан суралцахуйг бүрэн дүүрэн дэмжсэн СУРАЛЦАХУЙ-д суурилна гэж заасан байдаг. Үүнийг хувь хүний хүсэл сонирхол, хэрэгцээндээ нийцүүлэн боловсрол эзэмшүүлэх, мөн суралцагчийн хэрэгцээ, хүмүүний тулгамдсан асуудал болон үйл хэрэгт үндэслэх ёстой.

“Амьдралд суурилж суралцахуй”-д багш, оюутан бэлтгэгдсэнээр Эрүүл мэндийн салбарт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж, хүн ардын Эрүүл мэндийн чанарт онцгой өөрчлөлт гаргана гэдэгт эргэлзэхгүй байна.

Ном зүй

1. З.Зүмбэрэлхам, Ш.Сонинбаяр, Д.Өлзийбаатар. Монголын сүм хийдийн түүхэн товчоон.
2. Улаанбаатар хот. 2009 он. Эдмон ХХК-д хэвлэв. Ху. 310
3. Н.Бэгз. Боловсрол судлалын сургалтын байдал: Асуудал, шийдэл
4. Geoff Norman Medical education: past, present and future Perspect Med Educ. 2012 Mar; 1(1): 6–14. Published online 2012 Feb 7. doi: 10.1007/s40037-012-0002-7
5. Norman GR, Dore KL, Grierson L. The minimal relation between simulation fidelity and transfer of learning. Med Educ. 2012 (in press)
6. Teteris E, Fraser K, Wright B, McLaughlin K. Does training learners on simulators benefit real patients? Adv Health Sci Educ Theory Pract. 2011 (Epub ahead of publication).
7. Ericsson KA. Deliberate practice and the acquisition and maintenance of expert performance in medicine and related domains. Acad Med. 2004;79(10 Suppl):S70–81.
8. Hans Karle Global standards in medical education – an instrument in quality improvement. Medical education 11 July 2002, https://doi.org/10.1046/j.1365-2923.2002.01221_2.x
9. Altbach, P. (2003). American Accreditation of Foreign Universities: Colonialism in Action. International Higher Education, (32). <https://doi.org/10.6017/ihe.2003.32.7373>
10. Н.Бэгз. Монголын боловсрол судлал, 2023 он, хуудас 60
11. Х.Алтайсайхан, Д.Амарсайхан, Т.Алтанцэцэг, О.Болорсайхан, Ц.Лхагвасүрэн, Б.Оюунгоо, Д.Отгонбаяр, Н.Сүмбэрзул, Н.Хүрэлбаатар, Д.Цэрэндагва “Монгол үндэсний үзэл баримтлалд тулгуурласан эмч бэлтгэх сургалтын загвар” Улаанбаатар хот. 2023 он. Соёмбо ХХК-д хэвлэв. Хуудас 206-209.
12. Г.Гонгоржав. Монголчуудын эрдэм ухааны уламжлал. УБ., 1994.
13. О.Болорсайхан, Б.Батзориг, С.Мягмарчулуун, Д.Баярмаа, Д.Хишигтогтох “Монгол улсын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлт” УБ., 2023.

АНАГААХЫН БИОЛОГИЙН ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

Ж.Ариунаа¹, Д.Болормаа², Э.Эрхэс¹, О.Пүрэв³ (Sc.D)

¹АШУУИС, СС, Ерөнхий Эрдмийн тэнхим

²АШУУИС, СС, Суурь Шинжлэх Ухааны тэнхим

³Боловсролын хүрээлэн

ariunaa.j@mnums.edu.mn

Товч утга

Сувилахуйн мэргэжлийн хичээлийн хөтөлбөр болон сурган заах арга зүйд анализ хийн олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрийн агуулга болон сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэсээр байгаа боловч сувилахуйн ангийн биологийн хичээлийн хөтөлбөрийн агуулга болон сургалтын арга зүйд үнэлгээ хийсэн судалгаа одоогоор байхгүй байна. Тиймээс сувилагч мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиудын биологийн хичээлийн агуулгыг судлан харьцуулах зорилго тавилаа.

Анагаах ухаан тэр дундаа сувилагч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын судлах ёстой чухал хичээлийн нэг бол биологи бөгөөд сувилахуйн тусламж үйлчилгээг эмчлүүлэгчдэд чанартай хүргэхэд биологийн шинжлэх ухаан нь сувилагчийн үндсэн гол суурь мэдлэг болж өгдөг (McKee G., 2002).

Хэдийгээр биологийн хичээл нь сувилагч мэргэжилтний мэдлэгийн суурь болж байдаг ч олон шинэ нэр томъёолол, уншиж цээжлэх материал их, хичээлийн мөн чанарыг өөрийн мэргэжил, эмчлэх, сувилах практиктайгаа холбож сайн ойлгоогүйгээс оюутнуудад хүнд, уйтгартай мэт санагдаж, улмаар энэхүү хичээлийн ач холбогдол буурдаг байна (Prokop P., 2007).

Манай улсад сувилахуйн ангийн биологийн хичээлийн хөтөлбөрийн агуулга болон сургалтын арга зүйд үнэлгээ хийсэн судалгаа одоогоор байхгүй байгаа бөгөөд хичээлийн агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх болон биологийн хичээлийг оюутнуудад илүү сонирхолтой, үр дүнтэй заах аргыг боловсруулах хэрэгцээ шаардлага байна.

Түлхүүр үг: биологи, сувилахуй, хөтөлбөр, арга зүй

Удиртгал

Биологи нь амьд биеийн үндсэн шинж, бүтцийн түвшин, эс ба хөгжлийн биологи, түүхэн хувьсах хөгжил, хүний үүслийн талаар судалдаг шинжлэх ухаан төдийгүй өчүүхэн жижиг атомоос эс хүртэл, генээс бүтэц хүртэл амьд организмыг судлах ба анагаах ухааны салбарт суралцаж буй оюутнуудын зайлшгүй судлах шинжлэх ухааны нэг байсаар ирсэн.

Анагаах ухаан тэр дундаа сувилагч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын судлах ёстой чухал хичээлийн нэг бол биологи бөгөөд сувилахуйн тусламж үйлчилгээг эмчлүүлэгчдэд чанартай хүргэхэд биологийн шинжлэх ухаан нь сувилагчийн үндсэн гол суурь мэдлэг болж өгдөг (McKee G., 2002).

Хэдийгээр биологийн хичээл нь сувилагч мэргэжилтний мэдлэгийн суурь болж байдаг ч олон шинэ нэр томъёолол, уншиж цээжлэх материал их, хичээлийн мөн чанарыг өөрийн мэргэжил, эмчлэх, сувилах практиктайгаа холбож сайн ойлгоогүйгээс оюутнуудад хүнд, уйтгартай мэт санагдаж, улмаар энэхүү хичээлийн ач холбогдол буурдаг байна (Prokop P., 2007).

Сувилахуйн мэргэжлийн хичээлийн хөтөлбөр болон сурган заах арга зүйд анализ хийн олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрийн агуулга болон сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэсээр байгаа боловч сувилахуйн ангийн биологийн хичээлийн хөтөлбөрийн агуулга болон сургалтын арга зүйд үнэлгээ хийсэн судалгаа одоогоор байхгүй байна. Тиймээс сувилагч мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиудын биологийн хичээлийн агуулгыг судлан харьцуулах зорилго тавилаа.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Судлагдсан судалгааны мэдээлүүдийг цуглуулан тэдгээрт тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан дүн шинжилгээ хийлээ.

Үр дүн

Биологи нь амьд биеийн үндсэн шинж, бүтцийн түвшин, эс ба хөгжлийн биологи, түүхэн хувьсах хөгжил, хүний үүслийн талаар судалдаг шинжлэх ухаан юм. Биологи нь өчүүхэн жижиг атомоос эс хүртэл, генээс бүтэц хүртэл амьд организмыг судлах ба анагаах ухааны салбарт суралцаж буй оюутнуудын зайлшгүй судлах шинжлэх ухааны нэг байсаар ирсэн. Америкийн Нэгдсэн Улс (АНУ) нь анагаахын сургуулиудын сургалтын хөтөлбөрт биологийн шинжлэх ухаан тэр дундаа генетик, удам зүйн талаар түлхүү оруулах нь хүн төрөлхтний тулгамдсан асуудлын нэг болох удамших гажуудыг урьдчилан тооцоолох, оношлох ба улмаар эмчлэх, анагаах асуудлыг генетикийн арга барилыг хэрэглэхгүйгээр анагаах ухаан дангаар шийдвэрлэх боломжгүй гэдгийг онцгойлон тусгасан байна. Мөн АНУ, Япон болон Солонгос зэрэг улс сувилахуйн сурах бичигт генетик, удам зүйн талаарх ойлголтын эзлэх хувийг үнэлсэн судалгаа хийхэд зарим сувилахуйн сурах бичигт генетик, удамшлын талаар огт тусгагдаагүй байна. Биологи нь анагаах ухаан тэр дундаа сувилагч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын судлах ёстой чухал хичээлийн нэг бөгөөд сувилахуйн тусламж үйлчилгээг эмчлүүлэгчид чанартай хүргэхэд биологийн шинжлэх ухаан нь сувилагчийн үндсэн гол суурь мэдлэг болж өгдөг (McKee G., 2002).

Сувилагч мэргэжилтний хувьд эмчлүүлэгчдэдээ үр дүнтэй тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд эмчлүүлэгчийн асуудлыг шүүмжлэлтэй, эргэцүүлэн бодох шаардлагатай. Хэрэв эмчлүүлэгч архаг өвчтэй байвал юун түүрүүнд тухайн өвчний үе шат хэрхэн явагдсаныг тооцоолох нь чухал. Тухайлбал: Цистик фиброз (CF буюу бие махбодоо цэвэрлэж чадахгүйн улмаас уушгинд өтгөн саалиа үүсгэдэг генетикийн өвчин юм) болон удамшлын зарим өвчний үед гэр бүлийн эрүүл мэнд, түүхийн талаарх цогц мэдээлэл цуглуулж, генетик, геномын талаар наад зах нь үндсэн ойлголттой байж, үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлд зөв зохистой мэдээлэл өгөх нь сувилагч мэргэжилтний ажлын салшгүй хэсэг юм (De Jesus., 2016).

Хэдийгээр биологийн хичээл нь сувилагч мэргэжилтний мэдлэгийн суурь болж байдаг ч олон шинэ нэр томъёолол, уншиж цээжлэх материал их, хичээлийн мөн чанарыг өөрийн мэргэжил, эмчлэх, сувилах практиктайгаа холбож сайн ойлгоогүйгээс оюутнуудад хүнд, уйтгартай мэт санагдаж, улмаар энэхүү хичээлийн ач холбогдол буурдаг байна (Prokop P., 2007).

Биологийн хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өнөөгийн сургалтын технологийн үндсэн чиглэл болсон оюутан төвтэй, тэдний оролцоонд суурилсан мэдлэг бүтээх арга барил, сургалтын арга зүйг хэрэгжүүлэх нь чухал юм. Тухайлбал: сүүлийн үед хамгийн өргөн ашиглагдаж буй асуудал суурилсан сургалтын загвар нь оюутан, тэдэнд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чадварт суралцаж. Харин орчин үед мэдээлэл технологи хөгжихийн зэрэгцээ, түүнийг сургаалтанд үр ашигтай ашиглах аргууд нэмэгдсээр байна. Иймд олон орны эрдэмтэд судлаачид биологийн хичээлийн заах арга зүйд анхаарч Гибрид асуудал суурилсан арга, подкаст зэрэг сургалтын аргыг сувилахуйн оюутнуудад биологийн хичээл заахдаа ашигласан нь илүү үр дүнтэй байгаа нь батлагдсан (Carriy M., 2011).

Мөн түүнчлэн 2003 японы эрдэмтэн Цүжино нарын судлаачид болон 2010 онд солонгосын эрдэмтэн Ким нарын судлаачид сувилагч мэргэжилтний бэлтгэдэг сургуулиудын биологийн хичээлийн агуулга болон сувилахуйн сурах бичгийн генетикийн эзлэх хувийг үнэлсэн судалгаа тус тус хийсэн ба уг судалгааны дүнгээр сувилахуйн үндсэн сурах бичигт биологи, генетик, удам зүйн талаарх ойлголт хангалтгүй байна (Tsujino K., 2013).

Дүгнэлт

Сувилахуйн мэргэжлийн хичээлийн хөтөлбөр болон сурган заах арга зүйд анализ хийн олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрийн агуулга болон сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэсээр байгаа боловч сувилахуйн ангийн биологийн хичээлийн хөтөлбөрийн агуулга болон сургалтын арга зүйд үнэлгээ хийсэн судалгаа одоогоор байхгүй байгаа бөгөөд хичээлийн агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх болон биологийн хичээлийг оюутнуудад илүү сонирхолтой, үр дүнтэй заах аргыг боловсруулах хэрэгцээ шаардлага байна.

Хэлцэмж

Сувилагч мэргэжлээр суралцагч оюутнууд биологийн шинжлэх ухааныг сувилахуйн практикт ашигласан үр дүнд дүн шинжилгээ хийнэ.

Сувилагч мэргэжлээр суралцагч оюутнуудын шинжлэх ухаанд суурилсан сувилахуйн мэдлэг чадварыг үнэлэх судалгааны хэрэгцээг тодорхойлно.

Ном зүй

1. McKee G. Why is biological science difficult for first-year nursing students?. *Nurse Education Today*. 2002 Apr 1;22(3):251-7.
2. De Jesus MP, Mitchel M. Today's nurses need genetics education. *Nursing2019*. 2016 Oct 1;46(10):68.
3. Prokop P, Prokop M, Tunnicliffe SD. Is biology boring? Student attitudes toward biology. *Journal of biological education*. 2007 Dec 1;42(1):36-9.
4. Carriy M, Larramona P, Bacos JE, Pйrez J. The effectiveness of the hybrid problem-based learning approach in the teaching of biology: a comparison with lecture-based learning. *Journal of Biological Education*. 2011 Dec 1;45(4):229-35.
5. Tsujino K, Tsukahara M, Frazier L, Iino H, Murakami K. Genetic content in Japanese language nursing textbooks. *Research and theory for nursing practice*. 2003 Dec 1;17(4):353-62.
6. Kim M, Han J. Genetic content in Korean nursing textbooks. *Nursing & health sciences*. 2010 Mar;12(1):135-41.
7. Andrew S, McVicar A, Zanganeh M, Henderson N. Self-efficacy and relevance of bioscience for nursing, midwifery and healthcare students. *Journal of clinical nursing*. 2015 Oct;24(19-20):2965-72.
8. Friedel JM, Treagust DF. Learning bioscience in nursing education: perceptions of the intended and the prescribed curriculum. *Learning in Health and Social Care*. 2005 Dec;4(4):203-16.

THE LESSON OF MEDICAL BIOLOGY RESEARCH ON TEACHING METHODOLOGY

Abstract

The curriculum and teaching methods of the nursing profession are analyzed and the content of the program in accordance with international standards and innovative teaching methods are still used, but there is no research that evaluates the content and teaching methods of the biology curriculum of the nursing class. Therefore, we set a goal to study and compare the content of biology courses in schools preparing nurse specialists.

Biology is one of the important subjects to be studied by students studying medicine, especially nursing, and biological science is the main basic knowledge of nurses to provide quality nursing care to doctors (McKee G., 2002).

Although the biology course is the basis of the knowledge of a nurse specialist, there are many new terms, a lot of reading and memorizing material, and the nature of the course is not well understood in relation to their profession, treatment and nursing practice, so students feel it is difficult and boring, and thus the importance of this course decreases (Prokop P., 2007).

In our country, there is currently no research evaluating the content and teaching methods of the biology curriculum of the nursing class, and there is a need to bring the content of the course in line with international standards and to develop a more interesting and effective way to teach biology to student.

АНАГААХЫН БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ СУУРЬ ЭРДМИЙН СУРГАЛТАД ОЮУТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ

*Л.Нямаа, Г.Ганширмэн, Д.Эрдэнэчимэг, Б.Ундармаа, Л.Отгонтөгс
АШУУИС-ийн Говь-Алтай АУС*

Судалгааны ажлын үндэслэл

Боловсролын салбарын үйл ажиллагаа, боловсрол олгох үйл явц нь аливаа улс, үндэстний нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгуур хүчин зүйлийн нэг юм. Багш бол боловсролын үйл явцад нөлөөлөх үндсэн субъектийн нэг тул бүх түвшний боловсролын байгууллагуудын хувьд багшийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд тэдгээрийн үйлчлүүлэгчдээс тасралтгүй сэтгэл ханамжийн судалгаа авч сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанарт үнэлгээ өгч сайжруулах арга замыг оновчтой сонгон ажиллахад чиглэсэн бодлого, шийдвэрийг гаргах асуудал цаг ямагт шаардагдсаар байна. Бүх шатны боловсролын байгууллагын хувьд боловсролын бодлогыг амжилттай хэрэгжүүлж, зорилтот түвшинд хүрэхийн тулд ажилдаа сэтгэл ханамжтай, үүргээ өндөр түвшинд гүйцэтгэх чадвартай, хүсэл эрмэлзэлтэй, тууштай багш нар шаардлагатай. Үүний тулд бид оюутны сэтгэл ханамжийг багшийн зүгээс хэрхэн бүрдүүлж буйг судлах зорилгоор заах ур чадвар, харилцаа хандлага, цаг ашиглалтын талаар судлахаар зорилоо.

Орчин үеийн багш нараас олон ур чадварыг шаардах болсон төдийгүй тэдгээрийг зөөлөн ур чадвар хэмээн нэрийдэж байна. Үүнд:

- Багшийн сурган хүмүүжүүлэх ур чадвар, эв дүй
- Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа амжилттай болох үндэс нь багшийн ажлыг зүрх сэтгэлээсээ хийх, суралцагчаа хайрлах зэргээр цаг ямагт хөгжиж байдаг урлаг юм хэмээн тодорхойлсон байдаг.
- Багшийн харилцаа хандлага
- Хамтран багаар ажиллах чадвар
- Зохион байгуулах чадвар
- Нөлөөлөх чадвар

- Тусгах ур чадвар
- Мэдээлэл ашиглах ур чадвар
- Медиа ашиглах ур чадвар
- Эргэцүүлэн бодох ур чадвар
- Дамжуулан шилжүүлэх ур чадвар зэргийг голчлон анхаарч байна.

Нэрт сурган хүмүүжүүлэгч А.С.Макаренко “Сурган хүмүүжүүлэх ур чадварын мөн чанар нь нь мэдлэг болон эв дүйгээр илрэн гардаг” хэмээжээ. Харилцааны ач холбогдол өнөө цаг үед улам ихэссээр байна. Учир нь харилцаа нь мэдээлэл дамжуулалтын гол арга зам юм (Karadag, 2009). Хүн бүр тодорхой хэмжээний харилцах чадвартай байх ёстой ч багш нар илүүтэй харилцах чадвараа хөгжүүлэх хэрэгтэй. Энэ бол багш нарын үүрэг. Багш нарын хувьд харилцаа гэдэг бол харилцан үйлчлэл юм (Virtic & Repnik, 2012). Багш хүн чухал шинж чанаруудыг өөртөө бүрдүүлсэн байх шаардлагатай. Багш хүн оюутан сурагчидтайгаа харилцах үед ардчилсан хандлагатай, хүлээцтэй, эелдэг, энэрэнгүй, тэсвэр тэвчээртэй, итгэл даадаг, хошин байвал зохино (Saka & Surmeli, 2010) хэмээн судлаачид үзэж байна. Үр дүнтэй сургах-багшлах арга зам нь харилцаагүйгээр хэрэгжих боломжгүй юм. Үр дүнтэй харилцахыг хүсэж буй багш нар оюутнуудын зан араншинг урьдаас тааж мэдэх чадвартай байх хэрэгтэй. Олон тооны оюутнуудын өмнө ярьдаг, харилцааг санаачлан тогтоогч гэдгээрээ мөн олон нийтийн зан араншинг ч мөн зална. Тиймээс багш нар өөрийн мэдрэмж, зөрчлөө зохицуулах шаардлагатай (Karadag, 2009). Харилцаа гэдэг нь Оксфордын толинд тодорхойлсноор бол “мэдээллийг хүргэх”, “мэдээ мэдээллийг дамжуулах шинжлэх ухаан, дадлага” ажээ. Багшлах гэдэг нь ч мөн адил байнга шинэ мэдлэг, мэдээллийг дамжуулахын нэр юм (Prozesky, 2000). Хюбли харилцааг нарийн төвөгтэй процесс

(Зураг 1) болохыг тодорхойлсон байдаг (Hubley, 1993).

Багшийн үндсэн ажил дараах төрөлд хуваагдахаар байна. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх ажил (50%-80%)
 - Хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, заах
2. Сургалтын үйл ажиллагааг дэмжих бусад ажил (20-50%)
 - Эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, суралцагчдын авьяас чадварыг дэмжин ажиллах.

Багш хүн ажлаа амжилттай явуулах гол үндэс нь цаг хугацааг зөв зохицуулах чадвар юм. Цаг хугацаа бол маш хязгаарлагдмал хөрөнгө, худалдан авч болдоггүй, хэмнэн дараагийн зорилгод хадгалан үлдээж болдоггүй, сунгаж мөн ихэсгэж болдоггүй, тасралтгүй үрэгдэж байдаг бөгөөд түүнийг эргүүлэн авчирч болдоггүй амьдралын үйл явц юм. Эрдэмтдийн судалгаагаар хүн амьдралынхаа 34%-ийг унтаж, 33%-ийг ажиллаж, 33%-ийг гэр бүлдээ зарцуулдаг гэсэн судалгаа байна. Цагийн менежментийн 7 зарчмыг мөрдөн ажиллах нь аливаа ажлыг гүйцэтгэхэд чухал билээ. Үүнд:

- Тэнцвэрийг хадгалах тухай хууль
- Өдрийн төлөвлөгөө
- 60:40-ийн дүрэм
- Эйзенхауэрын зарчим
- A-L-P-E-N арга
- Төгсгөлийн цэгээс харах зарчим
- Биохэмнэлийг эвдэхгүй байх явдал юм.

Бид их сургуулийн багшийн зарим үр чадварыг судлах үүднээс заах үр чадвар, харилцаа хандлага, цаг баримтлалын байдлыг судалж үзлээ.

Судалгааны зорилго

Анагаахын боловсролын ерөнхий эрдмийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж буй багш нарт өгөх оюутны сэтгэл ханамжийг тодорхойлох

Судалгааны зорилт

1. Багш нарын заах үр чадварт өгсөн сэтгэл ханамж
2. Багш нарын харилцаа хандлагад өгсөн сэтгэл ханамж
3. Багш нарын цаг баримтлалд өгсөн сэтгэл

ханамж

Судалгааны арга, аргачлал


- Судалгааг агшингийн аргаар хаалттай асуумжаар, Ликертийн үнэлгээгээр google forms-ашиглан 2022 оны 09 сараас 2023 оны 03 сарын хугацаанд авч үр дүнг excel болон SPSS-22 программ ашиглан гаргалаа.
- Судалгаанд АШУҮИС-ийн Говь-Алтай АУС-ийн 980 оюутны төлөөлөл болгож 7 мэргэжлийн ангийн 1-ээс 6-р дамжааны 260 оюутан хамруулж үр дүнг хувиар тооцон гаргалаа.

Судалгааны үр дүн

Суралцаг мэргэжил



Суралцаг курс





Дүгнэлт


АШУҮИС-ийн ГА салбар АУС-ийн ерөнхий эрдмийн хичээл зааж буй 10 мэргэжлийн багш нарын сургалтын үйл ажиллагааны заах аргад сайн-90%, дундаж-10% дундаж оноо-4,199, харилцаа хандлагад сайн-70%, дундаж-30% дундаж оноо-4,142, цаг баримтлалд сайн-100% дундаж оноо-4,196 өгсөн байгаа нь оюутнуудын сэтгэл ханамж энэхүү 3 багц асуумжид сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна.

Хэлцэмж


- Ц.Мягмарсүрэн. Багшийн ажлыг төлөвлөх зөвлөмж илтгэл. 2017. Багш нарын 85% нь цаг баримталж ажилладаг гэсэн судалгаа гарчээ. Бидний судалгаанд 100% сайн дундаж оноо 4,196 буюу 83,92%-ийн сэтгэл ханамжтай байгаа нь дээрх судалгаатай ойролцоо байна.



Харилцаа хандлага дундаж оноо



Багшийн цаг баримтлал



• Бид сургалтын чанарын хяналт, сайжруулалтыг тогтмол хийж ажилладаг ба 2011-2019 оны хооронд 207 удаагийн “ХАБЭА-н Ажилтныг мэргэшүүлэх” сургалт зохион байгуулж, нийт 3415 суралцагчаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байдаг. Тэдгээрээс зөвхөн сүүлийн 3 жилийн судалгааны дүнг нэгтгэн харвал нийт суралцагчдын 95.5% нь ОШМИ-гийн сургалтад Маш их (66%) болон Их сэтгэл ханамжтай (29.5%) гэсэн үнэлгээ өгсөн байна. Анагаахын мэргэжлийн ерөнхий эрдмийн сургалтад суралцагчид багш нарын заах арга, үр чадварт сайн үнэлгээ 90% нь өгсөн ба дундаж оноо 4,199 буюу 83,98%-ийн сэтгэл ханамжтай байгаа нь дээрх судалгаанаас бага зэргийн доогуур үзүүлэлттэй байна.

• Ч.Долгоржав. Б.Батчулуун. МУБИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2014. 188-193-р хуудас. МУБИС-ийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааг шинжлэх нь судалгаанд багшийн хичээл хэрэгцээ сонирхолд нийцдэг-44%, харилцаа хандлага сайн-64,3%, цаг ашиглалт-58,6% тай өгсөн байна. Бидний судалгаанд оролцогчид 82,84% нь харилцаа хандлага сайн, 83,92% нь цаг баримтлал сайн хэмээн үнэлсэн байгаа нь дээрх судалгааны үзүүлэлтээс сайн байна.

Судалгааны практик ач холбогдол

- Судалгааг сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх,
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах,

- Багш нарын ажлыг үнэлэх,
- Өөрийн сургуулийн багш нарын сургалтын сэтгэл ханамжийг бусад сургуультай харьцуулах зэрэгт суурь судалгаа байдлаар ашиглаж болно.

Ном зүй

1. Hubley, J. (1993). *Communicating Health*. London: Macmillan.
2. Karadag, E. &. (2009). *Interaction And Communication In The Process Of Education And Shared Common Area In The Classroom*. *College Student Journal*.
3. Prozesky, D. R. (2000). *Communication and effective teaching*. *Teaching Eye Health*.
4. Saka, M., & Surmeli, H. (2010). *Examination of relationship between preservice science teachers' sense of efficacy and communication skills*. *Innovation and Creativity in Education, Book Series: Procedia Social and Behavioral Sciences*.-Δ Istanbul.
5. Virtic, M., & Repnik, R. (2012). *Improving quality of the educational process by raising teachers' communication skills*. *Problems of Education in the 21st Century*.
6. Zakahi, W., & McCroskey, J. (1989). *Willingness to communicate: A potential confounding variable in communication research*. *Communication Reports*, 96-104.
7. МУБИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2014. УБ. №06.

АНАГААХЫН ОЮУТНЫ ЦАХИМ СУРГАЛТЫН ҮЕИЙН ХАНДАЛТ БОЛОН СУРЛАГЫН АМЖИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Б.Балжинням¹, М.Ундрам², С.Гал-Эрдэнэ¹, Б.Солонго², Н.Сүмбэрзул³, Б.Оюунгоо⁴

¹Багшийн хөгжил, цахим сургалтын газар, АШУУИС

²Анагаах ухааны сургууль, АШУУИС

³Эрдмийн сургууль, АШУУИС

⁴Сувилахуйн сургууль, АШУУИС

baljinniam@mnums.edu.mn

Товч утга

КОВИД-19 цар тахлын үед цахим сургалт эрчимжсэн боловч цаашид үр дүнтэй хөгжүүлэхийн тулд судалгаанд суурилсан байх хэрэгтэй. Бид цахим хэлбэрээр суралцсан анагаахын суралцагчдын цахим сургалтын системд хандалтын зарим үзүүлэлтийг сурлагын амжилтын үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Судалгаанд хөл хорионы үед цахим хэлбэрээр суралцсан 1462 суралцагчийн мэдээллийг ашигласан бөгөөд сурлагын амжилт, хандалтын тоог сургалтын системээс, байршил, ашигласан төхөөрөмж, интернэтийн төрөл, зарцуулсан хугацаа зэрэг үзүүлэлтийг асуумжийн аргаар цуглуулсан. Суралцагчдын системд хандсан хандалтын тоо нь сурлагын амжилтын үзүүлэлтүүдтэй шууд сул хамааралтай байдал ажиглагдсан. Цахим хичээлд ихэвчлэн төв суурин газраас, компьютер, суурин интернэт ашиглаж хандсан бөгөөд өдөрт дунджаар 3-6 цаг зарцуулсан байна. Сурлагын амжилтын үзүүлэлт ба системийн хандалт, технологийн хэрэглээний хооронд ач холбогдол бүхий хамаарал ажиглагдаагүй нь цаашид цахим сургалтыг ашиглан сургалтын үр дүнг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна. Сургалтыг цахим хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулахад суралцагчийн зүгээс технологийн өндөр хэрэгцээ шаардлагагүй байна.

Түлхүүр үг: Цахим сургалт, системийн хандалт, сурлагын амжилт, анагаахын оюутан

Удиртгал

Ковид-19 халдварын дэгдэлтийн улмаас Монгол

улс 2020 оны 1 сараас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж^[1], боловсролын байгууллагууд сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн ба сургуулиуд 59 долоо хоногийн хугацаанд хэсэгчилсэн болон бүрэн танхимын сургалтыг зогсоож, их сургуулиудын сургалтын үйл ажиллагаа үүнээс ч урт хугацаанд цахим хэлбэрээр явагдсан^[2]. Дэлхий дахинд Ковид-19 цар тахлын оргил үед бүх түвшний сургуульд суралцаж буй 1.4 тэрбум суралцагч дижитал боловсролын платформуудад суурилан гэрээсээ суралцсан байна^[3]. Цахим сургалтын үед олон их, дээд сургуулийн хувьд тулгамдаж буй гол асуудал сургалтын платформ, технологи болж байсан^[4]. АШУУИС-ийн хувьд 2003 оноос зайн сургалтын технологийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2007 онд цахим сургалтын системийг төгсөлтийн дараах сургалтад ашиглаж, 2015 онд Цахим сургалтын төв болон Олон улсын сайбер сургуулийг байгуулсан⁵ ба 2020 онд цар тахлын үед онлайн сургалтад шилжихэд бэлтгэлтэй байсан^[6]. Сургалтын дижитал хэлбэр нь үр дүнтэй, нөөц хэмнэсэн, оролцоотой сургалтын хэлбэр байх боломжтой ба дижитал формат нь суралцагчдын сурах сэдлийг нэмэгдүүлдэг байна^[7]. Зарим мета-анализ судалгааны үр дүнгээс харахад хосолсон сургалт нь мэдлэг, ур чадварын гүйцэтгэл, сургалтын сэтгэл ханамжийн хувьд уламжлалт танхимын сургалтаас илүү үр дүнтэй болохыг нотолсон байсан^[8]. Танхимын сургалттай цахим сургалтыг хослуулан сургалтын үр дүнг нэмэгдүүлэх боломж байгаа бөгөөд нотолгоонд суурилан хөгжүүлэх хэрэгтэй. Иймээс бид анагаахын төгсөх дамжааны суралцагчдын цахимаар суралцаж байх

үеийн системийн хандалттай холбоотой зарим үзүүлэлтийг сурлагын амжилтын үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааг цахим сургалтын үед хандалтын болон сурлагын амжилтын зарим үзүүлэлтийг корреляцийн шинжилгээ ашиглан хийж гүйцэтгэхийг зорьсон. Хандалтын үзүүлэлтүүдэд байршил, ашигласан төхөөрөмж, интернэтийн төрөл, өдөрт зарцуулсан хугацаа, техникийн асуудал тулгарч байсан зэрэг мэдээллийг, харин сурлагын амжилтын үзүүлэлтэд төгсөлтийн шалгалтын дүн болон голч дүнгийн мэдээллийг ашигласан. Судалгаанд нийт 2020-2022 онд Ковид-19 цар тахлын үед цахим хэлбэрээр суралцаж төгссөн 1462 оюутны мэдээллийг ашигласан ба шалгалтын дүн, голч дүн, хандалтын дундаж тоо зэрэг үзүүлэлтийг сургалтын системийн мэдээллийн сангаас өгөгдөл олборлох аргыг ашиглан баримтын аргаар, байршил, ашигласан төхөөрөмж, интернэтийн төрөл, зарцуулсан хугацаа, техникийн асуудал зэрэг үзүүлэлтийг асуумжийн аргаар цуглуулсан. Статистик боловсруулалтыг SPSS 26, мэдээллийн нэгтгэл, хүснэгт дүрслэлийг Microsoft Office 2019 программ ашиглан хийж гүйцэтгэсэн.

Үр дүн

Судалгаанд нийт 2020 онд төгссөн 501, 2021 онд төгссөн 479, 2022 онд төгссөн 482 суралцагчийн мэдээллийг ашигласан.

Хүснэгт 1. Суралцагчдын сурлагын амжилтын мэдээлэл, төгссөн оноор

	Тоо (%)	Шалгалтын дүн±СХ	Голч дүн±СХ
2020 он	501 (34.3)	94.24 ± 1.91	2.97 ± 0.31
2021 он	479 (32.8)	98.56 ± 1.16	2.97 ± 0.29
2022 он	482 (33.0)	95.34 ± 1.45	3.06 ± 0.26
Нийт	1462	96.02 ± 2.4	3.00 ± 0.29

Төгсөлтийн мэдлэг үнэлэх сорилын шалгалтын онооны дундаж 96.02±2.4, голч дүнгийн дундаж 3±0.29 байна.

Хүснэгт 2. Суралцагчдын цахим хичээлд хамрагдсан хандалтын мэдээлэл

	Хувь	Хандалтын тоо (95% CL)
Хандсан байршил		
Улаанбаатар хот	62.2%	83.5 (79.3 ± 87.8)
Аймгийн төв	23.6%	69.7 (62.7 ± 76.6)
Сумын төв	11.1%	96.3 (85 ± 107.6)
Хөдөө	3.0%	85 (57.7 ± 112.3)
Гадаад	0.1%	-
Ашигласан төхөөрөмж		
Компьютер	56.0%	82.4 (78.2 ± 86.6)
Гар утас	41.9%	81.1 (75.1 ± 87.1)
Таблет	1.7%	90.6 (61.8 ± 119.4)
Бусад	0.4%	65.3 (13.4 ± 117.2)
Интернэтийн төрөл		
Дата	38.6%	79.1 (73.1 ± 85.1)
Утасгүй	14.6%	84.2 (75.8 ± 92.7)
Суурин	46.8%	83.3 (78.5 ± 88.2)
Зарцуулсан хугацаа		
1-2 цаг	6.8%	70.8 (58.2 ± 83.5)
3-4 цаг	39.2%	74.8 (69.5 ± 80)
5-6 цаг	36.4%	88.4 (82.7 ± 94)
7-8 цаг	13.2%	87.2 (76.2 ± 98.1)
9-10 цаг	3.8%	99.3 (81 ± 117.7)
10-с дээш	0.6%	87.5 (33.3 ± 141.7)
Техникийн асуудал		
Байнга	8.6%	88.5 (75.8 ± 101.1)
Хааяа	70.8%	83.7 (79.5 ± 88)
Огт үгүй	20.5%	73.5 (67.1 ± 80)

Судалгаанд оролцогчид цахим хичээлд ихэвчлэн Улаанбаатар хотоос (62.2%) суурин компьютер (56.0%), интернэт (46.8%) ашиглаж хандсан, цахим хичээлд өдөрт дунджаар 3-6 цаг (75.6%) зарцуулж байсан байна. Харин цахим хичээлд хандахад техникийн асуудал тулгардаг эсэх асуултад 8.6 хувь нь байнга, 70.8 хувь нь хааяа, 20.5 хувь нь огт үгүй гэж хариулсан байна.

Сурлагын амжилтын үзүүлэлтүүд болох төгсөлтийн шалгалтын дүн, голч дүнг хооронд хамааралгүй ($r=0.051$) байсан. Харин суралцагчдын системд хандсан хандалтын тоо болон голч дүн ($r=0.225$), шалгалтын дүн ($r=0.265$) сул хамааралтай байна. Интернэтийн болон ашигласан төхөөрөмжийн төрөл хоорондын хамаарал дунд зэрэг ($r=0.402$), төхөөрөмж болон байршил ($r=0.207$), интернэт болон байршил ($r=0.339$), асуудал болон байршил

Хүснэгт 3. Хандалт болон амжилтын үзүүлэлтүүдийн хамаарал

	ГД	ШД	СХ	ХБ	АТ	ИТ	ЗХ	ТХ
Голч дүн (ГД)	1							
Шалгалтын дүн (ШД)	0.051*	1						
Системийн хандалт (СХ)	0.225**	0.265**	1					
Хандсан байршил (ХБ)	0.015	0.046	0.010	1				
Ашигласан төхөөрөмж (АТ)	0.064*	0.099**	0.007	0.207**	1			
Интернэтийн төрөл (ИТ)	0.024	0.024	0.030	0.339**	0.402**	1		
Зарцуулсан хугацаа (ЗХ)	0.077**	0.027	0.110**	0.030	0.017	0.055*	1	
Техникийн асуудал (ТХ)	0.024	0.123**	0.071*	0.266**	0.168**	0.341**	0.041	1

** - $p < 0.01$, * - $p < 0.05$

($r=0.266$), асуудал болон интернэт ($r=0.341$) зэрэг үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал сул байгаа нь ажиглагдлаа.

Хэлцэмж

Ковид-19 цар тахлын үеийн цахим сургалттай холбоотой судалгаанууд маш их хийгдсэн байна. Арабын Нэгдсэн Эмират Улсын их сургуульд суралцаж буй оюутнуудын дунд цахим сургалтын орчин сурлагын амжилтад нөлөөл буй эсэхийг тодорхойлсон судалгаа хийсэн ба судалгааны үр дүнд цахим сургалтын орчин, дижитал бэлэн байдал, академик оролцоо, суралцагч, багш нарын цахим сургалтын хандлага зэрэг нь оюутны сурлагын амжилтыг тодорхойлдог чухал хүчин зүйл болохыг нотолсон байна⁹. Пакистаны их сургуулийн оюутнуудын дунд цахим сургалтын сэтгэл ханамж болон сурлагын амжилтын хоорондын хамаарлыг тогтоох зорилгоор хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад өндөр хамааралтай байсан байна¹⁰.

Бидний энэхүү судалгаа нь цахим хэлбэрээр суралцсан анагаахын суралцагчдын хандалтын болон сурлагын амжилтын зарим үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг тодорхойлох зорилгоор хийгдсэн, судалгаанаас суралцагчдын цахим сургалтын хандалт сурлагын амжилтад шууд нөлөөлж байгааг тодорхойлж чадахгүй сул талтай ч, хамаарал байгааг тодорхойлсон нь цаашид судлагдах боломжийг нэмэгдүүлэх давуу талтай юм.

Дүгнэлт

Сурлагын амжилтын үзүүлэлт болон системийн хандалт хооронд сул хамаарал ажиглагдаж байгаа нь онлайн сургалтыг ашиглан сургалтын үр дүнг

нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна. Сургалтын цахим хэлбэрээр зохион байгуулахад суралцагчийн зүгээс технологийн өндөр хэрэгцээ шаардлагагүй байна.

Ном зүй

1. МУ-ын засгийн газар. Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2022-01-26. №30.
2. UNESCO. Education: From disruption to recovery, COVID-19 impact on education.
3. UNESCO. 1.3 billion learners are still affected by school or university closures, as educational institutions start reopening around the world, says UNESCO.
4. Almaiah MA, Al-Khasawneh A, Althunibat A. Exploring the critical challenges and factors influencing the E-learning system usage during COVID-19 pandemic. Education and information technologies. 2020 Nov;25:5261-80.
5. Baatarpurev B, Tsogbadrakh B, Bandi S, Samdankhuu GE, Nyamjav S, Badamdorj O. Online continuing medical education in Mongolia: needs assessment. Korean Journal of Medical Education. 2022 Aug 26;34(3):191-200.
6. Baljinnyam B, Undram M, Solongo B, Sumberzul N, Lkhagvasuren Ts, Oyungoo B. Organising E-Learning in Medical School During State Heightened Level of Readiness in Response to COVID-19 Pandemic. Asia Pacific Medical Education Conference. Singapore, 2023. p313.
7. Sormunen M, Saaranen T, Heikkilä A, Sjugren T, Koskinen C, Mikkonen K, Kärriäinen M, Koivula M, Salminen L. Digital learning interventions

- in higher education: A scoping review. *CIN: Computers, Informatics, Nursing*. 2020 Dec 1;38(12):613-24.
8. Du L, Zhao L, Xu T, Wang Y, Zu W, Huang X, Nie W, Wang L. Blended learning vs traditional teaching: The potential of a novel teaching strategy in nursing education-a systematic review and meta-analysis. *Nurse Education in Practice*. 2022 Apr 29:103354.
9. Fernandez AI, Al Radaideh A, Singh Sisodia G, Mathew A, Jimber del Rio JA. Managing university e-learning environments and academic achievement in the United Arab Emirates: An instructor and student perspective. *PloS one*. 2022 May 12;17(5):e0268338.
10. Younas M, Noor U, Zhou X, Menhas R, Qingyu X. COVID-19, students satisfaction about e-learning and academic achievement: Mediating analysis of online influencing factors. *Frontiers in psychology*. 2022;13.

A COMPARATIVE STUDY OF SYSTEM ACCESS AND ACADEMIC ACHIEVEMENT INDICATORS DURING E-LEARNING FOR MEDICAL STUDENTS

Abstract

Application of e-learning systems has increased during the COVID-19 pandemic and further research is needed for its' effective development. The aim of this study is to compare some indicators of access to e-learning systems with academic achievement among medical students who studied online. In this study, we obtained the data of 1462 students who studied online during the complete lockdown from the e-learning system. and some information such as academic achievement, number, location and devices used for the access to the e-learning system, type of the internet connection, and time spent in the system were collected using questionnaires. A weak correlation between the number of accesses to the system by students and indicators of academic achievement was observed. E-classes were mostly accessed from the urban area, using a personal computer with wired internet, and on average 3-6 hours were spent per day. No significant correlation was observed between academic achievement indicators and system access and technology use, indicating that there is potential to increase learning outcomes using e-learning in the future. Higher technology is not required for effective learning on the e-learning system.

АНАГААХЫН СУРГУУЛИЙН ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА

Ш.Батзүсэм, Ж.Сарантуяа, Ж.Одонтуйа
АШУУИС-ийн говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургууль
odontuya.j@mnums.edu.mn

Товч утга

Оюутныг зөв үнэлснээр тэднийг идэвхжүүлэх, суралцах ач холбогдлыг ухамсарлуулах, бие даан суралцах болон ажиллах чадварыг нь хөгжүүлдэг^[1]. Их сургуулиудын боловсролын өөрчлөлт, шинэчлэлийг харахад “оюутан” төвтэй үнэлгээгээр үнэлдэг болсон байна^[4].

Судалгааны зорилго: Анагаахын сургуулийн оюутны суралцах үйл ажиллагааны явц дахь багшийн үнэлгээг судалж, боловсронгуй болгох арга замыг судлах

Судалгааны арга зүй: Судалгааг АШУУИС, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургуулиудын багш нараас оюутнуудыг үнэлж буй хэлбэр, аргын талаарх судалгааг google forms ашиглан нэг агшингийн аргаар хийсэн. Судалгаанд оролцсон нийт 134 багшаас 4 бүлэг 15 асуумжаар судалгааг авсан.

Судалгааны үр дүнг SPSS 22.0 программд ашиглан нас, ажилласан жил, албан тушаалын ялгаатай байдлыг 95%-ийн итгэх хязгаар /CI/-т тооцож, chi-square тестийг ашиглан харьцуулах бөгөөд тэдгээр хувьсагчуудын дундаж оноог t-test ашиглан харьцуулан тодорхойлно.

Үрдүн: Багш нарын 36.8% нь багш төвтэй, 63.2% нь оюутан төвтэй аргаар суралцагчдыг үнэлж байна. Суралцагчдыг үнэлэхдээ 57.7% нь мэдээллийн технологийн хэрэгслийг ашигладаг, 41.6% нь хааяа ашигладаг, 2.7% нь огт ашигладаггүй байна. Анагаахын мэргэжлийн сургуулийн багш нар оюутнуудын мэдлэг, үр чадварыг үнэлэх, багаар ажиллах, гардан үйлдэл, хандлагыг үнэлэхэд OSCE болон OSPE аргуудыг голчлон ашигладаг.

Дүгнэлт: Анагаахын мэргэжлийн сургуулийн багш нарын 36.8% нь багш төвтэй үнэлгээгээр оюутны

сургалтын үйл ажиллагааг үнэлж байгаа нь багш нар үнэлгээний аргаа шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Үнэлгээ, анагаах, багш төвтэй үнэлгээ

Үндэслэл

Үнэлгээ нь оюутны суралцах үйл ажиллагааны явцад болон судалсны дараагаар эзэмшиж байгаа цогц чадамжуудын түвшинг тодорхойлох үүднээс хийгдэж буй сургалтын нэгэн хэсэг юм^[1].

Дэлхий нийтээрээ “хүн” төвт хөгжлийн үндсийг боловсрол, эрдэм мэдлэг гэж тодорхойлох болсон өнөөгийн нөхцөлд монгол орны боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, түүнд нийгмийн болон хувь хүний хэрэгцээ, шаардлага, үндэсний онцлог зэргийг харгалзан үзэх шаардлагатай байгаа билээ^[2].

Олон улсын их сургуулиудын жишгээс харахад “Мэдлэг бол хүч” гэж тодорхойлсон ба энэ нь хүний оюуны хэрэгцээг өдөөж, сэтгэхүйг нь хөгжүүлэх гол хэрэгсэл бөгөөд түүнийг тодорхойлох гол элемент нь үнэлгээ юм.

Мэдлэг олгох сургалтын үйл ажиллагааны явц дахь үнэлгээг “багш” төвтэй, “оюутан” төвтэй гэж ангилах бөгөөд тэдгээрийн үнэлгээ өгөх үйлдлийг дараах байдлаар харьцуулсан байна

“Багш” төвтэй үнэлгээ:

- Заах арга болон үнэлж дүгнэхийг тус тусад нь ялгаж салган үнэлдэг байна
- Үнэлгээ бол сургалтын явцыг хянах хэрэгсэл юм
- Зөв хариулт бол үнэлгээний гол түлхүүр байна
- Оюутан өөрөө хөдөлмөрлөж, бусад эх сурвалжаас олж авсан мэдлэгийг үнэлдэггүй харин багш өөрийн бэлдсэн тест материалаар

оюутны мэдлэгийг үнэлдэг

- Бие даан идэвхтэй суралцах болон багаар хэрхэн ажиллаж байгааг үнэлдэггүй байна
- Зөвхөн оюутан суралцах ёстой бөгөөд багшийн заасан хичээлийн түвшинд үнэлнэ.

“Оюутан” төвтэй үнэлгээ:

- Заах арга зүйг үнэлгээтэй холбож уялдуулан үнэлдэг байна.
- Үнэлгээ бол сургалтын явцыг идэвхжүүлэх хэрэгсэл юм
- Оюутныг цааш хөгжүүлэн алдаанаас сурах боломжийг үнэлгээ бий болгоно
- Оюутан мэргэжлийн сэтгүүл, өгүүллэг, төсөл зэрэг бусад эх сурвалжаас өөрийн идэвх чармайлтаар олж авсан мэдлэгийг багшийн заасантай харьцуулж дүгнэхийг үнэлнэ.
- Хамтран багаар ажиллах, бусдаа сонсох дэмжих, бие даан ажиллах зэрэгт үнэлгээ өгнө
- Багш оюутан хамтран суралцах ба багш бүгдийг мэдэх албагүй байна

Оюутнууд дүн авахын төлөө ажиллах хандлага түгээмэл байдгаас сургалтын зорилгыг буруугаар ойлгоход хүрч байна. Үнэлгээ бол зөвхөн сурсан мэдсэн түвшинг тогтоогоод төгсдөг зүйл биш, харин яаж илүү ихийг мэдэх, ойлгох, хийж чадах вэ зэрэгт анхааран суралцах үйл ажиллагааг багтаана. Оюутныг зөв үнэлснээр тэднийг идэвхжүүлэх, суралцах ач холбогдлыг ухамсарлуулах, бие даан суралцах болон ажиллах чадварыг нь хөгжүүлдэг. Үнэлгээний арга хэлбэр, шалгуур нь оюутнуудад нээлттэй, тэдгээрийн хөгжил, сэтгэц, хувийн онцлогийг харгалзан үзсэн саналыг тусгасан байх ёстой. Энэ нь оюутны суралцах эрхийг хүндэтгэн тэдэнд эерэг зөв ойлголт, хувь хүн төлөвших, өөртөө итгэх хандлагыг бий болгохоос гадна багшийн ур чадвар, арга барилтай хэрхэн холбогдох, тэдний үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгнө^[3].

Их сургуулиудын боловсролын өөрчлөлт, шинэчлэлийг харахад “оюутан” төвтэй үнэлгээгээр үнэлдэг болсон байна. Өнөөгийн байдлаар монгол улс боловсролын шинэчлэл хийх ажлуудыг шат дараатай хийж байгаа бөгөөд сургалтын явцад оюутны эзэмшсэн мэдлэгийг “оюутан” төвтэй үнэлгээгээр үнэлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага гарч ирээд байна. Ингэснээр сургалтын үйл ажиллагааны явц дахь оюутны мэдлэг, ур чадвар,

чадамжийг бүрэн тодорхойлж тэдгээрийн мэдлэгийг хэмжигдэхүйц байхаар үнэлэх юм^[4].

Судалгааны зорилго

Анагаахын сургуулийн оюутны суралцах үйл явц дахь үнэлгээний хэлбэр, арга, хэрэглээг судлах

Зорилт

1. Оюутнуудын суралцах үйл явцыг үнэлж буй үнэлгээний хэлбэрийг судлах
2. Оюутныг үнэлж байгаа үнэлгээний аргын сонголт, хэрэглээг судлах

Судалгааны практик ач холбогдол

Оюутны суралцах үйл ажиллагааны явц дахь багшийн үнэлгээг судалснаар их дээд сургуулийн багшийн үнэлгээний өнөөгийн байдлыг үнэлж, цаашид боловсронгуй болгох арга замыг судлах ач холбогдолтой юм.

Судалгааны шинэлэг тал

Оюутны суралцах үйл ажиллагааг үнэлэх талаар судлаачид олон судалгаа хийж байгаа боловч анагаахын сургуулийн оюутны суралцах үйл явцыг үнэлэх багшийн үнэлгээний хэлбэрийн талаар судалж байгаа нь шинэлэг болно.

Судалгааны материал, арга зүй

Судалгааг АШУУИС, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургуулиудын багш нараас оюутнуудыг үнэлж буй хэлбэр, аргын талаарх судалгааг google forms ашиглан нэг агшингийн аргаар хийсэн. Судалгаанд оролцсон нийт 134 багшаас 4 бүлэг 15 асуумжаар судалгааг авсан.

Судалгааны үр дүнг SPSS 22.0 программд ашиглан нас, ажилласан жил, албан тушаалын ялгаатай байдлыг 95%-ийн итгэх хязгаар /CI/-г тооцож, chi-square тестийг ашиглан харьцуулах бөгөөд тэдгээр хувьсагчуудын дундаж оноог t-test ашиглан харьцуулан тодорхойлно.


Судалгааны үр дүн

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон багш нарын ерөнхий судалгаа


		Асуумж	Хувь /%/
Сургууль		АШУҮИС	45.1%
		АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургууль	21.1%
		АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль	9.5%
		АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны Сургууль	11.2%
		Нийт	100%
Багшийн албан тушаалын зэрэглэл		Даллагачигч багш	5%
		Багш	45%
		Ахлах багш	42.5%
		Профессор	7.2%
	Нийт	100%	
Нас		Насны дундаж	41±0.921
Ажилласан жил		Ажилласан жилийн дундаж	18±1.527



Зураг 1. Оюутныг үнэлж буй үнэлгээний хэлбэр



Зураг 2. Оюутны суралцах үйл ажиллагааг үнэлэхэд мэдээлэл технологийн ашиглалт



Зураг 3. Үнэлгээнд хэрэглэж байгаа аргуудыг харьцуулан судалсан үр дүн

Хэлцэмж

- Энэ удаагийн судалгаанд багшийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийг тусгаагүй бөгөөд багшийн үнэлгээний хэлбэр, аргуудыг илүү тусган судалсан.
- Gloria Brown. Student-Centered Learning in Higher Education. Судалгаанд Их дээд сургуулийн багшийн оюутныг үнэлэх үнэлгээ нь оюутан төвтэй үнэлгээнд шилжиж байгааг дүгнэж бичсэн байна. Бидний судалгаанд 36.8% нь багш төвтэй үнэлгээний хэлбэрээр оюутныг үнэлж байна.

Дүгнэлт

- Анагаахын сургуулийн оюутны суралцах үйл ажиллагааны явцыг үнэлж байгаа үнэлгээнд 63.2% нь оюутан төвтэй үнэлгээний хэлбэрээр үнэлж байгаа нь сайшаалттай боловч 36.8% нь багш төвтэй үнэлгээний хэлбэрээр үнэлж байгаа, 57% нь үнэлгээнд мэдээлэл технологийг хааяа болон ашиглахгүй байгаа явдал нь өнөө үеийн боловсролын өөрчлөлт, шинэчлэлийн шаардлагаас хоцрогдож байна.
- Анагаахын сургуулийн оюутнуудын мэдлэг шалгах аргуудаас сорилын арга, чадвар үнэлэхэд гардан үйлдэл, багаар ажиллах,

хандлага үнэлэхэд ТЭЭШ, ТЗТШ, 360 хэмийн аргуудаар голчлон хэрэглэж байна. Зарим багш нарын үнэлгээний аргууд цөөхөн байгаа нь үнэлгээнд шинэчлэл хийх шаардлага тулгарч байна.

Ном зүй

1. Evelyn Bergsmann^{ab} Marie Therese Schultes^a Petra Winter^b Barbara Schober^a Christiane Spiel^a Evaluation of competence-based teaching in higher education: Evaluation and Program Planning Volume 52, October 2015, 1-9 p
2. Christoper T. Husbands. Students’ Evaluation of Teaching in Higher Education: experiences from four European countries and some implications of the practice. 28 Jul 2006.95-114 p
3. Д.Ариунболор Р.Мядагмаа П.Туул П.Булга Д.Батбаяр. Сургалтын явцын үнэлгээг шинэчлэн сайжруулах, сургалтын хөтөлбөрт нэгдсэн үнэлгээ хийх арга зүйн зөвлөмж .УБ.2017 он.
4. Б.Бат-Оргил. Рубрик үнэлгээний системийг боловсронгуй болгох. УБ. 2015 он.

STUDYING FOR TEACHER EVALUATION IN MEDICAL SCHOOL STUDENTS

Introduction: Proper assessment of students is so important to motivate them, to make them aware of the importance of learning, to develop their ability to study and work independently, to respect their right to study, and to give them a positive attitude, personal development, and self-confidence.

Nowadays, changes and innovations in university education are aimed at “student-centered” assessment.

Purpose: To study and evaluate ways to improve teacher evaluation in the learning process of medical school students

Method, materials: The study data was collected from 134 teachers of the MNUMS, Govi-Altai, Medical School of MNUMS, Dornogovi, Medical School of MNUMS and Darkhan-Uul, Medical School of MNUMS by cross-sectional survey method. The results of the study were compared using SPSS 22.0 to calculate age, experience, and position differences at 95% confidence intervals (CI) using the chi-square test, and the mean scores of these variables were compared using a t-test.

Result: 36.8% of the teachers evaluate students by teacher-centered and 63.2% evaluate students by student-centered. 57.7% use information technology tools to assess student learning, 41.6% use it occasionally, and 2.7% do not use it at all. Teachers of medical schools mainly use OSCE and OSPE methods to assess student’s knowledge and skills, to work in teams, and to evaluate manual actions and attitudes.

Conclusion: The result that 36.8% of medical school teachers evaluate student learning through teacher-centered assessment indicates that teachers need to reform their assessment.

Keywords: evaluation, medical, teacher student centered assessment

ИХ СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

А.Индра, М.Бадмаараг, Б.Үржинбадам, Э.Пүрэвсүрэн, Д.Отгонбаяр
АШУҮИС, Шинжлэх ухаан, технологийн газар
indra.a@mnums.edu.mn

Товч утга:

Даяарчлал, шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшил, нийгмийн хэрэгцээ шаардлагаас хамаарч боловсролын талаар төрөөс баримтлах бодлого шинэчлэгдэж байгаа бөгөөд үүнтэй уялдан их сургуулиуд сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болон хөгжих шаардлагууд зүй ёсоор урган гарч байна. Ийм ч учраас их сургуулийн багшийн ажил үүргүүд шинэчлэгдэж, багш бүр өөрийн мэргэжлийн чиглэлд судалгаа шинжилгээний ажил хийж, үндэсний болоод бүсийн бүр цаашлаад дэлхийн хэмжээний судлаач багш байхыг шаардах боллоо.

Мэргэжлийн сургуулийн багшлах боловсон хүчний нэг онцлог нь багш хэмээх мэргэжлийг үндсэн мэргэжилтэйгээ давхар эзэмшдэгт оршино. Тэр тусмаа их сургуулийн багшийн нэг үндсэн үүрэг нь шинэ мэдлэгийг бий болгох явдал байдагтай уялдан судалгааны арга зүйд гаршсан судлаач байхыг бас давхар шаарддаг. Ийм учраас анагаахын сургуулийн багшийн хөгжлийг эрдэм шинжилгээ, сургалт, эрүүл мэндийн үйлчилгээтэй нягт холбон авч үзэх нь зүйтэй юм.

Зорилго: Багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйл, түүний хамаарлыг судлах

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг нэг агшингийн дескриптив судалгааны загвараар АШУҮИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх гүйцэтгэлийг үнэлэх 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах чанарын оноогоор Google sheets-д үүсгэсэн үнэлгээний хуудасны дагуу нотлох баримтыг цуглуулан нийт бүрэлдэхүүний 8 сургуулийн 71 тэнхимийн нийт 460 багшийн эрдэм шинжилгээний ажлыг 2022 оны 5 дугаар сарын 20-оос 6 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд үнэлж нэгтгэлээ.

SPSS 25.0 программыг ашиглан статистик боловсруулалтыг хийсэн. P утга <0.05 үед үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан багш нарын эрдэм шинжилгээний ажлыг үнэлэхэд 62% (n=286) нь хангалттай үнэлгээтэй байлаа. Гүйцэтгэлийг сургууль тус бүрээр нь ангилж үзэхэд Анагаах ухааны сургуулийн багш нарын 57% (n=74), Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн багш нарын багш нарын 74% (n=17), Нүүр ам судлалын сургуулийн багш нарын 43% (n=13), Био-Анагаахын сургуулийн багш нарын 54% (n=70), Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын 72% (n=31), Эм зүйн сургуулийн багш нарын 89% (n=25), Сувилахуйн сургуулийн багш нарын 68% (n=49), Эрдмийн сургуулийн багш нарын 87% (n=7) нь тус тус хангалттай үнэлгээтэй байлаа.

Дүгнэлт: АШУҮИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд нийт багш нарын 62% (n=286) нь хангалттай үнэлгээтэй байлаа. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн тэнхимийн төрлөөр харьцуулан судлахад анагаахын суурь боловсролын тэнхимийн багш нарын гүйцэтгэл нь албан тушаалын зэрэглэл бүрд эмнэлзүйн тэнхимийн багш нарын гүйцэтгэлээс 6-12%-иар илүү, ерөнхий эрдмийн тэнхимийн багш нарын гүйцэтгэлээс 6-34%-иар илүү байсан ба эрдэм шинжилгээний гүйцэтгэлийн оноог үзүүлэлт тус бүрээр статистик тооцоолол хийж үзэхэд Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажиллах, АШУҮИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлэх, Оюуны өмч, Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлэх, Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлэх

гэх мэт дийлэнх үзүүлэлтүүдэд статистик үнэн магадлал бүхий ялгаа ажиглагдаж байсан нь их сургуулийн багшийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тооцохдоо тэнхимийн төрөл, чиглэл, онцлог болон багш нарын эрдмийн зэрэг цол, албан тушаалын зэрэглэл бүрд ялгаатай оноогоор үнэлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Түлхүүр үг: эрдэм шинжилгээ, гүйцэтгэл, өгүүлэл, төсөл, оюуны өмч

Судалгааны үндэслэл

Дэлхийн олон улс орон шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан мэдлэгийн эдийн засаг, дэвшилтэт болон өндөр технологийг хөгжүүлэх замаар үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хөгжлийн бодлогоо чиглүүлэн эдгээрт хөрөнгө, нөөцийг төвлөрүүлэхэд онцгой анхаарал хандуулж байна.

Мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх үндэс суурь болох үндэсний инновацын үр ашигтай тогтолцоо бүрдүүлэхэд их сургуулиуд ялангуяа, судалгаанд суурилсан их сургуулиуд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгааг хөгжилтэй орнуудын туршлага харуулж байна. 2013 онд Судалгааны их сургуулийг хөгжүүлэх талаар гарсан “Хэфэйн тунхаглал”- д “судалгааны их сургуулийг үр ашигтай институци болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг бүх талаар дэмжсэн бодлого, эрх зүйн орчин бүрдсэнээр их сургуулийн өрсөлдөх чадварыг сайжруулан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломж нээгдэнэ. Ийм орчин бүрдээгүй нөхцөлд судалгааны их сургуулийн өрсөлдөх давуу талыг бий болгох, төлөвшин хөгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй” хэмээн тодорхойлжээ. Ийм ч учраас даяарчлал, шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшил, нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдан их сургуулиуд сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болон хөгжих шаардлагууд зүй ёсоор урган гарч байна. Үүний нэгэн адил АШУУИС нь Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох томоохон зорилго дэвшүүлэн их сургуулийн хөгжлийн бодлогодоо үнэлгээ хийж, “АШУУИС-ИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-2030” бодлогын баримт бичгээ хамт олноороо хэлэлцэн баталж, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, инновац-шинэ технологийг хөгжүүлэх, дэлхийн түвшний шинжлэх ухааны мэдлэг, технологид түшиглэсэн судалгаанд суурилсан их сургуулийн тогтолцоог

бий болгохоор зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд их сургуулийн багш нарын эрдэм судлалын ажлын эрх зүйн орчин, бүтэц тогтолцооны шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлснээр багш судлаачдын судалгааны бүтээмжийг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны таатай орчныг бүрдүүлэх, судалгааны ажлын чанарыг ахиулах, тэргүүлэх чиглэлийн судалгааг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний лабораториудын дэд бүтцийг сайжруулах, эрдэмтэн судлаачдын академик эрх чөлөөг эрхэмлэх болсноор манай их сургуулийн эрдэмтэн, багш судлаачид 2022 онд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн импакт фактор бүхий сэтгүүлд 109 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, бүтээлээс эшлэл авсан тоо 2676-д хүрч, Монгол улсын хэмжээнд эрдэм шинжилгээний бүтээлийн чансаагаар эхний 3 байранд тогтмол багтсан амжилттай ажиллаж ирлээ.

Судалгааны их сургуульд тавигдах үндсэн 6 шаардлагын голлох хүчин зүйл нь их сургуулийн багш судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд олон улсад хүлээн зөвшөөрөгдөх явдал тул АШУУИС-ийн багшийн ажил үүргүүд шинэчлэгдэж, багш бүр өөрийн мэргэжлийн чиглэлд судалгаа шинжилгээний ажил хийж, үндэсний болоод бүсийн бүр цаашлаад дэлхийн хэмжээний судлаач багш байхаар их сургуулийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөө тусган ажиллаж их сургуулийн багшийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг жил бүр 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлтээр гүйцэтгэлийн үнэлгээ хийж ажиллаж эхэлсэн бөгөөд бид 2022 онд АШУУИС-ийн бүрэлдэхүүний 8 сургуулийн мэргэжлийн 74 тэнхимийн 460 багшийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, судалгааны их сургуулийн хөгжилд багш нарын оруулж буй үр нөлөө, ахиц дэвшлийг тооцож байх зүй ёсны шаардлагыг үндэслэл болгон энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Зорилго

Багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйл, түүний хамаарлыг судлах

Зорилт

АШУУИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн өнөөгийн байдлыг судлах

Багш нарын эрдэм шинжилгээний гүйцэтгэлийг бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимүүдийн хувьд харьцуулан судлах

Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох

Арга, аргачлал

Бид энэхүү судалгааг нэг агшингийн дескриптив судалгааны загвараар АШУУИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх гүйцэтгэлийг үнэлэх 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах чанарын оноогоор Google sheets-д үүсгэсэн үнэлгээний хуудасны дагуу нотлох баримтыг цуглуулан нийт бүрэлдэхүүний 8 сургуулийн 71 тэнхимийн нийт 460 багшийн эрдэм шинжилгээний ажлыг 2022 оны 5 дугаар сарын 20-оос 6 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд үнэлж нэгтгэлээ.

Судалгааны асуумж 12 үзүүлэлтээс бүрдсэн ба үзүүлэлт тус бүрд харгалзах оноог өгч, нотлох баримтаар баталгаажуулсан. Үүнд:


1. Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан
2. Докторын зэрэг хамгаалсан
3. Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан
4. Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн өгүүлэлд шүүмж бичсэн
5. АШУУИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн
6. АШУУИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд иш татагдсан тоо
7. Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлсэн
8. Оюуны өмч
9. Дотоодын сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан
10. Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн
11. Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлсэн
12. Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн

SPSS 25.0 программыг ашиглан статистик

боловсруулалтыг хийсэн. P утга <0.05 үед үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн

2021-2022 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээний ажлаа үнэлүүлсэн 8 сургуулийн 71 тэнхимийн 460 багш нарын 62% (n=286) хангалттай үнэлгээтэй байсан ба нийт багш нарын 8.5% (n=39) нь профессор, 11.5% (n=53) нь дэд профессор, 27.2% (n=125) нь ахлах багш, 37.4% (n=172) нь багш, 15.4% (n=71) нь дадлагажигч багш байлаа.




Зураг 1. АШУУИС-ийн багш нарын албан тушаалын зэрэглэл /%/

Гүйцэтгэлийг сургууль тус бүрээр нь ангилж үзэхэд Анагаах ухааны сургуулийн багш нарын 57% (n=74), Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн багш нарын багш нарын 74% (n=17), Нүүр ам судлалын сургуулийн багш нарын 43% (n=13), Био-Анагаахын сургуулийн багш нарын 54% (n=70), Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын 72% (n=31), Эм зүйн сургуулийн багш нарын 89% (n=25), Сувилахуйн сургуулийн багш нарын 68% (n=49), Эрдмийн сургуулийн багш нарын 87% (n=7) нь тус тус хангалттай үнэлгээтэй байлаа.

Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тэнхимийн төрлөөр харьцуулж судлахад анагаахын суурь боловсролын тэнхимийн багш нарын 68.3% (n=170), эмнэлзүйн тэнхимийн багш нарын 57.2% (n=99), ерөнхий эрдмийн тэнхимийн багш нарын 44.7% (n=17) нь хангалттай үнэлгээтэй байна.

Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг багш нарын албан тушаалын зэрэглэлээр харьцуулж үзэхэд профессор багш нарын 87.2% (n=34), дэд профессор багш нарын 79.2% (n=42), ахлах багш нарын 68.8% (n=86), багш нарын 52.9%




Зураг 2. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл /бүрэлдэхүүн сургуулиар/

(n=91), дадлагажигч багш нарын 46.5% (n=33) нь хангалттай үнэлгээтэй байна.

Багш нарын 2021-2022 оны хичээлийн жилийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг үзүүлэлт тус бүрээр статистик тооцоолол хийж үзэхэд Scopus мэдээлийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан багш нарын 57.1% (n=4) нь профессор багш, 14.3% (n=1) нь дэд профессор, 14.3% (n=1) нь ахлах багш, 14.3% (n=1) нь багш нар байсан ба дадлагажигч багш нар редакцын зөвлөлд ажиллаагүй байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа (p<0.0001).

Тухайн жилд оюуны өмчөөр баталгаажсан бүтээлтэй багш нарыг бүрэлдэхүүн сургуулиар

харьцуулан судлахад давхардсан тоогоор Сувилахуйн сургуулийн багш нарын 32.7% (n=48), Био-Анагаахын сургуулийн багш нарын 28.6% (n=42), Эмзүйн сургуулийн багш нарын 17.7% (n=26), Анагаах ухааны сургуулийн багш нарын 9.5% (n=14), Нүүр ам судлалын сургуулийн багш нарын 6.1% (n=9), Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын 2% (n=3), Эрдмийн сургуулийн багш нарын 2% (n=3), Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн багш нарын 1.4% (n=2) байсан (p<0.0001) ба тэнхимийн төрлөөр судлахад 74.8% (n=95) нь анагаахын суурь боловсролын тэнхимийн багш нар, 17% (n=25) нь эмнэлзүйн тэнхимийн багш нар, 8.2% (n=12) нь ерөнхий эрдмийн тэнхимийн багш нар



Зураг 3. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл /Тэнхимийн төрөл, Албан тушаалын зэрэглэлээр/

байлаа ($p < 0.0001$). Оюуны өмчөөр баталгаажсан бүтээлтэй багш нарыг албан тушаалын зэргээр харьцуулж үзэхэд багш нарын 39.5% ($n=58$) нь багш, 35.4% ($n=52$) нь ахлах багш, 8.8% ($n=13$) нь профессор багш, 8.8% ($n=13$) нь дэд профессор, 7.5% ($n=11$) нь дадлагажигч багш нар байсан ($p=0.003$).

Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлж буй багш нарыг бүрэлдэхүүн сургуулиар харьцуулан судлахад Анагаах ухааны сургуулийн багш нарын 29.7% ($n=44$), Био-Анагаахын сургуулийн багш нарын 25.7% ($n=38$), Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын 23% ($n=34$), Сувилахуйн сургуулийн багш нарын 8.8% ($n=13$), Эмзүйн сургуулийн багш нарын 4.7% ($n=7$), Нүүр ам судлалын сургуулийн багш нарын 2.7% ($n=4$), Эрдмийн сургуулийн багш нарын 2.7% ($n=4$), Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн багш нарын 2.7% ($n=4$) байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай ($p < 0.0001$) байгаа ба төсөл хэрэгжүүлж байгаа багш нарыг тэнхимийн төрлөөр нь бүлэглэн харьцуулж үзэхэд 64.2% ($n=95$) нь анагаахын суурь боловсролын тэнхимийн багш нар, 33.8%

($n=50$) нь эмнэлзүйн тэнхимийн багш нар, 2% ($n=3$) нь ерөнхий эрдмийн тэнхимийн багш нар байгаа нь статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа байгааг илэрхийлж байна ($p=0.001$). Төсөл хэрэгжүүлж буй багш нарыг албан тушаалын зэрэглэлээр харьцуулж үзэхэд статистик үнэн магадлал бүхий ялгаа ажиглагдсангүй ($p=0.713$).

АШУҮИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн багш нарын 12.3% ($n=16$) нь профессор багш, 20% ($n=26$) нь дэд профессор, 23.1% ($n=30$) нь ахлах багш, 31.5% ($n=41$), 13.1% ($n=17$) нь дадлагажигч багш нар байсан бөгөөд ($n=0.001$) бөгөөд үүнээс дийлэнх хувь буюу 55.4% ($n=72$) нь анагаахын суурь боловсролын тэнхимийн багш нар, 41.5% ($n=54$) нь эмнэлзүйн тэнхимийн багш нар, 3.1% ($n=4$) нь ерөнхий эрдмийн тэнхимийн багш нар байлаа.

Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хариуцлагатай зохиогчоор бүтээл хэвлүүлсэн багш нарын 21.1% ($n=4$) нь профессор багш, 42.1% ($n=8$) нь дэд профессор, 26.3% ($n=5$) нь ахлах багш, 10.5% ($n=2$) нь багш байсан ба

Хүснэгт 1. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг бүрэлдэхүүн сургуулиудыг харьцуулсан дүн

№	Үзүүлэлт	АУС	МАУОУС	НАСС	БАС	НЭМС	ЭЗС	СС	ЭС	P утга
1	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан	1 (100%)								
2	Докторын зэрэг хамгаалсан	3 (37.5%)	-	1 (12.5%)	4 (50%)	0	0	0	0	0.624
3	Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан	3 (42.9%)	0	0	3 (42.9%)	0	0	0	1 (14.2%)	0.156
4	Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн өгүүлэлд шүүмж бичсэн	5 (45.5%)	0	0	4 (36.4%)	1 (9.1%)	0	0	1 (9.1%)	0.270
5	АШУҮИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн	46 (35.4%)	4 (3.1%)	5 (3.8%)	30 (23.1%)	19 (14.6%)	4 (3.1%)	21 (16.2%)	1 (0.8%)	0.018
6	АШУҮИС-ийн нэрээр Scopus санд бүртгэлтэй сэтгүүлд иш татагдсан тоо	31 (31.6%)	3 (3.1%)	4 (4.1%)	39 (39.8%)	8 (8.2%)	4 (4.1%)	5 (5.1%)	4 (4.1%)	0.001
7	Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлсэн	44 (29.7%)	4 (2.7%)	4 (2.7%)	38 (25.7%)	34 (23%)	7 (4.7%)	13 (8.8%)	4 (2.7%)	<0.0001
8	Оюуны өмч	14 (9.5%)	2 (1.4%)	9 (6.1%)	42 (28.6%)	3 (2%)	26 (17.7%)	48 (32.7%)	3 (2%)	<0.0001
9	Дотоодын сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан	38 (38%)	7 (7%)	8 (8%)	19 (19%)	14 (14%)	7 (7%)	4 (4%)	3 (3%)	0.001
10	Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн	72 (23.1%)	1 (4.8%)	21 (6.7%)	94 (30.1%)	39 (12.5%)	19 (6.1%)	45 (14.4%)	7 (2.2%)	0.001
11	Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлсэн	71 (26.1%)	21 (7.7%)	16 (5.9%)	68 (25%)	23 (8.5%)	21 (7.7%)	47 (17.3%)	5 (1.8%)	0.015
12	Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн	91 (24.7%)	22 (6%)	27 (7.3%)	94 (25.5%)	41 (11.1%)	22 (6%)	64 (17.4%)	7 (1.9%)	<0.0001

Үзүүлэлтүүдийг тоо (хувь)-р илэрхийлсэн. $p < 0.05$

Хүснэгт 2. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тэнхимийн төрлөөр харьцуулсан дүн

№	Үзүүлэлт	Эмнэлзүйн тэнхим	Анагаахын суурь боловсролын тэнхим	Ерөнхий эрдмийн тэнхим	P утга
1	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан	1 (100%)	0	0	0.435
2	Докторын зэрэг хамгаалсан	4 (50%)	4 (50%)	0	0.597
3	Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан	3 (42.9%)	4 (57.1%)	0	0.722
4	Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн өгүүлэл шүүмж бичсэн	5 (45.5%)	6 (54.5%)	0	0.572
5	АШУУИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн	54 (41.5%)	72 (55.4%)	4 (3.1%)	0.035
6	АШУУИС-ийн нэрээр Scopus санд бүртгэлтэй сэтгүүлд иш татагдсан тоо	37 (37.8%)	60 (61.2%)	1 (1%)	0.011
7	Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлсэн	50 (33.8%)	95 (64.2%)	3 (2%)	0.001
8	Оюуны өмч	25 (17%)	110 (74.8%)	12 (8.2%)	<0.0001
9	Дотоодын сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан	53 (53%)	47 (47%)	0	<0.0001
10	Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн	102 (32.7%)	190 (60.9%)	20 (6.4%)	0.001
11	Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлсэн	100 (36.8%)	146 (53.7%)	26 (9.6%)	0.015
12	Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн	132 (35.9%)	210 (57.1%)	26 (7.1%)	<0.0001

Үзүүлэлтүүдийг тоо (хувь)-р илэрхийлсэн. $p < 0.05$

Хүснэгт 3. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг багш нарын албан тушаалын зэрэглэлээр харьцуулсан дүн

№	Үзүүлэлт	Профессор	Дэд профессор	Ахлах багш	Багш	Дад.багш	P утга
1	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан	1 (100%)	0	0	0	0	0.029
2	Докторын зэрэг хамгаалсан	0	0	2 (25%)	4 (50%)	2 (25%)	0.650
3	Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан	4 (57.1%)	1 (14.3%)	1 (14.3%)	1 (14.3%)	0	<0.0001
4	Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн өгүүлэл шүүмж бичсэн	2 (18.2%)	2 (18.2%)	5 (45.5%)	2 (18.2%)	0	0.205
5	АШУУИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн	16 (12.3%)	26 (20%)	30 (23.1%)	41 (31.5%)	17 (13.1%)	0.001
6	АШУУИС-ийн нэрээр Scopus санд бүртгэлтэй сэтгүүлд иш татагдсан тоо	16 (16.3%)	20 (20.4%)	26 (26.5%)	27 (27.6%)	9 (9.2%)	<0.0001
7	Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлсэн	15 (10.1%)	19 (12.8%)	35 (23.6%)	55 (37.2%)	24 (16.2%)	0.713
8	Оюуны өмч	13 (8.8%)	13 (8.8%)	52 (35.4%)	58 (39.5%)	11 (7.5%)	0.003
9	Дотоодын сэтгүүлийн редакцын зөвлөлд ажилласан	18 (18%)	30 (30%)	30 (30%)	15 (15%)	7 (7%)	<0.0001
10	Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн	26 (8.3%)	42 (13.5%)	84 (26.9%)	108 (34.6%)	52 (16.7%)	0.187
11	Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлсэн	18 (18%)	30 (30%)	30 (30%)	15 (15%)	7 (7%)	0.003
12	Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн	31 (8.4%)	39 (10.6%)	103 (28%)	135 (36.7%)	60 (16.3%)	0.563

Үзүүлэлтүүдийг тоо (хувь)-р илэрхийлсэн. $p < 0.05$

Хүснэгт 4. Scopus мэдээлийн санд бүртгэлтэй сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн багш нарыг албан тушаалын зэрэглэлээр харьцуулсан дүн

Албан тушаал	Профессор	Дэд профессор	Ахлах багш	Багш	Дадлагажигч багш	P утга
Хариуцлагатай зохиогч	4 (21.1%)	8 (42.1%)	5 (26.3%)	2 (10.5%)	0	<0.0001
Нэгдүгээр зохиогч	1 (4.0%)	4 (16.0%)	6 (24.0%)	12 (48.0%)	2 (8.0%)	0.565

Үзүүлэлтүүдийг тоо (хувь)-р илэрхийлсэн. $p < 0.05$

дадлагажигч багш нар хариуцлагатай зохиогчоор бүтээл хэвлүүлээгүй байна ($p < 0.0001$). Scopus мэдээлийн санд бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор бүтээл хэвлүүлсэн багш нарын 4% ($n=1$) нь профессор багш, 16% ($n=4$) нь дэд профессор, 24% ($n=6$) нь ахлах багш, 48% ($n=12$) нь багш, 8% ($n=2$) нь дадлагажигч багш нар байсан ($p=0.565$) ба хариуцлагатай болон нэгдүгээр зохиогчоор бүтээл хэвлүүлсэн багш нарыг тэнхимийн төрлөөр харьцуулан үзэхэд статистик ялгаа ажиглагдсангүй ($p=0.936$).

Хэлцэмж

Их сургуулийн багшийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг олон улс болон дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, илтгэл хэлэлцүүлэх, оюуны өмч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал гэх мэт үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийг сургууль тус бүр харилцан адилгүй үнэлгээгээр үнэлж байна. Тухайлбал хамгийн их ялгаа ажиглагдсан нь Шинжлэх ухаан технологийн их сургууль Scopus, WOS, Pubmed мэдээлийн санд бүртгэлтэй гадаадын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлд хариуцлагатай болон нэгдүгээр зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн багш нарын эрдэм шинжилгээний оноог бүтэн тооцдог бол Монгол улсын их сургууль тус мэдээлийн санд бүртгэлтэй сэтгүүлийг 4 индексээр ангилан /Q1, Q2, Q3, Q4/ тухайн судалгааны салбарын дундаж индекстэй тэнцүү болон түүнээс дээгүүр индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл, дунджаас доогуур индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлийг зохиогч харгалзахгүй хамгийн өндөр оноогоор үнэлдэг. Манай сургуулийн хувьд Scopus мэдээлийн санд бүртгэлтэй гадаадын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлд хариуцлагатай, нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн байдлаар нь оноог ялгаж тооцдог. Мөн төсөл, хөтөлбөрийг үнэлэхдээ МУИС болон ШУТИС ямар байгууллагаас санхүүжүүлснээр нь тухайлбал ШУТС-ийн санхүүжүүлэлттэй төсөл, Төр

засгийн байгууллага, аж ахуйн нэгж, Монгол дахь албан ёсны байгууллагын захиалгат болон тухайн сургуулиас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, Гадаадтай хамтарсан төсөл гэсэн ангиллаар үнэлдэг нь манай сургуулиас ялгаатай байна. АШУҮИС-ийн хувьд төсөл хөтөлбөрийг үнэлэхдээ санхүүжилтийн мөнгөн дүнгээр буюу 100 сая төгрөг хүртэл, 100-300 сая төгрөг, 300-аас дээш төгрөгийн санхүүжилттэй төсөл гэж ангилан тооцдог.

Багшийн эрдэм шинжилгээ, инновацын ажлын үнэлгээг төрийн өмчийн болон хувийн их дээд сургуулиуд багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагад нийцүүлэн үнэлэх үнэлгээний системийг хэрэгжүүлж байна. Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль болон Монгол улсын их сургуулийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тооцоходоо кредитээр үнэлдэг ба профессор, багш нарын эрдэм шинжилгээ, инновацын ажил буюу “Б” цагийн ноогдлын хувь харьцаа багшийн албан тушаалын зэрэглэл ахих тусам 4-10%-иар өгсөх байдлаар үнэлдэг. Тухайлбал багшийн ажлын гүйцэтгэлийн дотор эрдэм шинжилгээ, инновац /б/ цагийн хувь нь Профессор 30%, Дэд профессор 25%, Ахлах багш 20%, Багш 10%, Дадлагажигч багш 5% буюу 5-10% ялгаатай тооцож байна. АШУҮИС-ийн хувьд “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-д сургалтын ачааллыг тэнхимийн төрөл, чиглэл, онцлогтой уялдуулан ялгаатай оноогоор тооцдог боловч эрдэм шинжилгээний ажлын оноог багш нарын албан тушаалын зэрэглэл харгалзахгүйгээр ижил оноогоор үнэлж байгаа нь багш, дадлагажигч багш нарын хувьд тухайн албан тушаалын зэрэглэлд харгалзах эрдэм шинжилгээний ажлын ачааллыг биелүүлж чадахгүйд хүрч байна. Мөн гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлтүүдийг дотор нь олон ангилалтай, хийсэн эрдэм шинжилгээний ажил болгон үнэлгээтэй болох нь тухайн сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний ажлын

гүйцэтгэл хангалттай өндөр байх нөхцөл бүрдэх юм.

Дүгнэлт

1. АШУУИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд нийт багш нарын 62% (n=286) нь хангалттай үнэлгээтэй байсан ба тэнхимийн төрлөөр харьцуулан судлахад анагаахын суурь боловсролын тэнхим хамгийн өндөр биелэлттэй буюу 68.3% (n=170), эмнэлзүйн тэнхимийн багш нарын 57.2% (n=99), ерөнхий эрдмийн тэнхимийн багш нарын 44.7% (n=17) нь хангалттай үнэлгээтэй байна.
2. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тэнхимийн төрлөөр харьцуулж үзэхэд анагаахын суурь боловсролын тэнхимийн багш нарын гүйцэтгэл нь багш нарын албан тушаалын зэрэглэл бүрд эмнэлзүйн тэнхимийн гүйцэтгэлээс 6-12%-иар илүү оноотой, ерөнхий эрдмийн тэнхимийн багш нарын гүйцэтгэлээс 6-34%-иар илүү байсан ба эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг үзүүлэлт тус бүрээр статистик тооцоолол хийж үзэхэд Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажиллах, АШУУИС-ийн нэрээр Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлэх, Оюуны өмч, Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлэх, Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлэх гэх мэт дийлэнх үзүүлэлтүүдэд статистик үнэн магадлал бүхий ялгаа ажиглагдаж байсан нь “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын эрдэм шинжилгээний ажлын үнэлгээг тэнхимийн төрөл, чиглэл, онцлог болон эрдмийн зэрэг цолоос хамаарч багш нарын албан тушаалын зэрэглэл бүрд ялгаатай оноогоор үнэлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Номзүй

1. The Executive Council of the WFME (1998). International standards in Medical Education: assessment and accreditation of medical schools' educational programmes. A WFME position

- paper. Medical Education. 32 (5) p 549-558
2. WHO Guidelines for Quality Assurance of Basic Medical Education in the Western Pacific Region. Manila. Philippines. 2001
 3. Ц.Лхагвасүрэн Ц., Цэрэндагва Д., Дүнгэрдорж Д., Мэргэжлийн боловсролын глобал стратеги, “Анагаах ухааны боловсрол судлал”, УБ, 2007, хуудас. 9
 4. WFME Global Standards in Medical Education- The Trilogy, University of Copenhagen, Denmark, 2001
 5. Karle H, 2002, Global standards in medical education - an instrument in quality improvement, Journal of Medical Education, v 36, I 7, p 604
 6. Д.Отгонбаяр, нар. Анагаах ухааны боловсрол судлал ном. Улаанбаатар; 2011 он.
 7. Д.Отгонбаяр, Ц.Лхагвасүрэн нар. Ерөнхий мэргэжлийн анагаах ухаан. Сургалтын нэгдмэл хөтөлбөр. 2012 он.
 8. Д.Отгонбаяр, “Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудал”. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2010 он
 9. Association of American Medical Colleges, 2007. Functions and structure of medical schools: Standards for accreditation of medical education programs leading to the MD degree, Liaison Committee on Medical Education. Retrieved: September 7, 2007, from: <http://www.lcme.org>
 10. “Хэфэйн тунхаглал”, 2013 он.
 11. Боловсролын чанарын үнэлгээ. Улирал тутмын сэтгүүл. 2010 оны дугаар 1,2.
 12. IHEPI, 6-8 September 2010, From Higher education to innovation.
 13. Н.Бэгз. Боловсролын хөгжлийн онол аргагүйн асуудал
 14. Л.Болдбаатар. Дээд боловсролын менежмент, өөрчлөлт шинэчлэлт, онол арга зүй, Улаанбаатар 2008.
 15. Төрийн өмчийн зарим их сургуулиудын багшийн эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх журам. /Монгол улсын их сургуулийн “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”, Хөдөө аж ахуйн их сургуулийн “Профессор, багш ажиллуулах журам”/
 16. Д.Отгонбаяр, Ц.Лхагвасүрэн нар. Анагаах эрдэм боловсрол 2015

17. Д.Отгонбаяр, Б.Балжинням, М.Ундрэм, Б.Баярмагнай нар. Багшийн ажлын үнэлгээнд хийсэн судалгаа. Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүл. 2011: 89-91.
18. Д.Отгонбаяр, Н.Баасанжав нар Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа Монголын Анагаах Ухаан сэтгүүл, 2018:№3, хуудас 75-79.
19. Д.Отгонбаяр, Н.Баасанжав нар Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн оюутны сэтгэл ханамжийн түвшин Монголын Анагаах Ухаан сэтгүүл, 2018:№3, хуудас 83-87.

ANALYSIS OF THE RESEARCH WORK PERFORMANCE LECTURERS OF MNUMS

Abstract

Government education policies are updated according to globalization, scientific and technological progress, and social needs, and as a result, universities should naturally transition from teaching universities to research universities. As a result, the responsibilities of university teachers have been renewed, and all teachers are expected to study their fields of specialization and become national, regional, or world-class research teachers. It is characterized that all university teachers working alongside to their primary profession. Since one of the main tasks of university professors are to generate new knowledge, they should be a researcher with a good understanding of research methodologies. Furthermore, there is a need to consider the development of professors at medical universities in terms of research, teaching, and health care service providing.

Purpose: To analyze the research work performance of teachers at MNUMS and the relationships between the variables that affect research performance of teachers.

Methods and materials: We used a cross-sectional descriptive research model and collected data using a Google sheets with four groups of 12 indicators with the points to evaluate the research work performance of teachers in 71 departments of 8 schools of MNUMS. The research work of 460 teachers was evaluated and collected from May 20 to June 10, 2022.

Results: The research work of 62% (n=286) of the all evaluated teachers was performed as satisfactory rate. In terms of research based performance scores by schools, 57% (n = 74) of medical school teachers, 74% (n = 17) of International School of Mongolian medicine teachers, and 43% (n=13) of School of Dentistry teachers, 54% (n=70) of Biomedicine school teachers, 72% (n=31) of School of Public health teachers, 89% (n=25) of School of Pharmacy, 68% (n=49) of School of Nursing teachers and 87% (n=7) of Graduate School teachers performed well.

Conclusion: According to the result of research work evaluation of MNUMS teachers, 62% of all evaluated teachers (n=286) were rated as satisfactory. In a comparison of research work performance by department, faculty members of Basic medical education departments performed 6-12% better than faculty members in clinical departments and 6-34% better than faculty members in general academic departments at each academic position. Statistically significant difference were observed when the research based performance score for each indicator is calculated such as the editorial board of a Scopus-registered journal, publishing an article in a Scopus-registered journal under the name MNUMS, implementing a project with international and domestic funding, and a domestic publication with ISSN and eISSN codes with intellectual property and presenting at international or national level conferences. It demonstrates that it is necessary to amend «Rules for Evaluating University Teacher Activity and Performance at MNUMS» and evaluate research work with different points for each department type, direction, specialty, and rank of the teacher's position.

Key words: research work, performance, article, project, intellectual property

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ ДЭХ УДИРДАХ АЖИЛТАНТАЙ ХОЛБООТОЙ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУДАЛСАН ДҮН

Б.Нарантунгалаг
“Ач” Анагаах ухааны их сургууль
narantungalag@ach.edu.mn

Түлхүүр үг: дүрэм, ёс зүй, хэм хэмжээ

Удиртгал: Ёс зүй түүний мөн чанар, хэм хэмжээг нарийн судлах, хүмүүсийн харилцаанд үүсэж буй асуудлыг шийдэх хэрэгцээ шаардлага аль ч нийгмийн үед байсаар ирсэн. Дэлхий дахинаа дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтан нь мэргэжлийн байх, ёс зүйн хэм хэмжээг биелүүлдэг байх, объектив байх, хариуцлагатай байх гэсэн 4 чухал үнэт зүйлийг хэрэгжүүлэгч байх нийгмийн хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж байгааг судлаачид судлан тайлбарлан, санал дэвшүүлж байна. Дээрх 4 үнэт зүйлээс бид “ёс зүйн хэм хэмжээг биелүүлдэг байх” гэсэн үнэт зүйлийн агуулгыг тайлбарлах, ингэхдээ дээд боловсролын сургалтын байгууллагын ёс зүйн дүрэмд удирдах ажилтантай холбоотой ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг судлах юм.

Судалгааны ажлын зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын ёс зүйн дүрэмд удирдах ажилтантай холбоотой хэм хэмжээний хэрэгжилтийг судлах.

Судалгааны хэрэглэгдэхүүн: Судалгааны түүвэрт ижил чиглэлийн хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг эсэхийг гол шалгуур болгон төрийн болон төрийн бус өмчийн тус бүр тав, нийт арван их, дээд сургуулийг сонгов. Судалгааны найдвартай байдлыг хадгалан нийт 743 багшийг судалгаанд хамруулав. 2 сар орчмын хугацаанд оролцогчдоос google from программыг ашиглаж өгөгдлийг цуглуулав.

Тоон судалгааны мэдээлэл цуглуулах асуулгын арга: Их, дээд сургуулийн багш нараас түүврийн аргаар асуумж судалгаа авч боловсруулалт хийв.

Статистик боловсруулалт: Судалгааны мэдээллийг SPSS программ ашиглан боловсруулж, үр дүнг нэгтгэн гаргав.

Судалгааны үр дүн: Судалгаанд нийт 743 их, дээд сургуулийн багш нарын төлөөлөл оролцсоны 73.9 хувь нь эмэгтэй, 26.1 хувь нь эрэгтэй байв. Энэ нь их, дээд сургуульд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгааг харуулж байна. Судалгаанд бүх насны төлөөлөл оролцсоноос гадна ажилласан жил, албан тушаалын зэрэглэл, туршлагын хувьд ялгаатай төлөөллүүд хамрагдсан байна.

Их, дээд сургуулийн багш нар мэргэжлийн ёс зүйн талаарх мэдээллийг хэрхэн, хаанаас авдгийг тодруулахад судалгаанд оролцогчдын 33.7 хувь нь хурал зөвлөгөөн, 18.3 хувь нь ном гарын авлагаас, 17 хувь нь суралцаж байх хугацаандаа, 12.1 хувь нь цахим хэлбэрээр, 6.3 хувь нь ахмад багш ажилчдаас, 5.6 хувь нь удирдах албан тушаалтнаас, 4.6 хувь нь холбогдох байгууллагын сургалтаас, 2.2 хувь нь бие даан сэдэвт хамаарах мэдээлэл авдаг гэж хариулжээ.

Дээд боловсролын салбарт мэргэжлийн ёс зүй хэрхэн төлөвшиж буйг тодруулахад судалгаанд оролцогчдын 44.1 хувь дунд, 31.7 хувь хангалтгүй, 15.1 хувь сайн, 6.1 хувь муу, 1.6 хувь маш сайн, 1.5 хувь мэдэхгүй гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчид байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн өнөөгийн байдлыг үнэлэхдээ сургуулийн ерөнхий захиралд 38.1 хувь нь сайн, бүрэлдэхүүн сургуулийн захиралд 38.1 хувь нь сайн, алба хэлтсийн даргад 24.7 хувь нь сайн, сургалтын албаны даргад 25.6 хувь нь сайн, захиргаа санхүү аж ахуй хариуцсан даргад 21.6 хувь нь сайн, тэнхим, лаборатори, төвийн

Хүснэгт 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүй өнөөгийн байдлыг багш нар үнэлсэн нь.

Үнэлгээ	Сургуулийн ерөнхий, дэд захирал	Бүрэлдэхүүн сургуулийн захирал	Алба хэлтсийн дарга	Сургалтын албаны дарга	Захиргаа санхүү, аж ахуй хариуцсан дарга	Тэнхим лаборатори төвийн эрхлэгч
Маш сайн	13.9	9.7	5.3	8.0	5.4	6.3
Сайн	38.1	38.1	24.7	25.6	21.6	17.4
Дунд зэрэг	29.0	29.0	29.6	27.6	28.2	16.5
Хангалтгүй	7.3	7.3	8.4	7.8	20	4.2
Муу	3.1	3.1	3.1	3.4	4.3	2.1
Мэдэхгүй	8.6	8.6	29.0	27.6	32.9	19.0
Нийт хувь	100	100	100	100	100	100

эрхлэгчдэд 17.4 хувь нь сайн гэж тус тус хариулжээ. (Дэлгэрэнгүй үр дүнг хүснэгт 1-д харуулав) Мөн алба хэлтсийн дарга, захиргаа санхүү аж ахуй хариуцсан дарга, сургалтын албаны дарга нарын мэргэжлийн ёс зүйг судалгаанд оролцогчдын 30% орчим нь мэдэхгүй гэж хариулсан нь анхаарал татлаа.

Их, дээд сургуулиуд ёс зүйн хороотой эсэх тэдгээр нь хэрхэн ажиллагдийг тодруулахад судалгаанд оролцогчдын 45 хувь нь ёс зүйн хороо байдаг боловч байнгын ажиллагаагүй, 24.8 хувь нь тийм, байнгын ажиллагаатай, 21 хувь нь мэдэхгүй, 9 хувь нь ёс зүйн хороо байхгүй гэж хариулжээ. Мөн удирдах албан тушаалтантай холбоотой ямар нэг асуудлаар ёс зүйн хороонд хандаж асуудлаа шийдвэрлүүлж байсныг тодруулахад 74.4 хувь нь үгүй буюу ёс зүйн хороонд хандаж байгаагүй, 9 хувь нь 1,2 удаа хандсан, 7.5 хувь нь санахгүй байна, 4.7 хувь нь ёс зүйн хороо байхгүй учраас хандах боломжгүй, 3.5 хувь тийм байнга хандаг, 0.5 хувь нь хандах бодолтой байдаг, 0.3 хувь нь хандах бодолгүй гэж хариулжээ. Мөн нэг, хоёр удаа цөөн хандсан, санахгүй тохиолдол, ёс зүйн хороо байхгүй учраас өргөдөл, гомдол гаргах боломжгүй гэж нийт судалгаанд оролцогчдын 10.7 хувь хариулжээ.

Судалгаанд оролцогчид ёс зүйн дүрэмд тусгагдсан удирдах ажилтны нийтлэг хэм хэмжээг үнэлэхдээ ажлын хариуцлага, идэвх санаачилга, ажлын цаг баримталж, үр өгөөжтэй, бүтээлч ашигладаг байдал нь “сайн”, мэдээллийг нээлттэй, ил тод нийтэд хүргэдэг байдал, таатай эерэг уур

амьсгал бүрдүүлдэг байдал зэрэг нийтлэг хэм хэмжээг “дунд зэрэг”, ажилчдаас тавьж буй шүүмжлэл, шаардлагыг хүлээн авч, тайлбар өгдөг байдал “мэдэхгүй” гэж үзжээ. Ёс зүйн дүрэмд тусгагдсанаар удирдах ажилтны хориглосон хэм хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ дийлэнх асуултад “мэдэхгүй” гэж хариулжээ. Ёс зүйн дүрэмд тусгагдсанаар удирдах ажилтны тусгай хэм хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “дунд” гэж үнэлжээ.

Судалгааны найдвартай байдлын шинжилгээ:

Судалгааны үр дүнг SPSS 26 программ дээр найдвартай байдлын шинжилгээ, дескриптив анализ, корреляцийн шинжилгээ, хи-квадрат тест ашиглан боловсруулаа. Судалгаанд нарийвчилсан шинжилгээ хийхийн өмнө судалгааны өгөгдлийн найдвартай байдлыг хэмжиж үзэхэд кронбах альфа коэффициент 0.886 буюу хангалттай найдвартай байна.

Reliability Statistics	
Cronbach's Alpha	N of Items
.866	31

Судалгаанд оролцогчид ёс зүйн дүрэмд тусгагдсан удирдах ажилтантай холбоотой ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг 65.9% нь ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг дунд зэрэг, 18.3% нь сайн, 1.4% нь маш сайн, 14.2% нь хангалтгүй, 0.3% нь муу гэж үнэлжээ.

Судалгаанд оролцсон багш нарын удирдах ажилтны ёс зүй хэм хэмжээг үнэлсэн үнэлгээ болон ёс зүйн хэм хэмжээн хэрэгжилт хоорондоо

Хүснэгт 2. Удирдах ажилтны ёс зүй хэм хэмжээний манлайлал нь тухайн сургуулийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн хамаарал

Correlations				
		Хэрэгжилт	Удирдлагын ёсзүй	
Хэрэгжилт	Correlation Coefficient	1.000	.132**	
	Sig. (2-tailed)	.	.000	
	N		738	
Kendall's tau b	Correlation Coefficient		1.000	
	Sig. (2-tailed)		.	
	N			

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

ямар хамааралтай байгааг корреляцийн шинжилгээгээр тодруулав. Тус шинжилгээний үр дүнд кендал тау-б корреляцийн коэффициент 0.132 буюу хамаарал эерэг сул байна. Энэ нь удирдах албан тушаалтныг үнэлсэн үнэлгээ болон ёс зүйн хэм хэмжээн хэрэгжилт хоорондоо хамааралтай. Хамаарал нь эерэг буюу удирдах албан тушаалтныг үнэлэх үнэлгээ нэмэгдэхэд ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт дагаад нэмэгдэнэ, харин тэрхүү хамаарлын хүч сул байна.

Ёс зүйн хэм хэмжээн хэрэгжилт нь тухайн сургууль ёс зүйн хороотой эсэхээр ялгаатай байгааг хи-квадрат тест ашиглан шинжлэв. Ёс зүйн хэм хэмжээн хэрэгжилт маш сайн гэж хариулсан 10 оролцогчийн 9 нь тийм байнгын ажиллагаатай гэж хариулсан байна.

Эндээс ёс зүйн хороотой эсэх нь ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд нөлөөлж байгаа эсэхийг шинжилж үзэхэд хи-квадрат тестийн P утга 0.000 буюу ач холбогдол бүхий ялгаатай гарч байна. (Sig<0.05) Энэ нь тухайн сургууль ёс зүйн хороотой эсэх, ёс зүйн хорооны үйл ажиллагаа явагдаж байгаа эсэх нь ёс зүйн хэрэгжилтэд нөлөөлж байна .

Дүгнэлт: Сургуулийн ёс зүйн хорооны үйл

ажиллагаа нь тогтвортой байх нь ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлдэг болох нь тус судалгааны үр дүнгээр харагдав.

Ном зүй:

1. АШҮҮИС-ийн ёс зүйн дүрэм. УБ., 2006
2. Ач АУИС-ийн багш, ажилтны ёс зүйн журам. УБ., 2020
3. Гурван-Эрдэнэ багшийн дээд сургуулийн багшийн ёс зүйн дүрэм. УБ., 2006
4. Монгол улсын их сургуулийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм. УБ.,
5. МУБИС-ийн ёс зүйн дүрэм. УБ., 2016
6. Наранчимэг, Н., Төгөлдөр, Э (2010). Боловсролын удирдлага. УБ.
7. ХААИС-ийн ажиллагсдын ёс зүйн дүрэм. УБ., 2015
8. ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм. УБ., 2015
9. Vilmaz, E. (2006). To investigate the effect of school managers ethical leadership levels on the organizational trust level and to test whether the organizational trust level inschools differentiate with respect to some variables or not. Unpublished doctoral dissertation, Institute of Social Sciences, Selcuk University, Konya, Turkey 2010

THE RESULTS OF STUDYING THE IMPLEMENTATION OF DIMENSIONS RELATED TO ADMINISTRATIVE STAFF IN THE CODE OF ETHICS OF HIGHER EDUCATION INSTITUTIONS

Summary: It will explain the content of the value of “fulfilling ethical norms” by the executive officer of the higher education institution, and in doing so, will study the implementation of the ethical norms related to the administrative officer in the code of ethics of the higher education institution.

The research was carried out in ten public and private universities. Using a questionnaire method to collect quantitative research data, the results were summarized by statistical processing.

The results of the study showed that stability of the school ethics committee’s activities increases the possibility of implementing ethical norms.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАРЫН ЗАРИМ АСУУДАЛД

Б.Уянга¹, М.Үзмээ², О.Болорсайхан²

¹АШУҮИС, Сувилахуйн сургууль

²АШУҮИС, Био-Анагаахын сургууль
uyanga@mnumns.edu.mn

ТОВЧ УТГА

Өнгөрсөн 20-оод жилийн хугацааны янз бүрийн хүчин зүйлийн нөлөөлөл нь Чанарын дотоод баталгаажилтыг дэлхийн дээд боловсролын шинэчлэлд баримтлах үндсэн чиг хандлага болоход нөлөөлөв^[1].

Бид суралцагч буюу хэрэглэгчийн таамаглаж байсан үйлчилгээний хүсэл, бодитоор хүлээж авсан үйлчилгээний сэтгэгдэл хоёрын зөрүүг багасгахын тулд суралцагчдаас асуумж судалгаа авч чанарыг үнэлэх, тодорхойлох үнэлгээний SERVQUAL загварыг үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Дээд боловсролын тогтолцоо хурдацтайгаар хөгжиж өдрөөс өдөрт даяарчлагдаж буй энэ үед Европын холбоо, АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй улс орон төдийгүй Хятад, Өмнөд Африк, Ираны их сургуулиуд сургалтын үйлчилгээний чанарыг тодорхойлон үнэлэх үндсэн аргуудын нэг нь SERVQUAL загварыг гэж үзэж байна. Иймд бидний судалгааны ажлын зорилго дэлхий нийтэд өргөнөөр ашиглаж буй SERVQUAL (Model of Service Quality) загвараар их сургуулийн сургалтын үйлчилгээний чанарыг тодорхойлоход оршино.

Судалгааг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар, дескриптив загвараар АШУҮИС-ийн 7 бүрэлдэхүүн 3 салбар сургуульд суралцаж буй 1-6 дугаар дамжааны 16-49 насны 2567 оюутан үүнээс эрэгтэй оюутан 384 (15%), эмэгтэй оюутан 2183 (85%)-ыг хамруулан хийж гүйцэтгэв. SERVQUAL асуумжаар сургалтын үйлчилгээ чанарыг салбар болон бүрэлдэхүүн сургуулиудад тодорхойлоход харилцан адилгүй үр дүн гарсан бөгөөд бүрэлдэхүүн болон салбар сургуулийн үйлчилгээний чанар сөрөг гарсан байна. Хамгийн бага буюу хамгийн их сөрөг үйлчилгээний чанар нь

-0.47 гарсан бөгөөд таамаглал болон сэтгэгдлийн хоорондын ялгаа нь мэдэгдэхүйц ялгаатай гарсан байна. Сургалтын үйлчилгээг хүргэх явцад багш, суралцагчийн харилцан уялдаа холбоо, нягтралыг сайжруулах, харилцаа хандлагыг илүүтэй анхаарах нь сэтгэгдэл, таамаглалын зөрүүг багасгах үндэс болно.

Удиртгал

Анагаахын боловсролын шинэчлэл, нийгмийн хэрэгцээний өөрчлөлтэй уялсан сургалтын агуулга, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн шинэчлэлт өөрчлөлт зогсолтгүй явагдсаар байна^[2].

“Оролцож байгаа бүх талууд сэтгэл ханамжтай байвал чанар гэнээ” гэж үзэх болсон. Үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нь хоорондоо салшгүй холбоотой юм. Үйлчлүүлэгч (суралцагч)-ийн сэтгэл ханамж нь үйлчилгээний чанарыг сайжруулах хамгийн чухал зохион байгуулалт. Мөн дараах 3 зүйл: үнэ өртөг, хамаарал, тэгш байдал зэрэг нь сэтгэл ханамжид давхар нөлөөлдөг^[3].

Үйлчлүүлэгчийн таамаглал болон сэтгэгдлийг үнэлсэн үнэлгээгээр үйлчилгээний үр дүн болон үйл явцыг мөн хэмжиж болно. Үр дүн гэдэгт тухайн үйлчилгээг хийж дуусгасан эсэх хамаарах бол үйл явц хэмээх ухагдахуунд үйлчлүүлэгчидтэй хэрхэн мэндчилж, анхаарал халамж тавьсан зэрэг ойлголт багтана. Үр дүн болон үйл явцыг таван үндсэн үзүүлэлтээр хэмжинэ. Үр дүнг бодит байдал буюу тухайн үйлчилгээг цэгцтэй сайн дуусгасан эсэх үзүүлэлтийг хамааруулна. Харин үйл явцыг үйлчилгээний чанарыг үнэлэх дараах дөрвөн үзүүлэлтээр хэмжинэ. Үүрэг хариуцлага нь ажилтнуудын үйлчлүүлэгчдэд туслах эрмэлзэл болон зохистой үйлчилгээ үзүүлэх үр чадварыг харуулна. Итгэл үнэмшил нь ажилтнуудын байгууллагын талаарх мэдлэг, үйлчлүүлэгчидтэй

харьцах харьцаа, итгэл төрүүлэх чадварыг харуулна. Анхаарал халамж нь үйлчлүүлэгчдэд ганцаарчлан анхаарал халамж тавих ур чадварыг харуулна. Биет байдалд нь барилга байгууламжийн өнгө үзэмж, тоног төхөөрөмж, бусад хэрэгцээт материалууд хамаарна^[4].

1985 онд АНУ-ын Миамийн Их сургуулийн профессор А.Парасураман анх үйлчилгээний чанарыг судлах зорилгоор энэхүү (Model of Service Quality) загвар аргачлалыг боловсруулан улам боловсронгуй болгон зарим нэг өөрчлөлтийг оруулж 27 асуулттай таамаглал, сэтгэгдэл бүхий 2 бүлэг, 5 үндсэн үзүүлэлттэй асуулга болгон сургалтын үйлчилгээний чанарыг тодорхойлохдоо ашиглаж байна. Ингэснээр судлаачид үйл ажиллагааны чанарыг нэг хэмжээст хэмжүүрээр үнэлж байсныг чанар гэх олон хэмжээст ойлголтыг олон үзүүлэлтээр үнэлэх боломж бүрдсэн. Энэ судалгаа нь сайжруулах шаардлагатай байгаа газрыг тодорхойлох, эсвэл нөөц хангамжийг хэрхэн сайн ашиглаж байгааг тодорхойлоход тусална^[5].

Зорилго

АШУУИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургуулийн сургалтын үйлчилгээний чанарыг SERVQUAL (Model of Service Quality) загвараар тодорхойлох нь

Зорилт

1. SERVQUAL (Model of Service Quality) загвараар сургалтын үйлчилгээний чанарыг АШУУИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургууль тус бүрээр судлах
2. SERVQUAL (Model of Service Quality) загвараар сургалтын үйлчилгээний чанарыг таван үзүүлэлт (биет байдал, бодит байдал, үүрэг хариуцлага, итгэл үнэмшил, анхаарал халамж)-ээр тодорхойлох.
3. Сургалтын үйлчилгээний чанар үр дүн, үйл явцыг АШУУИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургууль тус бүрээр харьцуулан судлах

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар, дескриптив загвараар 7 бүрэлдэхүүн 3 салбар сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтад суралцаж буй 2567 оюутан хамрагдсан болно.

SERVQUAL загвар нь таамаглал, сэтгэгдэл гэсэн

хоёр бүлэг 27 параллель асуулттай, асуулт тус бүр нь Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл оноогоор үнэлүүлж сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлов.

Үр дүн

Судалгааг АШУУИС-ийн 7 бүрэлдэхүүн 3 салбар сургуульд суралцаж буй 1-6 дугаар дамжааны 16-49 насны 2567 оюутан үүнээс эрэгтэй оюутан 384 (15%), эмэгтэй оюутан 2183 (85%)-ыг хамруулан хийж гүйцэтгэв.

SERVQUAL асуумж судалгаанд төгсөлтийн өмнөх сургалтад хамрагдаж буй Анагаах ухааны сургуулийн 714 (27.8%), Био-Анагаахын сургуулийн 602 (23.5%), Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн 123 (4.8%), Нүүр ам судлалын сургуулийн 147 (5.7%), Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн 135 (5.3%), Сувилахуйн сургуулийн 317 (12.3%), Эмзүйн сургуулийн 104 (4.1%), Говь алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 109 (4.2%), Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 196 (7.6%), Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 120 (4.7%) оюутнууд үүнээс 1 дамжааны 845 (32.9%), 2 дамжааны 415 (16.2%), 3 дамжааны 468 (18.2%), 4 дамжааны 451 (17.6%), 5 дамжааны 209 (8.1%), 6 дамжааны 179 (7.0%) оюутнууд хамрагдсан байна.

Хэлцэмж

SERVQUAL загвар нь сургалтын үйлчилгээний чанарыг урьдчилсан нөхцөлт 27 параллель асуулттай, ликертийн хэмжүүрээр 0-5 оноогоор үнэлүүлэхээр хийгдсэн ба энэ нь итгэл үнэмшил (5 хэсэг), үүрэг хариуцлага (5 хэсэг), анхаарал халамж (6 хэсэг), бодит байдал (7 хэсэг), биет байдал (4 хэсэг) зэргийг үнэлэхээр тогтсон байна. Энэхүү асуулгыг Kebriaei and Roudbari нар Ираны Zahedan их сургуулийн Анагаахын сургуулийн оюутнуудаас жишээ болгон судалжээ.

Дүгнэлт

1. Сургалтын үйлчилгээ чанарыг салбар болон бүрэлдэхүүн сургуулиудад тодорхойлоход харилцан адилгүй үр дүн гарав.
2. Боловсролын үйлчилгээний чанар үйлчлүүлэгчийн таамагласан түвшинд хүрэхгүй байгаа нь биет байдалтай (тухайн сургуулийн сургалтын технологийн шинэчлэл) шууд, эерэг ($r=0,723$) хүчтэй, анхаарал халамж (оюутны

сурах үйл ажиллагааг чиглүүлэх, багшийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа)-тай шууд, эерэг ($r=0,684$) дунд зэргийн хамааралтай байна.

сургалтын үйлчилгээг хүргэх явцад багш, суралцагчийн харилцан уялдаа холбоо, нягтралыг сайжруулах, харилцаа хандлагыг илүүтэй анхаарах нь сэтгэгдэл, таамаглалын зөрүүг багасгах үндэс болно.

3. Салбар болон бүрэлдэхүүн сургуулиуд

АШҮҮИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургуулийн сургалтын үйлчилгээний чанарыг үнэлсэн байдал

Хүснэгт 1

	Үзүүлэлт	T*	C**	C-T***	Paired	T-Test	α^{****}
					t	p	
Итгэл үнэмшил		3.82	3.52	-0.30			0.88
1	Сургалт нь бидэнд багаар ажиллах, харилцан ярилцаж, задлан шинжлэх үр чадвараа нэмэгдүүлэхэд тусалдаг	3.72	3.45	-0.27	16.8	<0.001	
2	Суралцагчийн ирээдүйн ажил, ажлын байранд мэргэшүүлдэг	3.85	3.54	-0.31	19.8	<0.001	
3	Багш нар хичээлийн бус цагаар суралцагчдын асуултад хариулж, зөвлөгөө өгдөг	3.54	3.18	-0.36	20.0	<0.001	
4	Суралцагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хангалттай мэдээллийн эх үүсвэртэй	3.74	3.38	-0.36	21.9	<0.001	
5	Багш, ажилчдын мэргэжлийн мэдлэг, үр чадвар хангалттай	4.26	4.08	-0.18	14.8	<0.001	
Үүрэг хариуцлага		3.42	3.03	-0.39			0.91
6	Багш нар суралцагчдад шаардлагатай үед нь цаг зав зарцуулдаг	3.64	3.29	-0.35	20.6	<0.001	
7	Суралцагчид сургалтын хөтөлбөрийн талаар сургуулийн удирдлагад санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг	3.28	2.81	-0.47	24.0	<0.001	
8	Суралцагчдын санал сэтгэгдлийг сургалтын хөтөлбөрт тусгадаг	3.30	2.87	-0.42	22.7	<0.001	
9	Нэмэлт мэдээлэл, гарын авлагаар хангадаг	3.52	3.19	-0.33	20.2	<0.001	
10	Сургалттай холбоотой асуудлаар багш, суралцагчдад ярилцах тогтмол цаг байдаг эсэх	3.35	2.98	-0.37	21.5	<0.001	
Анхаарал халамж		3.70	3.42	-0.28			0.89
11	Хичээлийн даалгавар ойлгоход хялбар, биелүүлэх боломжтой байдаг	3.65	3.42	-0.23	16.5	<0.001	
12	Суралцагчид онцгой нөхцөл байдал тулгарсан үед багш нар уян хатан ханддаг	3.55	3.24	-0.31	18.2	<0.001	
13	Хичээллэх цаг тохиромжтой байдаг	3.82	3.66	-0.16	13.5	<0.001	
14	Сургуульд хичээл унших тохиромжтой нам гүм, тухтай газар байдаг	3.53	3.06	-0.47	24.0	<0.001	
15	Сургуулийн ажилчид суралцагчидтай зөв боловсон харилцдаг	3.75	3.50	-0.26	17.9	<0.001	

16	Багш нар суралцагчидтай зөв боловсон харилцаг	3.90	3.65	-0.25	17.7	<0.001	
Бодит байдал		3.76	3.47	-0.29			0.92
17	Хичээлд шаардагдах материалаар тогтмол хангадаг	3.68	3.37	-0.31	20.7	<0.001	
18	Шалгалтын дүнг суралцагчдад мэдээлдэг	3.81	3.50	-0.31	20.0	<0.001	
19	Сургалтын ном товхимол ойлгомжтой байдаг	3.79	3.49	-0.29	20.4	<0.001	
20	Суралцагчдын идэвх чармайлыг үнэлж нэмэлт оноо өгдөг	3.68	3.38	-0.30	18.6	<0.001	
21	Суралцагчийн сургалтын явц, дүн алдаагүй тэмдэглэгддэг	3.85	3.62	-0.22	16.4	<0.001	
22	Сургуульд байдаг ном товхимол, гарын авлага, мэдээллийн хэрэгслүүдийг олж хэрэглэхэд хялбар	3.59	3.23	-0.36	22.3	<0.001	
23	Сургуулийн багш ажилчид цаг барьдаг, товлосон цагтаа ажил үүргээ гүйцэтгэдэг	3.92	3.71	-0.22	16.5	<0.001	
Биет байдал		3.88	3.64	-0.25			0.91
24	Багш нарын биеэ авч явах байдал, гадаад дүр төрх	4.18	4.12	-0.06	7.2	<0.001	
25	Анги танхимын өнгө үзэмж, тав тух	3.87	3.56	-0.31	21.3	<0.001	
26	Сургалтын материал, техник технологи, багаж хэрэгслийн шинэчлэлт	3.72	3.38	-0.34	21.6	<0.001	
27	Сургалтад хэрэглэгддэг багаж хэрэгслийн өнгө үзэмж	3.77	3.49	-0.28	20.0	<0.001	
Бүгд		3.72	3.42	-0.30			

*Таамаглал, **Сэтгэгдэл, ***Зөрүү оноо, ****Кронбах альфа

SERVQUAL загварын 5 үзүүлэлтээр АШУҮИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургуулийг нэгтгэн гаргасан байдал

Хүснэгт 2

Сургууль	Итгэл үнэмшил		Үүрэг хариуцлага		Анхаарал халамж		Бодит байдал		Биет байдал		Н		Ч	
	T*	C**	T*	C**	T*	C**	T*	C**	T*	C**	T*	C**	T*	C**
АУС	3.77	3.35	3.31	2.76	3.63	3.27	3.67	3.27	3.91	3.63	3.66	3.26	-0.40	-0.36
БАС	3.95	3.69	3.57	3.21	3.82	3.56	3.91	3.65	4.04	3.82	3.86	3.59	-0.27	
МАУОУС	3.69	3.32	3.29	2.82	3.60	3.25	3.63	3.22	3.92	3.76	3.63	3.27	-0.35	
НЭМС	3.89	3.54	3.47	3.03	3.69	3.42	3.77	3.44	3.82	3.48	3.73	3.38	-0.35	
НАСС	3.79	3.33	3.45	2.87	3.74	3.33	3.74	3.34	3.77	3.21	3.69	3.21	-0.48	
СС	3.73	3.52	3.34	3.04	3.57	3.31	3.66	3.45	3.67	3.43	3.59	3.35	-0.24	
ЭЗС	3.95	3.55	3.49	3.03	3.72	3.33	3.84	3.47	3.97	3.61	3.80	3.40	-0.40	
ГААУС	3.70	3.56	3.38	3.27	3.61	3.49	3.65	3.56	3.74	3.67	3.62	3.51	-0.11	-0.09
ДААУС	3.83	3.75	3.47	3.37	3.80	3.72	3.86	3.77	3.89	3.78	3.77	3.68	-0.09	
ДГАУС	3.79	3.78	3.40	3.30	3.80	3.75	3.79	3.71	3.75	3.68	3.71	3.64	-0.06	

АШУУИС 3.82 3.52 3.42 3.03 3.70 3.42 3.76 3.47 3.88 3.64 3.72 3.42 -0.225

Дээрх үр дүнгээс харахад сургалтын чанарыг салбар болон бүрэлдэхүүн сургуулиудад тодорхойлоход харилцан адилгүй үр дүн гарав.

АШУУИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургуулийн оюутны сэтгэгдэл, таамаглал, үйлчилгээний чанарын дундаж түвшнийг SERVQUAL загварын 5 үзүүлэлтээр гаргасан байдал

Хүснэгт 3

Сургууль	Таамаглал	Сэтгэгдэл	Үйлчилгээний чанар	Р
АУС	(3.65±0.71)	(3.24±0.67)	(-0.41±0.58)	<0.001
БАС	(3.86±0.6)	(3.58±0.63)	(-0.27±0.47)	<0.001
МАУОУС	(3.61±0.68)	(3.25±0.56)	(-0.36±0.61)	<0.001
НЭМС	(3.73±0.7)	(3.38±0.64)	(-0.34±0.52)	<0.001
НАСС	(3.7±0.65)	(3.23±0.61)	(-0.47±0.64)	<0.001
СС	(3.59±0.64)	(3.35±0.56)	(-0.24±0.48)	<0.001
ЭЗС	(3.79±0.65)	(3.39±0.6)	(-0.4±0.63)	<0.001
ГА-АУС	(3.62±0.59)	(3.51±0.53)	(-0.11±0.35)	<0.001
ДА-АУС	(3.77±0.56)	(3.68±0.55)	(-0.09±0.32)	<0.001
ДГ-АУС	(3.71±0.54)	(3.65±0.59)	(-0.06±0.4)	<0.001
Үйлчилгээний чанарын нийт дүн	(3.71±0.65)	(3.41±0.64)	(-0.3±0.53)	<0.001

SERVQUAL асуумж бүрэлдэхүүн болон салбар сургуулийн үйлчилгээний чанар сөрөг гарсан байна. Хамгийн бага буюу хамгийн их сөрөг үйлчилгээний чанар нь -0.47 гарсан бөгөөд таамаглал болон сэтгэгдлийн хоорондын ялгаа нь мэдэгдэхүйц ялгаатай гарсан байна.

Pearson корреляциар SERVQUAL загварын 5 үзүүлэлтийн хоорондын хамаарлын хүчийг харуулсан байдал

Хүснэгт 4

	1	2	3	4	5	6
Итгэл үнэмшил	.643**					
Үүрэг хариуцлага	.515**	.590**				
Анхаарал халамж	.514**	.461**	.684**			
Бодит байдал	.529**	.473**	.577**	.684**		
Биет байдал	.455**	.389**	.490**	.506**	.723**	
Үйлчилгээний чанар	.328**	.417**	.322**	.343**	.266**	1

$p < 0,001$. сул* (0. – 0.3); дунд ** (0.3 – 0.7); хүчтэй *** (0.7 – 1.0).

Биет байдал, биет байдлын хооронд шууд, эерэг ($r=0,723$) хүчтэй, бодит байдал анхаарал халамжийн хооронд шууд, эерэг ($r=0,684$) дунд зэргийн хамааралтай бөгөөд энэ нь статистикийн үнэн магадтай байна ($p < 0,001$). Бусад хүчин зүйлүүд шууд ($r=0,389-0,643$) дунд зэргийн хамааралтай, бөгөөд нь статистик ач холбогдол бүхий үнэн магадтай байна.

АШУУИС-ийн 7 бүрэлдэхүүн, 3 салбар сургуулийн сургалтын үйлчилгээний үр дүн, SERVQUAL загварын 5 үзүүлэлтээр гаргасан байдал

Хүснэгт 5

	Үзүүлэлт	Таамаглал	Сэтгэгдэл	Үйлчилгээний чанар	P
Үр дүн	Бодит байдал	3.76	3.47	-0.29	P<0.001
Үйл явц	Итгэл үнэмшил	3.71	3.40	-0.30	P<0.001
	Үүрэг хариуцлага				
	Анхаарал халамж				
	Биет байдал				

Үр дүн (-0.29) буюу үйл явц (-0.30)-ийг илтгэх үйлчилгээний чанарын утга нь сөрөг гарсан. Ялангуяа сургалтын үйлчилгээг хүргэх явцад олон талуудын харилцан уялдаа холбоо, нягтралыг сайжруулах, харилцаа хандлагыг илүүтэй анхаарах нь үйл явцаар дамжин биет бус үйлчилгээг хүртсэний дараах бодитоор хүлээж авсан сэтгэгдэл, таамаглалын зөрүүг багасгах үндэс болно (P<0.001).

Ном зүй

1. Чанарын дотоод баталгаажуулалт: Дээд боловсролын чанарыг сайжруулах, төгсөгчийн хөдөлмөр эрхлэх байдлыг нэмэгдүүлэх 2019 он
2. Ц.Лхагвасүрэн, О.Болорсайхан. Монгол улсад эмч бэлтгэх анагаах ухааны боловсролын хөгжил, шинэ үзэл баримтлал 2021 он
3. Bolorsaikhan Omboosuren, Otgontsetseg.O, Purevdorj Tsedен, Dalkh Tserendagva "Results of the service quality survey of the nursing schools", New medicine Mar, 2012
4. B Omboosuren, M Tseveenmyadag, D Tserendagva, T Purevdorj, Quality Gaps in Educational Services in State Health Colleges: Viewpoints of Students, Medical Education 2012 Blackwell Publishing Ltd. MEDICAL EDUCATION 2012;46 (Suppl. 2)
5. Berry LL. Relationship marketing of services-Growing interest, emerging perspectives. Journal of the Academy of Marketing sciences. 1995; 26:767-86.

STUDYING FOR TEACHER EVALUATION IN MEDICAL SCHOOL STUDENTS

Abstract

Over the past 20 years, the impact of various factors has made the internal quality assurance the main trend in higher education reform around the world. We are using the SERVQUAL model to assess and determine the quality through questionnaire in order to reduce the gap between the customers' expected service and received service

Currently, nowadays the higher education system is developing rapidly and becoming increasingly globalized day by day, universities in developed countries such as the European Union, the United States, and Japan, as well as universities in China, South Africa, and Iran, consider the SERVQUAL model to be one of the main methods for determining the quality of educational services.

Therefore, the purpose of our research is to determine the quality of university education services using the SERVQUAL (Model of Service Quality) model, which is widely used around the world.

The research was conducted by random sampling and descriptive model, total of 2567 students, which including 384 (15%) male students and 2183 (85%) female students from 1st to 6th year studying in 3 branch and 7 component schools of Mongolian National University of Medical Sciences.

Using the SERVQUAL questionnaire, there were different results in determining the quality of teaching services in branch and component schools, and the quality of service in branch and component schools were negative.

The maximum negative service quality was -0.47, and the difference between predictions and comments was significant.

In the process of delivering educational services, improving the interaction and density of teachers and students, paying more attention to relationships will be the basis for reducing the difference in impressions and assumptions.

ОЛОН МЭРГЭЖЛИЙН БАГТ ХАМТРАН СУРАЛЦАХУЙН АРГЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР НЭВТРҮҮЛСЭН ҮР ДҮН

Б.Азжаргал, С.Оюунцэцэг, Н.Сүмбэрзул
АШУУИС, СС
azjargal.b@mnums.edu.mn

Товч утга

Зорилго: Хамтран суралцахуйн аргыг олон мэргэжлийн багт цахим хэлбэрээр туршин судлах

Арга, аргачлал: Судалгааны ажлын үр дүнгийн хүснэгт, дүрслэлийг Microsoft Office 2016 иж бүрдэл, статистик боловсруулалтыг SPSS-25.0 программ программаар хийж гүйцэтгэсэн. Судалгааны мэдээ мэдээллийн өгөгдлийг кодлон шивж, алдааг шалгасны дараа үр дүнг ашиглан тоон мэдээллийн боловсруулалтыг хийсэн ба дундаж утга болон хазайлтыг тодорхойлж, судалгааны зорилтын хүрээнд таамаглал дэвшүүлэн, тохирох статистик аргуудаар (t, ANOVA, Chi-Square, Spearman корреляци) шалган асуумж судалгааны үр дүнд түүвэрлэлтийн зохистой хэмжээг Kaiser-Meyer-Olkin-ий индексээр, хүчин зүйл хоорондын ялгааг Bartlett Sphericity Chi Square индексээр тодорхойлсон. Туршилтын өмнөх болон дараа онооны дундаж, ялгаатай байдлыг Kruskal Wallis тест болон Wilcoxon matched тестээр тооцож, бүх үр дүнгийн хувьд статистик үнэн магадлалыг 95 хувийн ($p < 0.05$) магадлалаар баталгаажуулсан.

Үр дүн: Туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад хандлага ($P < 0.05$, $P < 0.001$), хамтран суралцахуйд бэлтгэгдсэн байдал ($P < 0.05$), хамтын ажиллагаа ($P < 0.05$), багийн чадавч ($P \leq 0.05$), багийн чадамж ($P < 0.05$). Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн чадамж 3.5 – аас их, ($P < .001$), багийн хамтын ажиллагаа ($P < 0.05$, $P < 0.001$) статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна.

Түлхүүр үг: Чадамж, олон мэргэжлийн баг, хамтран суралцахуй, хандлага, өөрчлөлт

Дүгнэлт: Хамтран суралцахуйн аргыг олон мэргэжлийн багт цахим хэлбэрээр нэвтрүүлэхэд хандлага, чадамж, хамтын ажиллагаа, чадавч,

харилцаа, үнэ цэнэ ёс зүй, үүрэг хариуцлага, багийн ажиллагааны хандлага эергээр өөрчлөгдсөн байна.

Удиртгал

Эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх анагаах ухааны боловсролыг хувирган өөрчлөх хэрэгцээ шинэ зуунд бий болсон тухай олон улсын судлаачид дүгнэн, сургалтын арга, эмнэл зүйн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх шаардлагыг цохон тэмдэглэсэн байна.

Анагаах ухааны боловсролын хувирган өөрчлөх шинэчлэлд мэргэжил хоорондын хамтран суралцахуйн арга зүйг боловсрол судлаачид дэлхий дахинаа санал болгож байна.

Мэргэжил хоорондын хамтран суралцахуй болон багийн хамтын ажиллагаа нь суралцах явцдаа эмчлүүлэгчдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний туршлагыг бий болгох, орон нутаг, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртгийг бууруулах, үйлчилгээ үзүүлэгчдийн ажлын туршлагыг сайжруулах гэсэн үндсэн дөрвөн чиглэлийг гол зорилго болгодог [1]. (Бервик, Нолан, & Уиттингтон, 2008; Брандт, Лутфия, Кинг, & Chioreso, 2014). Эрүүл мэндийн оношилгоо, менежментийн нарийн төвөгтэй байдал, технологийн дэвшил нэмэгдэж байгаа энэ үед мэргэжил хоорондын хамтран суралцахуй болон багийн хамтын ажиллагаа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүд, түүний түншүүд хооронд үр дүнтэй хамтын ажиллагааны эрэлт хэрэгцээг улам бүр нэмэгдсэнтэй холбоотойгоор шийдвэрлэх гарц болж байгааг дурдсан байна^[2].

Мэргэжил хоорондын хамтран суралцахуй болон багийн хамтын ажиллагааны эрүүл мэндийн

салбарт үзүүлэх ач холбогдлын өнөөгийн хэрэгцээ нь тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад үзүүлэх нөлөөг тодорхойлсон шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо бүхий судалгааны ажлууд шаардлагатай байгааг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг бууруулах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хомсдол бий болсонтой холбогдуулан эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны байдал, тэдний уян хатан буюу хөрвөх чадвар, ажлын туршлага зэрэгт оршиж буйг дурдаад энэхүү хэрэгцээ нь хүн амын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх ач холбогдолтойг Лутфия нарын судалгаанд өгүүлсэн байна^[3].

Судалгааны ажлын зорилго

Хамтран суралцахуйн аргыг олон мэргэжлийн багт цахим хэлбэрээр туршин судлах

Судалгааны шинэлэг тал

Хамтран суралцахуйн аргыг олон мэргэжлийн багт туршин судалснаар анагаахын шинжлэх ухаанд эмнэл зүйн сургалтын хувирган өөрчлөх боловсролд хувь нэмэр оруулах нотолгоог бий болгож байгаагаараа шинэлэг тал болж байна.

Судалгааны хэрэглэгдэхүүн арга зүй

Судалгааны хамрах хүрээ: Туршилтын бүлэг нэг бүрд их эмч 1, эм зүйч 1, эх баригч 2, сувилагч 2 гэсэн бүрэлдэхүүнээр хуваарилсан 3 бүлгийг, хяналтын бүлэгт их эмч 1, эм зүйч 1, эх баригч 2, сувилагч 2 гэсэн бүрэлдэхүүнээр хуваарилсан 3 бүлгийг санамсаргүй байдлаар хуваарилан хамруулсан.

Судалгааны арга: Судалгааны ажлын зорилгын хүрээнд мэдээ, мэдээллийг тоон судалгааны аргаар цуглуулсан.

Мэдээ материал цуглуулсан байдал: Эмнэл зүйн тохиолдол дээр семинарыг тусгайлан жижиг бүлгээр цахим орчинд Google Meet платформыг ашиглан сургалтыг удирдан явуулсан ба үр дүнгийн харьцуулалтыг сургалтын өмнөх болон дараах шалгуураар харьцуулан судлан, хяналтын бүлэгт уламжлалт сургалтын аргаар мэргэжил тус бүрийн хэсэгт уламжлалт удирдамжийн дагуу хичээлийг явуулан, хавсралтын дагуу үр дүнг хэмжсэн.

Статистик боловсруулалт: Судалгааны ажлын үр дүнгийн хүснэгт, дүрслэлийг Microsoft Office 2016 иж бүрдэл, статистик боловсруулалтыг SPSS-25.0 программ, ном зүйн дугаарлалтыг EndNote X6 программаар хийж гүйцэтгэсэн. Судалгааны мэдээ мэдээллийн өгөгдлийг кодлон шивж, алдааг шалгасны дараа үр дүнг ашиглан тоон мэдээллийн боловсруулалтыг хийсэн ба дундаж утга болон хазайлтыг тодорхойлж, судалгааны зорилтын хүрээнд таамаглал дэвшүүлэн, тохирох статистик аргуудаар (t, ANOVA, Chi-Square, Spearman корреляци) шалган асуумж судалгааны үр дүнд түүвэрлэлтийн зохистой хэмжээг Kaiser-Meyer-Olkin-ий индексээр, хүчин зүйл хоорондын ялгааг Bartlett Sphericity Chi Square индексээр тодорхойлсон. Туршилтын өмнөх болон дараа онооны дундаж, ялгаатай байдлыг Kruskal Wallis тест болон Wilcoxon matched тестээр тооцож, бүх үр дүнгийн хувьд статистик үнэн магадлалыг 95 хувийн (p<0.05) магадлалаар баталгаажуулсан.

Үр дүн

Туршилт судалгааг төрөх үеийн тусламж үзүүлэх эмнэл зүйн тохиолдолд суурилсан багийн тусламж үйлчилгээг үйлчилгээг үзүүлэх зорилгоор туршилтын бүлэгт сонгогдсон оюутнуудыг багт хуваарилан, цахим хэлбэрийн сургалтад хамруулан, сургалтын өмнөх болон дараах сорилоор судалгааг авч, үр дүнг тооцов.

Хүснэгт 1. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн хандлагын өөрчлөлт

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Хяналтын бүлэг								
Хамтын ажиллагаа	-2.7	8.0	2.2	-7.6	2.2	-1.2	12	0.251
Хамтран суралцахуй	-3.3	13.1	3.6	-11.2	4.6	-0.9	12	0.379
Удирдлагын тогтолцоо	-1.9	9.2	2.6	-7.5	3.6	-0.8	12	0.466
Бэрхшээлүүд	1.3	6.8	1.9	-2.8	5.4	0.7	12	0.502

Туршилтын бүлэг								
Хамтын ажиллагаа	-4.3	7.3	1.6	-7.6	-1.0	-2.7	20	0.014**
Хамтран суралцахуй	-7.9	9.1	1.9	-11.9	-3.9	-4.1	21	0.001***
Удирдлагын тогтолцоо	-4.2	7.4	1.6	-7.5	-0.9	-2.7	21	0.014**
Бэрхшээлүүд	2.8	10.2	2.1	-1.6	7.2	1.3	22	0.196

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад хандлагын өөрчлөлт ажиглагдаж, статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P < 0.05$, $P < 0.001$)

Хүснэгт 2. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн бэлэн байдал

Бүлгүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Хяналтын бүлэг								
Бэлтгэл байдал	5.8	14.9	4.1	-3.3	14.8	1.4	12	0.189
Туршилтын бүлэг								
Бэлтгэл байдал	-7.7	11.0	2.5	-13.1	-2.4	-3.1	18	0.007**

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад хамтран суралцахуйд бэлтгэгдсэн байдал статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P < 0.05$)

Хүснэгт 3. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн хамтын ажиллагааны өөрчлөлт

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Хяналтын бүлэг								
Хамтын ажиллагаа								
Тодорхойлогдоогүй								
Туршилтын бүлэг								
Хамтын ажиллагаа	-3.67	7.68	1.81	-7.48	0.15	-2.03	17.00	0.05

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад хамтын ажиллагааны өөрчлөлт ажиглагдаж, статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P < 0.05$)

Хүснэгт 4. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн багийн чадварын өөрчлөлт

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Хяналтын бүлэг								
Багийн чадвар	8.87	28.79	7.43	-7.08	24.81	1.19	14	0.25
Туршилтын бүлэг								
Багийн чадвар	-4.81	11.61	2.28	-9.50	-0.12	-2.11	25	0.05

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад багийн чадвар өөрчлөгдөж, статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P \leq 0.05$)

Хүснэгт 5. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн багийн чадварын өөрчлөлт

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Хяналтын бүлэг								
Багийн чадвар	-1.94	15.88	3.97	-10.40	6.52	-0.49	15	0.633

Туршилтын бүлэг								
Багийн чадвар	-5.12	11.53	2.80	-11.04	0.81	-1.83	16	0.086

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад багийн чадвар статистикийн ач холбогдол бүхий ялгаа ажиглагдахгүй байна.

Хүснэгт 6. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн багийн чадамжийн өөрчлөлт

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Хяналтын бүлэг								
Багийн чадамж	3.00	23.40	8.27	-16.56	22.56	0.36	7	0.728
Туршилтын бүлэг								
Багийн чадамж	-10.71	16.10	3.91	-18.99	-2.43	-2.74	16.000	0.015

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад багийн чадамж өөрчлөгдөж, статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. (P<0.05)

Хүснэгт 7. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн чадамжийг тодорхойлох ажиглалт судалгааны үр дүн

Чадамж	Дундаж	95% Итгэх интервал		t	P утга	Дундаж	95% Итгэх интервал		t	P утга
		Доод	Дээд				Доод	Дээд		
Манлайлал										
1	3.33	2.79	3.87	13.23	0.000	3.92	3.54	4.30	21.56	0.000
2	3.07	2.42	3.71	10.21	0.000	3.64	3.23	4.05	18.29	0.000
Харилцаа										
8	3.73	3.24	4.22	16.36	0.000	4.6	4.36	4.84	39.84	0.000
4	3.33	2.72	3.95	11.60	0.000	4.52	4.28	4.76	38.57	0.000
5	3.00	2.31	3.69	9.27	0.000	4.52	4.25	4.79	34.60	0.000
9	3.33	2.65	4.02	10.46	0.000	4.56	4.24	4.88	29.68	0.000
Үнэ цэнэ, ёс зүй										
7	3.40	2.78	4.02	11.74	0.000	4.44	4.12	4.76	28.90	0.000
11	3.20	2.57	3.83	10.81	0.000	4.52	4.25	4.79	34.60	0.000
12	2.80	2.20	3.40	10.02	0.000	3.04	2.43	3.65	10.23	0.000
Үүрэг хариуцлага										
3	3.33	2.79	3.87	13.23	0.000	4.48	4.24	4.72	38.23	0.000
6	3.33	2.72	3.95	11.60	0.000	4.52	4.28	4.76	38.57	0.000
10	3.33	2.68	3.98	10.99	0.000	4.6	4.36	4.84	39.84	0.000
Багийн ажиллагаа										
13	3.20	2.60	3.80	11.45	0.000	4.48	4.19	4.77	31.37	0.000
14	3.53	3.03	4.04	14.95	0.000	4.56	4.24	4.88	29.68	0.000

Хүснэгтээс харахад тохиолдлын бүлэгт мэргэжил хоорондын хамтран суралцахуйн чадамж 3.5–аас бага, туршилтын бүлэгт сургалтын өмнөх болон дараах байдлыг харьцуулахад мэргэжил хоорондын хамтран суралцахуйн чадамж 3.5– аас их, статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. (P<.001)

Хүснэгт 8. Мэргэжил хоорондын хамтран суралцахуйн үр дүн

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% Итгэх интервал		t	df	P утга
				Доод	Дээд			
Туршилтын бүлэг								
Багийн үйл ажиллагаа	-33.2	3.3	0.8	-35.0	-31.4	-39	14	0.000
Ач холбогдол	1.67	2.55	0.66	0.25	3.08	2.53	14	0.02
Хэрэгжилт	2.60	4.47	1.15	0.13	5.07	2.25	14	0.04
Орчин	1.27	2.37	0.61	-0.05	2.58	2.07	14	0.05
Харилцаа	4.33	3.56	0.92	2.36	6.30	4.72	14	0.000
Баримтлах зарчим	-3.27	5.92	1.53	-6.55	0.01	-2.14	14	0.05

Хүснэгтээс харахад туршилтын бүлэгт сургалтын үр дүнд багийн хамтын ажиллагаа нь статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P < 0.05$, $P < 0.001$)

Хэлцэмж

Туршилтын болон хяналтын бүлэгт хамтран суралцахуйн аргыг цахим хэлбэрт нэвтрүүлэн, сургалтын үр дүнг олон улсын үнэлгээний хуудсаар тодорхойлоход мэргэжил хоорондын хамтран суралцахуйн, хамтын ажиллагаа түүнд хандах хандлага, багийн хамтын ажиллагаа, чадавх, чадвар, чадамжид туршилтын бүлгийн хувьд эерэг өөрчлөлт гарсан. ($P < 0.05$, $P < 0.001$) Сургалтад бэлэн байдлыг тодорхойлоход туршилтын бүлэгт статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P < 0.05$) Хамтран суралцахуйн чадамжийг туршилтын бүлэгт Жеффферсоны ажиглалтын үнэлгээний хуудсаар үнэлэхэд манлайлал, үнэ цэнэ ёс зүй, үүрэг хариуцлага, багийн ажиллагааны дундаж онооны түвшин тус бүртээ 3.5–аас их, статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна. ($P < 0.001$) Сургалтын үр дүнг үнэлэхэд багийн үйл ажиллагаа, харилцаа ($P < 0.001$), сургалтын ач холбогдол, сургалтын хэрэгжилт ($P < 0.05$) байсан бол сургалтын орчин болон зарчим ($P = 0.05$) гэсэн үр дүнг харуулсан байна.

Дүгнэлт

Хамтран суралцахуйн аргыг олон мэргэжлийн багт цахим хэлбэрээр нэвтрүүлэхэд хандлага, чадамж, хамтын ажиллагаа, чадавх, харилцаа, үнэ цэнэ ёс зүй, үүрэг хариуцлага, багийн ажиллагааны хандлага эергээр өөрчлөгдсөн байна.

Талархал

Судалгаанд хамтран ажилласан нийт багш, оюутнууддаа судлаачдын багийн зүгээс талархал илэрхийлье.

Ном зүй

1. World Health Organization. AIECP Framework for Action on Interprofessional Education & Collaborative Practice. Geneva: World Health Organization, 2010. P. 13.
2. Connie White Delaney, Craig Kuziemyk & Barbara F. Brandt. Integrating informatics and interprofessional education and practice to drive healthcare transformation. *Journal of Interprofessional Care*, 29:6, 527-529, DOI: 10.3109/13561820.2015.1108735
3. Thistlethwaite, J., & Moran, M. Learning outcomes for interprofessional education (IPE): Literature review and synthesis. *Journal of Interprofessional Care*, 24(5), 503-513. (2010).
4. Thompson, C. Do interprofessional education and problem-based learning work together? *Clinical Teacher*, 7(3), 197-201. (2010).
5. H. Watanabe. Overview of IPE. For IPE training course 2014, Gunma University.
6. Gaskin DJ, Richard P. The economic costs of pain in the United States. *J. Pain*. 2012;13:715–724
7. Leila Safabakhsh, Alireza Irajpour, Nikoo Yamani. Designing and developing a continuing interprofessional education model. *Advances in Medical Education and Practice* 2018; 9:459–467
8. Darlow B, Coleman K, McKinlay E, Donovan S, Beckingsale L, Gray B, Nesar H, Perry M, Stanley J, Pullon S. The positive impact of interprofessional education: a controlled trial to evaluate a programme for health professional students. *BMC Med Educ*. 2015; 15:98
9. Frenk J, Chen L, Bhutta ZA, et al. Health professionals for a new century: transforming education to

- strengthen health systems in an interdependent world. *Lancet*. 2010;376:1923–1958
10. Framework for Action on Interprofessional Education & Collaborative Practice, WHO 2010.
 11. Centre for the advancement of interprofessional education (CAIPE). Interprofessional education in pre-registration courses. Retrieved from www.caipe.org.uk. (2012).
 12. Heinemann GD., Schmitt MH., Farrell MP., & Brallier SA. Development of an Attitudes Toward Health Care Teams Scale. *Eval Health Prof*, 22(1), 123-142. (1999).
 13. Buring SM, Bhushan A, Broeseker A, et al. Interprofessional education: definitions, student competencies, and guidelines for implementation. *Am J Pharm Educ*. 2009;73(4):59.
 14. Thistlethwaite JE, Forman D, Matthews LR, Rogers GD, Steketee C, Yassine T. Competencies and frameworks in interprofessional education: a comparative analysis. *Academic Medicine*. 2014;89(6):869-875.
 15. Khalili H, Orchard C, Laschinger HKS, Farah R. An interprofessional socialization framework for developing an interprofessional identity among health professions students. *Journal of Interprofessional Care*. 2013;27(6):448-453.
 16. Lee B, Celletti F, Makino T, Matsui H, Watanabe H. Attitudes of medical school deans toward interprofessional education in Western Pacific Region countries. *Journal of Interprofessional Care*. 2012;26(6):479-483.
 17. A. Lee, C. Steketee, G. Rogers & M. Moran. Focus Towards a theoretical framework for curriculum development in health professional education. on *HEALTH professional education: A MULTI-DISCIPLINARY journal*, vol. 14, No. 3, 2013
 18. Ruby E. Grymonpre, Christine A. Ateah, Heather J. Dean, Tuula I. Heinonen, Maxine E. Holmqvist, Laura L. MacDonald, A. Elizabeth Ready, and Pamela F. Wener. Sustainable Implementation of Interprofessional Education Using an Adoption Model Framework. *Canadian Journal of Higher Education Revue canadienne d'enseignement suprieur*. 2016;46(4): 76 - 93

RESULT OF IMPLEMENTED INTERPROFESSIONAL EDUCATION IN MULTIPROFESSIONAL TEAMS BY ONLINE

Objective: To implement interprofessional education in multiprofessional teams by online.

Methods: Tables and visualizations of the research results were made using Microsoft Office 2016 suite and statistical processing was done using SPSS-25.0 program. The data of the research was coded and typed, after checking the errors, numerical data processing was performed using the results, the average value and deviation were determined, hypotheses were made within the scope of the research objectives, and the questionnaire was tested using appropriate statistical methods (t, ANOVA, Chi-Square, Spearman correlation). adequate sampling size was determined by the Kaiser-Meyer-Olkin index, and differences between factors were determined by the Bartlett Sphericity Chi Square index. The mean and difference of pre-test and post-test scores were calculated using the Kruskal Wallis test and the Wilcoxon matched test, and statistical significance was confirmed at 95 percent ($p < 0.05$) for all results.

Results: In the experimental group, compared to the pre- and post-training conditions, a change in attitudes toward health care teams was ($P < 0.05$, $P < 0.001$) readiness for interprofessional learning scale was ($P < 0.05$), team skills scale was ($P < 0.05$), interprofessional collaboration scale was ($P \leq 0.05$), team fitness test was ($P < 0.05$). Interprofessional collaborative learning scale was greater than 3.5, ($P < .001$) and Jefferson;s scale was statistically significant difference. ($P < 0.05$, $P < 0.001$).

Conclusion: In conclusion, interprofessional education learning method was introduced by online to multiprofessional teams, attitudes, competences, cooperation, team fitness, collaboration, values, ethics, responsibilities, and teamwork attitudes were positively changed.

Key words: Competency, multiprofessional team, interprofessional education, attitudes, change

ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, НИЙГЭМ-ЭРҮҮЛ АХУЙН МОНИТОРИНГИЙН АСУУДАЛД

Д.Отгонжаргал(Ph.D)

АШУУИС, Дархан- АУС, СШУТэнхим

otgonjargal.d@mnums.edu.mn

Хураангуй

ДЭМБ-ын тодорхойлсноор эрүүл мэнд гэдэг нь “Зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын сайн сайхан байдлын цогц бүрдэл” юм. Орчин үед эрүүл мэндийн талаар дэлхий нийтэд баримталж байгаа бодлого, үйл ажиллагаа нь хүнийг эрүүл байлгах, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэж байгаа бөгөөд үүний тулд хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, хүний бие организмд сөргөөр нөлөөлж болох экогенетик хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, амьдралын тааламжгүй дадал хэвшлийг өөрчлөх шаардлага тулгарч байна.

Түлхүүр үг: ДЭМБ, хүрээлэн буй орчин, хууль тогтоомж, экогенетик хүчин зүйлс

Үндэслэл

Орчин үеийн ертөнцөд хүрээлэн буй орчны маш олон хүчин зүйлс хүний эрүүл мэндэд нөлөөлж байна. Өнөөдөр дэлхий дахины нийт өвчлөлийн 85 орчим хувь нь хүрээлэн буй орчны бохирдол болон хүний өдөр тутмын амьдралын хэв маягаас үүдэлтэй^[4] байгааг ДЭМБ-аас зарласан. Улс үндэстнүүдийн дунд эмчлэхэд нэн төвөгтэй олон шинэ судлагдаагүй өвчин бий болж “хүний эрүүл мэнд- хүрээлэн буй орчин” гэсэн асуудал илүү хурцаар тавигдах болов. Энэ ойлголт нь ихээхэн өргөн хүрээний асуудал бөгөөд хүн төрөлхтөн эрүүл аюулгүй орчинд амьдрахын тулд экосистемийг эрүүл байлгах, гадаад орчин дахь мутагений нөлөөллийг бууруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаанд нэгдэхийг^[6] эрмэлзэж байна.

Даяарчлал, шинжлэх ухаан-техникийн хөгжлийн эрин үед хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх, бохирдлыг таслан зогсоох, хүн амын эрүүл мэндийг хамгаалан сайжруулах асуудал нэг улс, бүс нутгийн хүрээндээс хальж дэлхий нийтийн

асуудал^[5] болсон байна. Үүнтэй холбоотойгоор нийгэм-эрүүл ахуйн нөхцөл байдал, хүн амын эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдрах хэв маяг, хүний экосистемийн хими, физик, биологийн бохирдлын асуудлуудыг цогцоор нь авч үзэх, хүний эрүүл мэндийг ажиллах амьдрах орчинтой нь холбон судлах явдал урьд өмнөхөөс илүү чухлаар тавигдаж байгаа билээ.

Хотжилт болон аж үйлдвэрлэл хөгжсөн улс орнуудад үйлдвэрлэлийн үйл явцад бий болсон химийн хортой нэгдлүүд нь гадаад орчинд тархаж агаар, хөрс, усаар дамжин хүний биед нэвтэрч, эд эрхтэнд хорт бодис байнга хуримтлагдах нь аливаа өвчний шалтгаан болж байна^[3]. Ингэснээр хүний бие махбод архаг хордлогод орж ядрах, нойрмоглох, анхаарал сулрах зэрэг сөрөг нөлөөлөлд өртсөөр байгаа юм. Хүн эрүүл энх аж төрөх нь өвчин эмгэггүй байхын зэрэгцээ бие бялдар оюун санаа нийгмийн амьдралын сайн сайхан байдлын цогц бүрдлийн илэрхийлэл^[2] болохыг судлаачид цохон тэмдэглэдэг. Иймд хүний эрүүл мэнд гэдэг нь хүрээлэн буй бодит юмс, биологи, эдийн засаг, орчны нөлөөллийг зохицуулах өөрийнх нь бие махбодын хариу урвалаас гадна улс төр, эдийн засгийн чадвараас шууд хамаарч байдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн хөгжлийн тогтвортой өсөлтийг хангаж чадахгүйгээр хүний амьдралын мөн чанар, эрүүл мэндийг сайжруулах боломжгүй^[3] гэж үзэж болох юм. Манай улсын хувьд ийм нэгдсэн тогтолцоо бий болж чадаагүйгээс орчны хүчин зүйл, эрүүл мэндийн хоорондын уялдаа холбоог тогтоож, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажил туйлын хангалтгүй байна.

Дэлхийн улс орнуудын сүүлийн үеийн чиг хандлагыг ажиглахад, нийтийг хамарсан өвчний тархалт дэгдэх бүрд тусгай дүрэм журам батлахаас илүүтэй нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй аливаа нөхцөл байдалд цаг алдахгүй,

шуурхай арга хэмжээ авах, зохион байгуулалтад орох, бэлэн байдлыг хангах, нийгэмд тогтворгүй ойлгомжгүй байдал үүсгэхгүйн тулд нийтлэг стандарт тогтоон тусгайлсан хууль батлахыг чухалчилж байна. Энэхүү чиглэлийн хүрээнд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас хөгжиж буй улс орнуудад "... нийгмийн эрүүл мэндийн тухай хууль" нь анагаах ухаан, хүрээлэн буй орчин, биоэтик зэрэг бусад салбарыг оролцуулсан хууль тул салбар хоорондын уялдаа холбоог хангаж тодорхойгүй хэм хэмжээнээс зайлсхийх зөвлөмжийг хүргүүлсэн байдаг.

Монгол Улсын Их Хурлаас "Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 24-р тогтоолыг 2020 оны наймдугаар сарын 28-ны өдөр баталж мөн өдрөөс эхлэн мөрдөж байгаа бөгөөд уг тогтоолын 2-р зүйлийн 2.1.5-д нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль эрх зүйн орчныг бий болгоно" гэж заасан. Монгол улсын хэмжээнд нийгмийн нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулахад хамаарах 29, эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд хамаарах 15, орчны эрүүл мэндийн хамаарах 15, биотехнологи, инновацад хамаарах 9, тархвар зүй, шуурхай удирдлагад хамаарах 6, санхүү аж ахуйд хамаарах 16, хоол шим тэжээлд хамаарах 8, нийгмийн эрүүл мэндийн лавлагаа, лабораторид хамаарах 1 хууль тогтоомж мөрдөгдөж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн эрүүлд мэндийн асуудал нь зөвхөн эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбар, тэдгээрийн албан тушаалтан түүнчлэн бусад хуулийн этгээд, ТББ, иргэд бүгдэд хамааралтай болох нь харагдаж байна. Гэтэл өнөөдрийн байдлаар энэхүү мөрдөгдөж байгаа хуулиудад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бусад яам агентлагуудын үүрэг оролцоо, тэдгээрийн уялдаа холбоог зохицуулж өгөөгүй байна.

Судалгааны ажлын зорилго

Орчны эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт тэдгээрийн уялдаа холбоог иргэд хэрхэн ойлгож, хэрэгжүүлдэг эсэх, орчны эрүүл мэндийн боловсролын өнөөгийн түвшин ямар байгааг тандан судлах, цаашид хэрхэн сайжруулах боломжийг тодруулах, хэрэгжүүлж болохуйц зохимжтой хувилбарыг боловсруулж зөвлөмж гаргах

Судалгааны ажлын зорилт

1. Орчны эрүүл мэндийн асуудал, түүнд хандах иргэдийн хандлага, экогенетикийн хүчин зүйлсийн талаарх мэдлэг, хандлага ямар түвшинд байгааг тандан судлах
2. Иргэдийн мэдлэг боловсролыг цаашид сайжруулах боломжийг тодруулах
3. Зөвлөмж болгох зохимжтой хувилбарыг боловсруулж гаргах

Судалгааны ажлын практик ач холбогдол

Орчны эрүүл мэндийн талаарх хууль тогтоомж, тэдгээрийн уялдаа холбоог ард иргэд ойлгож мэдсэнээр өөрсдийн амьдрах нийгэмдээ хариуцлагатай хандах, орчны эрүүл мэндийн боловсролын үйлчилгээг бүх нийтэд жигд хүртээмжтэй хүргэснээр ахуйн химийн бодисуудтай мэдлэгтэйгээр харилцах төдийгүй хүрээлэн буй орчинд үүсэж болох хими, физик, биологийн бохирдлоос урьдчилан сэргийлэх чадвартай болох, өөрсдийн эрүүл мэнддээ анхаарахаас гадна нийгэм, нийтийн өмнө хариуцлага хүлээх иргэний ухамсар дээшлэх зэрэг практик ач холбогдлыг дурдаж болох юм.

Судалгааны арга


Судалгаанд агшингийн загварыг ашигласан бөгөөд асуумж судалгаагаар мэдээлүүдийг цуглуулж, SPSS программ дээр статистик дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг боловсруулсан. Уг судалгаанд Улаанбаатар хотын болон Дархан-Уул аймгийн 18-50 насны нийт 45 иргэд хамрагдсан болно.

Судалгааны үр дүн

Судалгаанд нийт 45 хүн хамрагдсан бөгөөд 30 хүртэлх насны 15 хүн оролцсоноос 13 эмэгтэй (86%), 2 эрэгтэй (13%), 30-40 насны 21 хүн оролцсоноос 15 эмэгтэй (71%), 6 эрэгтэй (28%), 40-өөс дээш насны 9 хүний 8 эмэгтэй (88.8%), 1 Эрэгтэй (11.1%) иргэд, нийтдээ эрэгтэй 9 эмэгтэй 36 хүн оролцов.

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон хүмүүсийн нас, хүйсийн байдал


нас	нийт		эрэгтэй		эмэгтэй		нийт
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
1 30 хүртэл	15	86%	2	13%	13	86%	
2 30-40	21	71%	6	28%	15	71%	
3 40-өөс дээш	9	20%	1	11.1%	8	88.8%	
Нийт	45	100%	9	100%	36	100%	100%



Зураг 1. Химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн талаарх мэдлэг хандлагын байдал
Химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд эрүүл мэндэд хортой эсэх талаар судлахад дараах үр дүн харагдлаа.


Судалгааны хариултыг нэгтгэвэл:

- сахарын хүчил (консервант- зайдас болон дарс) хортой 38% хоргүй 32% мэдэхгүй 30%,
- шингэн кристалл (компьютер болон гар утасны дэлгэц) хортой 54% хоргүй 25% мэдэхгүй 21%
- бордоо (азотын бордоо, ууталсан шүвтрийн бордоо) хортой 38% хоргүй 36% мэдэхгүй 26%,
- мяндсан утас(цаасан живх, эмэгтэй хүний ариун цэврийн хэрэгсэл, фломастер) хортой 57% хоргүй 16% мэдэхгүй 27%,
- гиалуроны хүчил (гоо сайхны бүтээгдэхүүн, чийгшүүлэгч бодис) хортой 36% хоргүй 42% мэдэхгүй 22% гэсэн хариултыг өгсөн байгаа нь хүмүүс өөрсдийн эрүүл мэндийг зөвхөн эмчид, эмнэлэгт даатгах хуучинсаг сэтгэхүйтэйгээ зууралдсаар байна гэж дүгнэж болохоор байгаа юм.




Зураг 2. Хүрээлэн буй орчны бохирдолт, хог хаягдлын талаарх ойлголт

Их хэмжээний үйлдвэрлэл – их хэмжээний хэрэглээ – их хэмжээний хаягдал гарах эдийн засгийн энэхүү тогтолцооны үр дүнд бидний амьдрал амар хялбар бөгөөд элбэг хангалуун болсон ч янз бүрийн хорт бодисоор тойрон хүрээлэгдэж, хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэнд аюулд өртөөд байна. Иймээс иргэдийн дунд хог хаягдлыг ангилан ялгах дадал суулгаж, хог хаягдлын зөв менежментийн ач холбогдлыг таниулан ойлгуулах явдал анагаах ухааны боловсролын хувьд их чухал байна.




Зураг 3. Хүрээлэн буй орчинд цацрагийн үзүүлэх нөлөөллийн талаарх ойлголт

Судалгаанд оролцсон хүмүүсийн хариултыг авч үзвэл, цацраг нь хүний бий болгосон шинэ зүйл биш бөгөөд байгалийн мөнхийн үзэгдэл учир ямар ч хор нөлөөгүй гэж хариулсан 4 (8.8%), цацраг идэвхт нутаг дэвсгэрт ионжих цацрагийн нөлөө нь организмд хортой үр дагавар үзүүлнэ гэж хариулсан 31 (68.8%), цацраг идэвхт бодисууд хүрээлэн буй орчинд агаар, ус, хөрсөөр дамжин тархана гэж хариулсан 8 (17.7%) Мэдэхгүй гэж хариулсан 2 (4.4%) иргэд байв.



Зураг 4. Биосферийн радио идэвхт бохирдлын талаарх мэдлэг, хандлагын байдал

Судалгаанд оролцсон иргэдийн хариултыг нэгтгэвэл, Цөмийн зэвсгийг үйлдвэрлэх турших гэсэн хариултыг 19 (42.2%), Цөмийн энергийг эрчимтэй хөгжүүлэх гэсэн хариултыг 16 (35.5%), Үндэсний эдийн засаг, анагаах ухааны салбарт ионжуулсан цацрагийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх гэсэн хариултыг 7 (15.5%), Мэдэхгүй гэсэн хариултыг 3 (6.6%) тус тус сонгосон байна.



Зураг 5. Цацрагийн бохирдол хүний биед хэрхэн дамжих талаарх ойлголт

Агаар, ус, хоол хүнсэн дэх цацрагийн бохирдол хүний биед дамжин орох замыг нэрлэнэ үү? гэсэн асуултад судалгаанд оролцсон хүмүүсийн 21 (46.6%) нь амьсгалын зам, арьс салстын гэмтсэн хэсэг, хоол боловсруулах эрхтэн гэж хариулсан бол 15 (33.3%) нь гэмтээгүй арьс салст, 8 (17.7%) нь хөлсөөр, 1 (2.2%) нь мэдэхгүй гэж хариулсан.

Дүгнэлт

Нэгдүгээрт, Нийгэм-эрүүл ахуйн нөхцөл байдал, хүн амын эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдрах хэв маяг, хүний экосистемийн хими, физик, биологийн бохирдлын асуудлуудыг цогцоор нь авч үзэх, хүний эрүүл мэндийг ажиллах амьдрах орчинтой нь холбон судлах явдал урьд өмнөхөөс илүү чухлаар тавигдаж байгаа орчин үед манай улсад хууль эрх зүй болон эрүүл мэнд, боловсролын байгууллагуудыг хамарсан нэгдсэн тогтолцоо бий болж чадаагүй байна.

Хоёрдугаарт, Хүн амын дунд экологийн шалтгаант өвчлөлийн талаарх ойлголт бага байгаа нь өөрсдийн эрүүл мэндийг хамгаалахдаа мэдлэгийг чухалчилдаггүй, эрүүл мэндээ нэгдүгээрт тавьдаггүй, орчны бохирдлын талаарх хууль эрх зүйн мэдлэг сул, нийгэм, нийтийн өмнө хариуцлага үүрэх чадамжгүй зэрэг нийтлэг доголдол, дутагдал байгааг энэхүү судалгаа харуулж байна гэж үзлээ.

Зөвлөмж:

- Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг бусад салбарын бодлогод тусган салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах боломж бидэнд байна.
- Нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн.
- Орчны эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, бусад салбартай уялдуулах орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

- Хүн амын ёс заншилд тохируулан эрүүл аж төрөх зан үйл, хэв маягийг төлөвшүүлэх, ард нийтээр нийгэм-эрүүл ахуйн мониторинг хийх мэдлэг чадвартай байх асуудал чухал байна.
- Хүн амын эрүүл мэндийн бодлогод хүний экологи-физиологийн асуудлыг тусгах, хүрээлэн буй орчны хими, физикийн гаралтай мутагенийг хязгаарлахад аливаа мэргэжлийн үүрэг оролцоог тодотгох, мэргэжлийн суурь хичээлүүдэд энэ чиглэлийн агуулгын багтаамжийг нэмэгдүүлж өгөх шаардлагатай байна.

Ном зүй

1. Прохоров Б.Б. Экология человека. - М.: Publishing Center «Academy», 2003
2. Губарева Л. И, Мизирева О.М “Экология человека семенари для учащихся университета” 2010
3. Архангельский В. И. Кириллов В.Ф Гигиена и экология человека, Учебник для медицинских училищ и колледжей, 2019
4. Федотов В.Г “Современная буржуазная философия США научного метода”, Воронеж, 1994
5. Catton, W. R. (1994). «Foundations of human ecology». *Sociological Perspectives*. 31 (1): 75–95. doi:10.2307/1389410. JSTOR 1389410.
6. Goudie, Andrew (2000). *The Human Impact on the Natural Environment*. Cambridge, Massachusetts: This MIT Press. pp. 203–239. ISBN 0-262-57138-2.
7. Odum, E. P. (1971). *Fundamentals of Ecology* (Third ed.). New York: Saunders. ISBN 0-7216-6941-7.

PROBLEMS OF ENVIRONMENTAL HEALTH AND SOCIO-HEALTH MONITORING

Abstract

According to the World Health Organization, health is defined as “not only the absence of disease, but also a comprehensive state of physical, mental, and social well-being”. In modern times, global health policies and activities are aimed at preserving public health and preventing disease, and for this purpose, it is important to increase public health education, improve environmental hygiene conditions and reduce ecological factors that can have a negative impact on the human body.

Keywords: WHO, environmental health, legislation, ecological factors

СУРАЛЦАХАД ҮҮСЭЖ БУЙ БЭРХШЭЭЛД НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН НЬ

Б.Байгалмаа, Ж.Ариунаа, П.Одонжил, П.Орхонтуйа
АШУУИС-ийн Сувилахуйн Сургууль
orkhontuya@mnums.edu.mn

Товч утга

Сурах бэрхшээл нь сургалтын үйл явцад тулгардаг түгээмэл асуудал төдийгүй өсвөр насанд тохиолдох үндсэн бэрхшээлүүдийн нэг юм. Сурах бэрхшээлтэй суралцагчид нэлээдгүй их байгаа тул түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйлс, тэдгээрийг судлах нь практик ач холбогдол өндөртэй байна. Суралцах бэрхшээлд соёл, нийгэм, эдийн засгийн хөгжил, багшийн харилцаа, багшийн арга зүй, сэтгэл санааны хямрал, тухайн хүүхдийн өөрийн бие махбодын онцлог, хувь хүн болон нийгэм, гэр бүл, хүрээлэн буй орчин, сургууль зэрэг янз бүрийн шалтгаанууд нь сурах бэрхшээлд хүргэдэг. Бид тоон судалгааны асуумжийн аргаар Цю Лили нарын сурах арга барил, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн тухай 31 асуулт бүхий асуумжийг ашиглаж статистик боловсруулалт хийн, үр дүнг гаргасан. Суралцагчдын цээжлэх чадвар 58.3 хувь нь дунд зэрэг, бие даах чадвар 63.6 хувь дундаас доогуур муу, суралцах хүсэл, сонирхол 70.9 хувьд нь дундаас доогуур, гэр бүлийн орчин 65 хувь нь дундаас доогуур муу байна. Эндээс харахад судалгаанд хамрагдсан 1-р дамжааны суралцагчдын анхаарал тогтвортой байдал, суралцах хүсэл, сонирхол дунд ба түүнээс бага үзүүлэлттэй байна. Иймд эдгээр бэрхшээлүүдэд нийгэм, гэр бүлийн орчин хэрхэн нөлөөлж буйг судалж үзсэн. Суралцах хүсэл сонирхолд нийгэм, гэр бүлийн хүчин зүйлс, харин анхаарлын тогтвортой байдалд багшийн лекц ойлгомжтой эсэх, гэрийн суралцах орчин зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна ($p < 0.001$).

Түлхүүр үг: сурах бэрхшээл, нөлөөлөх зарим хүчин зүйл, үнэлэх

Удиртгал

Дэлхийн бүх улс орны ерөнхий боловсролын сургуульд суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд нийтлэг байдаг байна. Канадын хүүхдүүдийн нийт 3.2 хувь нь, АНУ-д нийт хүүхдийн 97 хувь нь суралцахуйн бэрхшээлтэй гэж тодорхойлжээ^[1]. Монгол улсын хувьд сургуулийн нэг ангийн 20 хүүхдийн 3 нь тодорхой хэмжээгээр суралцахуйн бэрхшээлтэй байна^[2]. “Сурах бэрхшээл гэдэг нь тухайн сурагчийн танин мэдэхүйн чадвар, сэтгэл хөдлөл, физиологи, боловсролын түвшин, сургалтын хөтөлбөрийн шаардлагыг удаан хугацаанд хангаж чадаагүй, болон бусад хүчин зүйлээс шалтгаалан сурах чадамж муу буюу хоцрогдсоныг хэлнэ”^[3]. Сурах бэрхшээлтэй суралцагчдыг 6 төрөлд хуваадаг. Үүнд: Сурагчдын бие даах чадвар, анхаарлын тогтвортой байдал муу, цээжлэх чадвар муу, хүсэл сонирхол дутмаг, нийгэм, гэр бүл, хичээлийн орчны нөлөөлөл гэж ангилна^[4]. Соёл, нийгэм, эдийн засгийн хөгжил дорой, багш нарын заах арга барил сул, хүмүүжлийн доголдол, сэтгэл санааны хямрал, мэдрэхүйн эрхтний эмгэг, бие махбодын онцлог, сургууль болон гэр бүлийн нөлөөлөл, танин мэдэхүйн сэтгэлзүйн шинж чанарууд зэрэг янз бүрийн шалтгаанууд нь сурах бэрхшээлд хүргэдэг.

Сурахуйн бэрхшээлээс болж хүүхдүүд хичээлээ ойлгохгүй, улмаар хичээлээс хоцрох, хичээлдээ дургүй болох, өөрийгөө буруушаах, аажмаар багш, үе тэнгийнхнээс өөрийгөө тусгаарлах замаар хичээлээс завсардаж байна^[6]. Судлаачид ихэвчлэн сурах бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог шинж чанарыг судалдаг ч сэтгэлзүйн гүн гүнзгий дүн шинжилгээ хийдэггүй байна. Бидний өгүүлэлд сурах бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн сэтгэлзүйн шинж чанаруудыг судалж, сурах бэрхшээлийн шалтгаан юунаас болж байгааг

судлахыг зорьсон.

Шинэлэг тал: Суралцагчдын суралцахад үүсэж буй бэрхшээл, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлийн учир шалтгааныг тодорхойлж, практик үр дүнтэй арга замыг хайх боломжтой тул онолын үнэ цэнтэй судалгаа болж буйгаараа шинэлэг юм.

Зорилго: Сувилахуйн сургуулийн суралцагчдын сурахад үүсэж буй бэрхшээл, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг тодорхойлох

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

АШУУИС-ийн Сувилахуйн Сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилийн 1 дүгээр дамжаанд суралцаж буй суралцагчдаас google form ашиглан санамсаргүй түүврээр 164 суралцагчид хамруулсан. Судалгаанд Цю Лили нарын сурах арга барил, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн тухай 31 асуулт бүхий асуумж ашиглаж статистик боловсруулалт хийн, үр дүнг гаргасан.

Судалгааны статистик боловсруулалт

Судалгааны үр дүнгийн статистик боловсруулалтыг IBM SPSS 26 программ ашиглан үр дүнг тоо хувиар илэрхийлэв. сурах бэрхшээл түүнд нөлөөлөх хүчин зүйлийг үнэлэхдээ олон хүчин зүйлийн логистик регрессийн шинжилгээг ашигласан.

Үр дүн

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг хүснэгт 1-д харуулсан ба 90.25 хувь нь эмэгтэй оюутан, 9.75 хувь нь эрэгтэй оюутан хамрагдсан байна. Насны хувьд 84 хувь нь 18 нас хүртэл, 77 хувь нь 19-25 нас хүртэл, 3 хувь нь 25-с дээш настай байна. Харьяаллын хувьд оролцогчдын 25 хувь нь хөдөө орон нутгийн, 71.9 хувь нь хотын

Хүснэгт 1. Хүн ам зүйн мэдээлэл


	Үзүүлэлт	Тоо	хувь
Нас	18 нас	84	51.2
	19-25 нас	77	46.9
	26-30 нас	3	1.9
Хүйс	Эрэгтэй	16	9.75
	Эмэгтэй	148	90.25
Мэргэжил	Сувилахуй	85	51.8
	Тусгай мэргэжлийн	79	48.2

Харьяалал	Хот	118	71.9
	Хөдөө	41	25
	Алслагдсан дүүрэг	5	3.1

суралцагчид байв. Суралцагчдыг мэргэжлийн чиглэлээр нь авч үзвэл сувилахуйн мэргэжилтэн 85 хувь, тусгай мэргэжилтэн 79 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан суралцагчдын цээжлэх чадвар 58.3 хувь нь дунд зэрэг, бие даах чадвар 63.6 хувь дундаас доогуур муу, гэр бүлийн орчин 65 хувь нь дундаас доогуур муу байна.

Анхаарлын тогтвортой байдал



Зураг 1. Анхаарлын тогтвортой

Суралцах хүсэл, сонирхол



Зураг 2. Суралцах хүсэл, сонирхол байдал

Судалгаанд хамрагдсан суралцагчдын анхаарлын тогтвортой байдал 67.5 хувь нь дундаас доогуур, суралцах хүсэл, сонирхол 70.9 хувьд дунд ба түүнээс бага байна (Зураг1-2). Дээрх үзүүлэлтэд үндэслэн эдгээр бэрхшээлүүдэд нийгэм, гэр бүлийн орчин хэрхэн нөлөөлж буйг судалж үр дүнг тооцсон. Анхаарлын тогтвортой байдал багшийн лекц ойлгомжтой эсэх, гэрийн суралцах орчин зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна (Хүснэгт 2) ($p < 0.001$).

Хүснэгт 2. Анхаарлын тогтвортой байдал нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ

	Анхаарлын тогтвортой байдал				р утга	Нийт	
	Үгүй		Тийм			тоо	хувь
	Тоо	Хувь	Тоо	Хувь			
Нийгэм, гэр бүлийн орчин							
Багшийн лекц ойлгомжтой эсэх					0.001		
Тийм	41	55.00%	49	32.20%		90.55	47.94%
Заримдаа	29	41.30%	53	54.60%		82.413	8.41%
Дургүй	2	3.70%	5	13.20%		7.037	51.08%
Багшийн хичээлээс гадуурх давтлагад хамрагддаг эсэх					0.472		
Тийм	20	54.10%	82	48.00%		102.54	42.29%
Заримдаа	23	38.50%	79	46.10%		102.39	6.63%
Үгүй	7	7.30%	6	5.90%		13.073	5.77%
Гэрийн даалгавраа хийдэг эсэх					0.154		
А.Ихэнхдээ	6	8.30%	3	3.30%		9.083	36.51%
В.Заримдаа	20	34.90%	33	38.20%		53.349	57.72%
С.Үгүй	47	56.90%	55	58.60%		102.57	45.75%
Багшийн өгсөн даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж чаддаг эсэх					0.062		
Тийм	31	51.40%	42	40.10%		73.514	43.54%
Хааяа	27	40.40%	51	46.70%		78.404	10.71%
Үгүй	4	8.30%	9	13.20%		13.083	21.26%
Гэрийн суралцах орчин					0.001		
Маш сайн	16	29.40%	17	13.20%		33.294	21.34%
Сайн	14	22.90%	24	19.70%		38.229	17.60%
Дунд	10	17.40%	21	17.80%		31.174	39.81%
Муу	18	30.30%	44	49.30%		62.303	66.03%

Суралцах хүсэл сонирхолд нийгэм, гэр бүлийн хүчин зүйлс нөлөөлж байна (Хүснэгт 3) ($p < 0.001$).

Хүснэгт 3. Суралцах хүсэл сонирхолд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ

Үзүүлэлт	Суралцах хүсэл сонирхол				р утга	Нийт	
	Үгүй		Тийм			тоо	хувь
	Тоо	Хувь	Тоо	Хувь			
Нийгэм, гэр бүлийн орчин							
Багшийн лекц ойлгомжтой эсэх					0.001		
Тийм	51	60.00%	81	46.00%		45	53.01%
Заримдаа	30	35.30%	82	46.60%		113	40.94%
Үгүй	4	4.70%	13	7.40%		62	6.05%
Багшийн хичээлээс гадуурх давтлагад хамрагддаг эсэх					0.001		
Тийм	5	5.90%	9	5.10%		14	5.50%
Заримдаа	38	44.70%	58	33.00%		96	38.83%
Үгүй	42	49.40%	109	61.90%		151	55.67%

Гэрийн даалгавраа хийдэг эсэх					0.001		
Тийм	41	48.20%	76	43.20%		117	45.71%
Үгүй	38	44.70%	77	43.80%		115	44.23%
Заримдаа	6	7.10%	23	13.10%		29	10.06%
Байнга	51	60.00%	117	66.50%		168	63.24%
Багшийн өгсөн даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж чаддаг эсэх					0.001		
Тийм	51	63.00%	117	67.40%		168	73.00%
Заримдаа	23	27.00%	46	26.30%		69	19.00%
Үгүй	9	10.00%	11	6.30%		11	8.00%
Гэрийн суралцах орчин							
Маш сайн	16	39.50%	77	58.30%	0.001	101	58.73%
Сайн	23.3	51.00%	28	35.00%		80	39.41%
Дунд	7.4	8.30%	5.6	4.50%		9	1.86%
Муу	4.3	1.20%	2.4	2.20%			

Хэлцэмж

Энэхүү өгүүлэлд суралцагчдын суралцах бэрхшээлд /анхаарлын тогтвортой байдал, суралцах хүсэл, сонирхол, цээжлэх чадвар, гэрийн бүл хичээлийн орчин/ дүн шинжилгээ хийж, улмаар тэдэнд сурахад тулгарч буй бэрхшээл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг /нийгэм, гэр бүлийн орчин/ судалж үр дүнг гаргасан болно. Судалгаанд хамрагдагсдын суралцах хүсэл, сонирхол, анхаарлын тогтвортой байдал дундаас доогуур байсан. Анхаарлын тогтвортой байдал нь сурах бэрхшээлтэй хүүхдүүдийн нийтлэг шалтгаан болдог. Энэ нь хүүхдийн сурлагын амжилтад шууд нөлөөлдөг^[5]. Мөн оюутнууд өглөөний болон өдрийн хоолны дэглэм алдагдсанаас, ядарч стресст орсноос анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байдлаас болоод хичээлдээ идэвхгүй оролцдог байна^[7]. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын ихэнх нь хичээлдээ дур сонирхолгүй байгаа нь манай судалгааны үр дүнтэй нийцэж байв^[4]. Анхаарлын тогтвортой байдалд багшийн лекц ойлгомжтой эсэх, гэрийн суралцах орчин зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Эдгээр бэрхшээлд нийгэм, гэр бүлийн хүчин зүйлс нөлөөлж байгаа нь судалгааны үр дүнд ажиглагдсан ($p < 0.001$). Бусад судлаачдын үр дүнгээс харахад бие махбодын болон орчны хүчин зүйлүүд нь оюутнуудын суралцахууд ихээхэн нөлөөлж байна. Гэхдээ судалгаанд оролцогчдын суралцах чадварт бие махбодын хүчин зүйлээс орчны хүчин зүйлс илүү хүчтэй нөлөөлдөг гэж үзэж болохоор байна^[8]. Монгол улсад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад өсвөр насныхны

суралцахад үүсэх бэрхшээл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар харьцангуй бага судлагдсан байв. Судалгаа нь зөвхөн АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн суралцагчдын дунд хийгдсэн тул бусад зорилтот бүлгийг төлөөлөх боломжгүй юм.

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан 1-р дамжааны суралцагчдын суралцах хүсэл, сонирхол 70.9 хувьд дунд ба түүнээс бага, анхаарлын тогтвортой байдал 67.5 хувь нь дундаас доогуур муу байна. Анхаарал тогтвортой байдал болон суралцах хүсэл сонирхолд нийгэм, гэр бүлийн орчин нөлөө үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Цаашид суралцагчдын сурах бэрхшээлийг арилгахад эдгээр хүчин зүйлүүдэд анхаарах нь зүйтэй. Багшийн заах арга барил нь шинэлэг байж, тухайн суралцагчдын онцлогт тохирсон байвал анхаарлын тогтвортой байдал, хичээлд оролцох идэвхийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Ном зүй

1. Maja Altarac. Lifetime prevalence of learning disability among US children Affiliations expand 2007. DOI: 10.1542/ peds.2006-2089L
2. Монголын сэтгэлзүй сэтгэц, хэмжилзүйн үндэсний төв. 2013 оны 6 сар, до.7.
3. Chen, Li. International Journal of New Developments in Education ISSN 2663-8169 4 (2): Research on Social Development Characteristics of Children with Learning Difficulties and Corresponding Educational

- Strategies. DOI: 10.25236/IJNDE.2022.040204. 2016.18-21p
4. Mark Enrick R. Learning Styles and Factors Affecting the Learning of General Engineering Students International Journal of Academic Research in Progressive Education and Development 3 (1). DOI: 10.6007/1JARPED/v3-i1/500 URL: <http://dxdoi.org/10.6007/1ARPED/v3-i1/500> 2014.
 5. Castro F D, Hubert C, Strand E, et al. Severe functional difficulties and disabilities in children and adolescents and the Sustainable Development Goals[J]. Salud Publica De Mexico; 2017. 59p, 354p
 6. Баяраа, Д. сурахуйн бэрхшээл чухам юунаас шалтгаалдгийг шинжлэх ухаан яг таг тогтоогүй байгаа. Өдрийн сонин. Монгол Улс: Улаанбаатар хот. 2016.11.24.
 7. Harris, S. Children are arriving in class too hungry and tired to concentrate, warns teachers union. London, England: Associated Newspapers Ltd. Retrieved October 9, 2013, from <http://www.dailymail.co.uk/news/article-1377028/Hungry-children-concentrate-warns-Association-Teachers-Lecturers.html>; 2011, April 15

A STUDY ON DIFFICULTIES TO LEARN FACTORS AFFECTING ON IT

Abstract

Learning difficulties are not only a common problem in the educational process, but also one of the main problems in adolescence. Since there are quite a lot of students with learning disabilities, it is of great practical importance to study some of the factors that influence them. Learning difficulties include cultural, social, and economic development, teacher relationships, teacher methods, mental disorders, physical characteristics of the child, individual and society, family, environment, and school. We used a questionnaire with 31 questions about Qiu Lili's learning style and the factors affecting it, using a quantitative research questionnaire method, to perform statistical processing and produce the results. 58.3 percent of students' memorization ability is average, 63.6 percent of students' self-reliance is below average, 70.9 percent of their desire and interest in learning is below average, and 65 percent of their family environment is below average. It can be seen from this that the attention stability, desire and interest of the 1st year students involved in the research are medium or lower. Therefore, how the social and family environment affects these problems was studied. Interest in learning is influenced by social and family factors, while stability of attention is influenced by factors such as teacher's lecture clarity and home learning environment ($p < 0.001$).

ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД ТУЛГУУРЛАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД - АШУУИС-ИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЖИШЭЭГЭЭР -

Д.Амарсайхан

Нийгмийн эрүүл мэндийн сургууль, УСАУ, АШУУИС
 amarsaikhan.d@mnumns.edu.mn

Товч утга

Боловсролын байгууллагын хувьд сургалтын хөтөлбөрөө тасралтгүй шинэчлэн сайжруулж хөгжүүлэх асуудал сургалтын чанар хийгээд бэлтгэж буй мэргэжилтний үр чадварт шууд нөлөөтэй байдаг. Бид уг судалгаанд үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалд тулгуурлан АШУУИС-ийн НЭМС-ийн нийгмийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлох арга зүй, үйл явцыг авч үзэв.

Түлхүүр үг: сургалтын хөтөлбөр, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, үр дүнд суурилсан боловсрол, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүн

Удиртгал

Боловсролын байгууллагын хувьд сургалтын хөтөлбөрөө тасралтгүй шинэчлэн сайжруулж хөгжүүлэх асуудал сургалтын чанар хийгээд бэлтгэж буй мэргэжилтний үр чадварт шууд нөлөөтэй байдаг. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах үйл явцыг бүхэлд нь сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх хэмээдэг ба олон улсад киррикулум (curriculum) нэр томъёогоор нэрлэх явдал зонхилдог^[1] билээ. Дэлхий дахинаа суралцагч төвтэй сургалтын үзлийг баримтлах болсонтой уялдуулан тухайн сургалтын хөтөлбөрөөр зөвхөн мэдлэгийг бус мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх явдлыг чухалчилах болсон ба 1990-ээд оны үеэс “Үр дүнд суурилсан боловсрол”-ын онол, үзэл баримтлал дэлгэрч, олон улс оронд

хэрэгжиж байна. Үр дүнд суурилсан боловсролын үзлийг хөгжүүлэх ажлын хүрээнд 2000 онд MIT (Массачусетсийн Технологийн Их сургууль)-гаас гаргасан CDIO санаачилга нь дэлхий даяар бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад хувь нэмэр оруулж байна. CDIO нь Conceive (сэтгэх), Design (зохиох), Implement (бүтээх), Operate (хэрэглэх) гэдгийн товчлол бөгөөд анх инженерийн боловсролыг шинэчлэх зорилгоор бий болсон үзэл баримтлал ажээ. Энэхүү үзэл баримтлалд суралцахуйн үр дүн (Learning Outcome)-гийн талаарх ойлголт чухал байр суурь эзэлдэг. Үүнийг дотор нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (Program Learning Outcome-PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүн (Course Learning Outcome-CLO) гэж хоёр хувааж үздэг ба эдгээр нь хоорондоо уялдаатай байснаар сургалтын хөтөлбөр зорилгодоо хүрэх боломжтой гэж үздэг байна. “Тухайн хөтөлбөрөөр суралцаж төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын түвшингээр үнэлэгдэх сургалтын арга”^[2] гэж судлаачид товчоор тодорхойлжээ. “ҮДСБ-ын тогтолцоо нь урьдчилан төсөөлсөн суралцахуйн үр дүнг үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлсний дараа бодит хүрсэн үр дүнд үнэлгээ хийх замаар төсөөлсөн суралцахуйн үр дүнгээ эргэж сайжруулдаг эргэх холбоо бүхий тасралтгүй ажиллагаатай систем”^[3] болохыг судлаачид онцолжээ. Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалыг МУИС, ШУТИС, МУБИС зэрэг Монгол улсын их сургуулиуд сургалтын хөтөлбөртөө нэвтрүүлэн ашиглаж байна.

Бид уг судалгаанд АШУҮИС-ийн НЭМС-ийн нийгмийн эрүүл мэнд (цаашид НЭМ)-ийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлох арга зүй, үйл явцыг авч үзэв. НЭМС нь 1963 оноос хойш Монгол улсад эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэнд судлалч бэлтгэж ирсэн ууган, цорын ганц төрий өмчийн боловсролын байгууллага бөгөөд өнөөг хүртэл эрүүл ахуй, халдвар судлалын чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг «ЭРҮҮЛ АХУЙЧ» мэргэжилтэн бэлтгэж ирсэн ба нийгмийн хөгжил, тухайн шинжлэх ухааны үзэл баримтлалын олон улсын чиг хандлага, нийгмийн эрүүл мэндийн шинэ хандлага зэргийг харгалзан 2000 оноос эхлэн «НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД СУДЛАЛЧ» нэршлийн дор нийгмийн эрүүл мэнд судлалч, эрүүл ахуйч хос мэргэжилтэнг бэлтгэн, тус мэргэжлийн бакалаврын хөтөлбөрийн шинэчлэлийг тасралтгүй хийж ирсэн^[4].

НЭМ-ийн тусламжийн үндсэн зорилго нь хүн амын дундах эрүүл мэндийн байдлыг гадаад орчин, нийгэмтэй холбон судлан тогтоох, үнэлэх түүнд тулгуурлан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, эрх зүйн орчны баталгааг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжилтэд нь хяналт, зохицуулалт, зөвлөмж удирдамжаар хангах гэсэн гурван үндсэн зарчимд тулгуурлан дэлхий нийтэд хөгжиж байна. Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтыг гаргасны дотор Эрүүл мэндийн чиглэлээр нэн шаардлагатай 3 мэргэжлийн нэг нь НЭМ-ийн мэргэжилтэн байна. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (ЗГ-ын 2017/24 тогтоол)-ын 2.4.1.9-д нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний болон орон нутгийн түвшинд тогтвортой бүтэц бий болгон чадавхижуулах болон 2.4.1.10-д иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд нь тохирсон өвчний эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгааг онцлон заасан байдаг.

АШУҮИС-ийн НЭМ-ийн сургалтын хөтөлбөрийн багтаамж, хөгжлийн зарим онцлог үе шатыг авч үзвээс, НЭМ-ийн мэргэжилтнийг “Мэргэжлийн чиглэл: нийгмийн эрүүл мэнд, 091801 индекстэйгээр, өдрөөр, 5 жилийн хугацаатай 165

багц цагийн багтаамжтай хөтөлбөрөөр бэлтгэж ирсэн бөгөөд «Нийгмийн эрүүл мэнд» бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-өөр 2011, 2018 онд тус тус үндэсний хэмжээнд, 2023 онд АРНЕА олон улсын байгууллагаар олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн байна.

Хэрэглэгдэхүүн, арга зүй

АШУҮИС-ийн захирлын 2016.11.07 өдрийн хурлын шийдвэр, Эрдмийн зөвлөлийн дэргэдэх нэр томъёоны зөвлөлийн 2016.10.07, 2016.09.25-ны өдрийн хурлуудаар тус тус хэлэлцүүлэн баталж 2+3 хөтөлбөрийн хүрээнд 165 (68+97) кредит судлахаар болсон. НЭМ-ийн бакалаврын боловсролын агуулга нь эрүүл мэндийн салбар, хувийн хэвшлийн салбар, эрдэм шинжилгээний байгууллага, төр олон нийтийн байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж болон нийгмийн шаардлагатай бусад салбарт нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эрүүл ахуйч, тархвар судлаачаар ажиллахад шаардагдах үр чадвар олгоход чиглэнэ гэж тодорхойлсон байна. 2017 оны хичээлийн жилээс «НЭМ судлаач» бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд орсон багц цагийн багтаамж Монгол Улсын Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Сайдын 2014 оны 04 сарын 28-ний өдрийн А/174 тоот тушаалын хавсралтаар батлагдсан «Дээд боловсролын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах шаардлага»-д тусгасан сургалтын төлөвлөгөөнд тусгах багц цагийн шаардлагыг хангаж байна (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Хөтөлбөрийн агуулга^[5]

№	Багц цагийн агуулга	Багц цаг	Нийт багц цагт эзлэх %	Хөтөлбөрт тавигдах Үндсэн шаардлага
1	Ерөнхий суурь	47 кр	28.5%	30%-с илүүгүй байх
2	Мэргэжлийн суурь	38 кр	23%	25%-с илүүгүй байх
3	Мэргэшүүлэх	80 кр	48.5%	45%-с багагүй байх
	НИЙТ ДҮН:	165 кр	100%	

НЭМ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг 2018 онд

сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлснээс хойш хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад үрдүнд суурилсан боловсролын үзэл баримтлалыг тусгаж хэрэгжүүлэх ажлыг хийсэн бөгөөд хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүнг шинэчлэн тодорхойлсон. Бид сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ үр дүнд суурилсан боловсролын CDIO Стандарт 2 “Суралцахуйн үр дүнгүүд”-н загварт тулгуурлан хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлсон ба үүнд шаардагдах зохих судалгаа, дүн шинжилгээг хэрэгжүүлсэн. CDIO Стандарт 2-т хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хүрээг дараах байдлаар тодорхойлсон байдаг: “Хөтөлбөрийн зорилгод нийцсэн, хөтөлбөрийн оролцогч талуудаар баталгаажуулсан хувь хүний болон хүмүүстэй харилцах ур чадвар, бүтээгдэхүүн, үйл явц, системийг бий болгох ур чадвар, түүнчлэн судлагдахууны мэдлэгийг багтаасан сургалтын тодорхой, нарийвчилсан үр дүн”.^[6] Уг стандартын шалгуурын үнэлгээний рубрикт (Хүснэгт 2) тулгуурлан хөтөлбөр хэрэгжүүлэгч баг өөрийн үнэлгээг хэрэгжүүлсэн ба үнэлгээ 5-н түвшинг “хангаж байна”, цаашид ч тогтмол сайжруулах хэрэгтэй гэж үзсэн.

Хүснэгт 2. CDIO Стандарт 2-ын шалгуурын үнэлгээний рубрик^[6]

Үнэлгээ	Шалгуур
5	Үнэлгээний бүлгүүд оролцогч талуудын хэрэгцээнд гарсан өөрчлөлтөд үндэслэн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тогтмол хянаж, шинэчилдэг.
4	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг байгууллагын алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлж, үр дүн тус бүрээр ур чадварын түвшинг тогтоодог.
3	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг багш, оюутнууд, төгсөгчид, салбарын төлөөлөгчид зэрэг хөтөлбөрийн гол оролцогч талуудаар баталгаажуулдаг.
2	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн тодорхой томъёоллыг тусгах төлөвлөгөөг бий болгосон.
1	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг бий болгох, өөрчлөх хэрэгцээг хүлээн зөвшөөрч, уг явцыг эхлүүлсэн.

Мэдлэг, хувь хүний болон хүмүүстэй харилцах чадвар, бүтээгдэхүүн, үйл явц, системийг бий болгох ур чадварыг хамарсан тодорхой хөтөлбөрийн суралцахуйн үр дүн байдаггүй.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд PLO-г боловсруулахдаа дараах арга зүй, эрх зүйн баримт бичигт тулгуурлав. Үүнд:

- CDIO Стандарт
- Нийгмийн эрүүл мэнд судлалч хөтөлбөрийн мэргэжлийн тодорхойлолт, мэргэжлийн чиглэлийн зориулалт, мэргэжилтэнд тавих нийтлэг шаардлага, нийгмийн эрүүл мэнд чиглэлээр төгсөгчдийн мэргэжлийн бэлтгэл тавигдах үндсэн шаардлага, төгсөгчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг (20), чадвар (11), хандлага (6)
- ДЭМБ-аас гаргасан НЭМ-ийн тусламж үйлчилгээний 10 гол үйл ажиллагаа
- Өөрийн үнэлгээний тайлангийн 1.2 бүлэгт тусгагдсан «Хөтөлбөрийн зорилго, эцсийн үр дүнгийн уялдаа» Оюутнууд сургуулиа төгсөхөд эзэмшсэн байх чадамжууд^[7]
- Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны 24 дүгээр тогтоолоор батлагдсан «Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого»
- Стандарт хэмжил зүйн газар, 2012 оны 12 сард НЭМ –ийн мэргэжилтний “Мэргэжлийн чиглэл: Нийгмийн эрүүл мэнд- Индекс: MNS 5323 – 125, 2012” дээд боловсролын стандарт^[8]
- 2014 онд НЭМС-ийн эрдэмтэн багш нар боловсруулан гаргасан 8 хүрээ бүхий эзэмшвэл зохих 95 ур чадварыг заасан НЭМ-ийн мэргэжилтний цогц чадамж^[9]
- Монгол улсын БШУ-ны сайдын 2014 оны 04/2-ны өдрийн А/174 тоот тушаал

Үр дүн

Бид CDIO Стандарт 2-т тулгуурлан сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг шинэчлэн тодорхойлохдоо хөтөлбөрийн эрхэм зорилго, сургуулийн стратеги төлөвлөгөөнд нийцүүлэхийн зэрэгцээ оюутан, төгсөгч, ажил олгогч гэх мэт бүх оролцогч талуудын эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжийн судалгааг хэрэгжүүлж, үр дүнг нь тусгасан болно^[8]. Хөтөлбөрийн суралцахуйн

үр дүнг (хүснэгт 3) шинэчлэн боловсруулж, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх 30 гаруй хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулсан ба Орчны эрүүл мэнд хичээлийг жишээ болгон үзүүлэв. (хүснэгт 4)

Дээр өгүүлсэн арга зүй, эрх зүйн баримт бичигт тулгуурлан хөтөлбөрийн суралцахуйн үр дүн PLO1-PLO3-д нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, PLO4-PLO11-д эзэмшсэн байх чадваруудыг, PLO12-PLO13-д төгсөгчдийн хандлагыг тодорхойлсон.

Хүснэгт 3. Нийгмийн эрүүл мэнд судлалч бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг, ур чадвар, хандлагын суралцахуйн үр дүн /PLOs/-гийн жагсаалт

PLO1	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх орчин, нийгмийн хүчин зүйлд дүн шинжилгээ хийх, эрсдэлт хүчин зүйлс, шалтгааныг илрүүлэх мэдлэгтэй болно
PLO2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн тэгш хүргэхэд санхүүгийн болон хүний нөөцийг оновчтой хурваарилах мэдлэгтэй болно
PLO3	Аливаа өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх арга, стратеги, түвшин, зарчмын талаарх мэдлэгтэй болно
PLO4	Хүн амын эрүүл мэндийг дэмжих, сайжруулахад шаардлагатай мэдээллийг олж авах, дүн шинжилгээ хийх, судалгааны арга зүйг оновчтой ашиглах ур чадвартай байх
PLO5	Нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад шаардагдах хэмжилт болон лабораторийн шинжилгээний арга зүйг ашиглах чадвартай байх
PLO6	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох арга барилд суралцаж, эрдэм шинжилгээний үр дүнд суурилсан бодлого боловсруулах ур чадвартай байх
PLO7	Эпидемиологийн тандалт хийж, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ур чадвартай байх
PLO8	Хүн амын ажиллах, сурах, амьдрах орчин, хоол хүнсний аюулгүй байдал, эрсдэлийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх хууль тогтоол, дүрэм, стандартыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих ур чадвартай байх

PLO9	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд олон нийтэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, олон нийтийн нөлөөлөгчийн ур чадвартай байх
PLO10	Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа нийгэм, орчин, сэтгэл зүйн хүчин зүйлсийг арилгах, багасгахад чиглэсэн интервенц хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх ур чадвартай байх
PLO11	Судалгаа хийх, үр дүнг боловсруулах, дүгнэх чадвартай байх
PLO12	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн бодлогыг оновчтой тодорхойлж, эрүүл мэндийн салбарт манлайлан оролцох хандлагатай
PLO13	Салбар дундын хамтын оролцоог эрэлхийлэх, сайн хамтрагч, харилцагч байх хандлагатай

Дээрх хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн уялдааг авч үзэхийн тулд хөтөлбөрийн матрицыг (хүснэгт 5) боловсруулан гаргав. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хувь нэмэр оруулдаг хичээлийн суралцахуйн үр дүнгийн тархалтыг харваас хөтөлбөрт мэдлэгийн 199, чадварын 232, хандлагын 141 CLO хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болох 13 PLO-г хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Өөрөөр хэлбэл, CLO, PLO-гийн тархалт жигд тодорхойлогдсон байна.

Дүгнэлт

НЭМ-ийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, хөгжүүлэх ажлын хүрээнд үр дүнд суурилсан боловсролын CDIO Стандарт 2 “Суралцахуйн үр дүнгүүд”-н загварт тулгуурлан бүх оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тандах зохих судалгаа, дүн шинжилгээг хийж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлсон болно. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо “төгсөгчийн мэдлэг, чадвар, хандлага” гэсэн арга зүйг баримтлав.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, нэгж хичээлийн суралцахуйн үр дүнгийн уялдаа хамаарлын матрицаас ажиглахад төгсөгчийн чадварт илүүтэй анхаарсан хөтөлбөр болох нь ажиглагдлаа.

Цаашид сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн томьёолол, хэрэгжилтийг сайжруулахад бүх

Хүснэгт 4. Нийгмийн эрүүл мэнд судлалч бакалаврын хөтөлбөрийн Орчны эрүүл мэнд хичээлийн мэдлэг, үр чадвар, хандалгын суралцахуйн үр дүн /CLOs/-ийн жагсаалт

CLO 1	ОЭМ, судлах зүйлс, судлах аргуудыг ойлгох	PLO 1	K2
CLO 2	Агаарын үндсэн бохирдуулагчид, эх үүсвэрийн талаар мэдэж, агаарын чанарыг үнэлэх	PLO 2	K5
CLO 3	Аюултай хог хаягдлын менежмент, үе шатыг ойлгож эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах мэдлэгтэй болж, зөв ангилах	PLO 3	K6
CLO 5	Эрүүл мэндийн байгууллагад аюултай хог хаягдлын менежментийг үнэлж, чадвартай болох	PLO 4	S3
CLO 5	Агаарын үндсэн бохирдуулагчдыг хэмжих, шинжлэх	PLO 5	S5
CLO 6	Агаарын чанарын дата-мэдээлэл боловсруулж, судалгааны үр дүн, нотолгоо бий болгох	PLO 11	S4
CLO 7	Агаарын бохирдлыг үнэлэх, агаарын чанарыг индексээр үнэлж мэдээлэх хандалгатай болох	PLO 12	A3
CLO 8	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангиллын дагуу ялгаж ангилахын ач холбогдлыг ойлгох	PLO 12	A3

Хүснэгт 5. Нийгмийн эрүүл мэнд судлалч хөтөлбөрийн PLO, CLO-гийн матриц

	Correspondence of CLOs and CLOs												
	PLO-1	PLO-2	PLO-3	PLO-4	PLO-5	PLO-6	PLO-7	PLO-8	PLO-9	PLO-10	PLO-11	PLO-12	PLO-13
	Knowledge			Skill						Attitude			
Basic courses													
Mongolian history, culture and customs	CLO(1)	CLO(3)		CLO(1)			CLO(1)		CLO(1)	CLO(1)		CLO(1)	CLO(3)
Health management	CLO(2)	CLO(3)						CLO(1)		CLO(1)	CLO(1)		CLO(1)
Professional basic's courses													
Introduction to public health	CLO(9)		CLO(2)	CLO(5)		CLO(2)			CLO(1)	CLO(2)		CLO(5)	CLO(3)
Fundamentals of Epidemiology	CLO(8)	CLO(6)	CLO(3)	CLO(4)		CLO(1)	CLO(2)	CLO(3)			CLO(2)	CLO(9)	CLO(9)
Health behavior	CLO(3)		CLO(2)	CLO(2)		CLO(2)		CLO(2)	CLO(3)	CLO(1)	CLO(1)	CLO(1)	CLO(2)
Professional courses				CLO(2)									
Public health policy	CLO(4)	CLO(3)	CLO(3)(1)			CLO(1)			CLO(2)	CLO(3)		CLO(3)	CLO(2)
Health financial management	CLO(2)	CLO(2)		CLO(4)	CLO(4)	CLO(2)						CLO(2)	
Health social work	CLO(3)	CLO(1)	CLO(3)	CLO(1)	CLO(1)	CLO(1)	CLO(1)	CLO(1)				CLO(2)	CLO(1)
Health organization management		CLO(6)				CLO(5)						CLO(5)	CLO(5)
Health information systems	CLO(5)	CLO(3)	CLO(1)	CLO(1)		CLO(2)				CLO(1)	CLO(2)	CLO(3)	CLO(2)
Parasitology	CLO(2)	CLO(1)	CLO(2)		CLO(1)	CLO(1)	CLO(1)	CLO(2)	CLO(1)		CLO(1)	CLO(2)	CLO(1)

Fundamentals of biostatistics	CLO(5)	CLO(4)	CLO(2)	CLO(4)					CLO(4)	CLO(6)	CLO(2)	CLO(2)	
Epidemiology of communicable diseases	CLO(7)	CLO(3)	CLO(6)	CLO(8)		CLO(8)		CLO(7)			CLO(6)	CLO(6)	
Epidemiology of non-communicable diseases	CLO(8)	CLO(1)	CLO(5)	CLO(3)	CLO(2)	CLO(5)				CLO(7)	CLO(5)	CLO(5)	
Health promotion	CLO1(2)		CLO3(3)	CLO4(1)			CLO(1)		CLO(1)		CLO(2)	CLO(1)	
Fundamentals of food science	CLO1(1)	CLO2(1)	CLO3(1)		CLO(1)		CLO(1)	CLO(2)	CLO(1)		CLO(1)	CLO(3)	CLO(1)
Food hygiene	CLO1(4)		CLO3(3)		CLO(3)			CLO(3)			CLO(1)	CLO(6)	CLO(5)
Food technology	CLO1(3)		CLO3(3)	CLO4(1)	CLO(2)	CLO(1)		CLO(3)				CLO(2)	CLO(2)
Child and adolescent health and hygiene	CLO1(3)		CLO3(3)		CLO(2)	CLO(1)		CLO(3)				CLO(1)	CLO(1)
Fundamentals of child and adolescent hygiene	CLO1(3)		CLO3(2)	CLO4(2)	CLO(1)	CLO(1)	CLO(1)	CLO(2)	CLO(1)		CLO(1)	CLO(1)	CLO(1)
Sanitation and hygiene control	CLO1(1)	CLO2(1)		CLO4(1)	CLO(1)	CLO(1)		CLO(2)				CLO(1)	CLO(1)
Environmental hygiene	CLO1(1)	CLO2(1)	CLO3(1)	CLO4(1)				CLO(2)				CLO(2)	
Environmental health	CLO1(1)	CLO2(1)	CLO3(1)	CLO4(1)	CLO(1)					CLO(1)		CLO(2)	
Fundamentals of toxicology	CLO1(4)		CLO3(1)		CLO(1)	CLO(3)						CLO(2)	CLO(1)
Radiation hygiene	CLO1(3)		CLO3(1)		CLO(2)	CLO(1)						CLO(2)	CLO(1)
Fundamentals of occupational hygiene	CLO1(2)		CLO3(1)	CLO4(1)	CLO(2)	CLO(1)				CLO(2)	CLO(2)	CLO(2)	CLO(2)
Occupational hygiene	CLO1(1)	CLO2(1)	CLO3(2)	CLO4(1)	CLO(2)	CLO(1)				CLO(1)	CLO(2)	CLO(2)	CLO(2)
Occupational diseases	CLO1(7)	CLO2(2)	CLO3(7)	CLO4(2)	CLO(2)	CLO(1)		CLO(2)	CLO(1)	CLO(1)		CLO(1)	CLO(2)
Manufacturing technology	CLO1(1)	CLO2(1)		CLO4(2)		CLO(2)		CLO(2)			CLO(2)		CLO(2)
Risk assessment	CLO1(1)	CLO2(3)	CLO3(1)	CLO4(1)	CLO(1)			CLO(2)	CLO(1)	CLO(2)		CLO(1)	CLO(1)
	PLO(97)	PLO(43)	PLO(59)	PLO(47)	PLO(27)	PLO(36)	PLO(20)	PLO(33)	PLO(19)	PLO(20)	PLO(30)	PLO(76)	PLO(65)
	Knowledge-199			Skill-232						Attitude-141			

оролцогч талуудын эрэлт хэрэгцээний судалгаа, төгсөгчдийн мөшгөх судалгааг байнгын давтамжтайгаар хэрэгжүүлж, хөтөлбөрөө сайжруулахад тусгаж ажиллах нь зүйтэй юм.

Ном зүй:

1. Ж.Даваа “Их дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”, Артсофт, УБ. 2012.
2. Нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөмж, УБ., 2017.
3. Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг

тодорхойлох арга зүйн зөвлөмж, УБ., 2017, х.10

4. НЭМС-ийн тайлан 2021 он
5. Ахиц дэвшлийн тайлан НЭМС. 2022 он
6. <http://www.cdio.org/implementing-cdio/standards/12-cdio-standards#standard2>
7. АРНЕА өөрийн үнэлгээний тайлан НЭМС. 2023 он
8. Стандарт, хэмжил зүйн газрын <https://estandard.gov.mn/>
9. Мэргэжилтний цогц чадамж. 2016. Улаанбаатар хот
10. НЭМС-ийн үйл ажиллагааны тайлан, 2018-2022 он

SOME ISSUES OF CURRICULUM DEVELOPMENT BASED ON THE CONCEPT OF OUTCOME-BASED EDUCATION - ON THE EXAMPLE OF PUBLIC HEALTH CURRICULUM AT MNUMS -

Abstract

In this study, we aim to analyze the process and methods of reforming the program learning outcomes of Public Health course at MNUMS with respect to implementing an outcome-based education principles. It can be inferred that the outcome-based education aspect is highly prominent in MNUMS's Public Health curriculum. In doing so, program learning outcomes and course learning outcomes are defined by taking curriculum objectives and general demand into account. Henceforward, to further improve the curriculum, there is a need to focus on refining the interrelation between program learning outcomes and course learning outcomes, constantly implementing study results from all parties and making the program more accessible.

ҮР ДҮНД СУУРИЛСАН СУВИЛАХУЙН ХӨТӨЛБӨРӨӨР ТӨГСӨГЧ ОЮУТНЫ ЦОГЦ ЧАДАМЖИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Л. Хишигдэлгэр, Ц. Басбиш, Б.Оюунгоо, Г.Ганхуяг
АШУУИС, Сувилахуйн сургууль
khisigdelger@mnums.edu.mn

Товч утга

Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр шинээр боловсруулах ажлын хүрээнд мэргэжилтний цогц чадамжийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгардаг. Сувилагчдын цогц чадамжийн дэд бүлгүүдэд өгч буй хүчин зүйлийн үр дүн $F(4,17)=3.79, P=.006$ ялгаатай байгаа бөгөөд ажил олгогчдын сувилагч нарт өгсөн цогц чадамжийн үнэлгээний дундаж, сувилагч нарын цогц чадамжийн өөрийн үнэлгээний дунджаас бага байна. Иймээс ҮДСБ-ыг хэрэгжүүлэхэд тус хөтөлбөрөөр төгсөгчдийн цогц чадамжийг сайжруулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Сувилагч, ажил олгогч, цогц чадамж, үнэлгээ

Үндэслэл: Үр дүнд суурилсан сувилахуйн боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хамгийн гол нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг зөв тодорхойлох нь шаардлагатай байдаг. Энэ нь төгсөгчдийн чадамж ямар байгааг тодорхойлох, ажил олгогчдын хэрэгцээ шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх, сургалтын үйл ажиллагааны аль хэсэгт алдаа дутагдал байгааг илрүүлэх, түүнийг хэрхэн засаж, сайжруулах зэрэг олон үйл ажиллагаанд эергээр нөлөөлдөг.^[1] Дэлхийн олон оронд гол асуудал болж буй сэдвийн нэг нь сувилагчийн ур чадвар байдаг ба сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд салбарын ажил олгогчид чадварлаг сувилагч ажиллуулахыг илүүд үздэг. Үүний үр дүнд сувилагч нар шинэ технологи, шинэ үүрэг, шинэ ажлын байр, эрүүл мэндийн шинэ сорилтод дасан зохицох чадвараа улам өргөжүүлэх төлөвтэй байна. Мэргэжлийн ур чадвар нь цаг хугацааны явцад хөгжиж, хүрдэг ба үнэн хэрэгтээ чадамжийг олж авах нь эцсийн цэг биш үйл явц юм.^[2,3] Сувилагч нар мэргэжилтний хувьд нийгэмд хэрхэн хувь

нэмэр оруулах талаар үргэлж сорилттой байдаг бөгөөд сувилахуйн ур чадвар нь сувилагчийн үүргээ биелүүлэхэд шаардагдах үндсэн чадварыг агуулдаг. Тэд тасралтгүй шууд тусламж үйлчилгээ үзүүлэх, амь насыг хамгаалах, өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг дэмжихэд мэргэжлийн хариуцлага хүлээх ёстой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд сувилахуйн ур чадвараа сайжруулж, өдөр тутмын практикт ашиглах нь чухал юм. Чадамж бол туршлага, суралцах замаар олж авсан чадвар юм.^[4] Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилахуйн ур чадварыг үнэлэх нь хамгийн чухал хүчин зүйл болох эмнэлзүйн тусламж үйлчилгээг тасралтгүй сайжруулах, сургалтаар засаж залруулах боломжтой дутагдлыг илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.^[5] Сувилахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн боловсролын зорилго зорилтууд (PEOs)-д тухайн хөтөлбөрөөр суралцаж төгсөгчид суралцаж байх үедээ олж авсан мэдлэг, чадвар, хандлагадаа тулгуурлан мэргэжлээрээ (4-5) жил ажилласны дараа хэрхэн хөгжиж ямар түвшинд хүрсэн байх ёстойг илэрхийлдэг. Иймээс бид сувилахуйн ур чадваруудыг сургах аргуудыг тодорхойлохын тулд мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлохыг зорилго.^[6]

Судалгааны ажлын зорилго: Сувилахуйн мэргэжилтнүүдийн цогц чадамжийг үнэлэх зорилготойгоор 1. Сувилагчийн цогц чадамжийн өөрийн үнэлгээг тодорхойлох, 2. Сувилагчийн цогц чадамжид ажил олгогчийн үнэлгээг тодорхойлох зорилтыг дэвшүүлсэн.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй: Судалгаанд АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийг бакалаврын хөтөлбөрөөр төгсөгч 1-5 хүртэлх жил ажиллаж буй сувилагч нарыг хамруулсан ба CDIO нэг агшингийн (cross-sectional) үнэлгээний аргачлалыг ашигласан. Судалгааны өөрийн үнэлгээ болон

ажил олгогчдын үнэлгээнд Hsiu-Chin, Huan-Sheng Lo нарын боловсруулсан Competency inventory Scale буюу (Core Competency) үр дүнг үнэлэх 7 бүлэг 43 стандарт асуумжид тулгуурлан явууллаа. Хөтөлбөрийн үнэлгээний арга зүйд “7 = бүрэн санал нийлнэ”-ээс “1 = огт санал нийлэхгүй” хүртэлх оноогоор дундаж үзүүлэлт, ач холбогдлын түвшин, хамаарлыг үнэлээ. Судалгааны мэдээллийг дескриптив болон (Spearman) корреляци, дисперс шинжилгээ, ANOVA тест зэргийг ашиглан, SPSS 25 программаар боловсруулан судалгааны ёс зүйн зөвшөөрлийг Ёс зүйн хяналтын хорооны 2022.01.21-ний өдрийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл авч гүйцэтгэсэн.

Үр дүн: Анхан болон лавлагаа шатны эмнэлгийн байгууллагад ажиллаж буй сувилахуйн хөтөлбөрөөр суралцаж төгссөн 181 сувилагч мэргэжилтэн, 27 ажил олгогчоос ажилласан жил, мэргэжлийн зэрэг, албан тушаалаар ерөнхий мэдээллийг цуглуулсан болно. Тус судалгаанд хамрагсдын 95 (52.5%) 1-5 жил ажилласан, хүйсийн хувьд 172 (95%)-нь эмэгтэй сувилагч хамрагдсан. Хүн ам зүйн бүлгийн дескриптив үзүүлэлт, хамаарлын шинжилгээнд мэргэжилтний улсад ажилласан жил, тухайн байгууллагад ажилласан жилтэй хүчтэй хамааралтай байсан нь тус судалгаанд хамрагдсан сувилагч нар нэг байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж буйг харуулж байлаа. (хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Хувьсагч	Давтамж N=181	Хувь 100%
Нас (жилээр)		
20 хүртэлх	32	17.7
21-24	43	23.8
25-29	65	35.9
30-аас дээш	41	22.7
Хүйс		
Эрэгтэй	7	3.9
Эмэгтэй	174	96.1
Албан тушаал		
Сувилагч	168	92.8
Бусад	13	7.2
Боловсролын зэрэг		
Бакалавр	181	100
Магистр	0	0.0

Ажилласан жил		
1-5 жил	156	86.2
6-10 жил	25	13.8
Мэргэжлийн зэрэг		
Ахлах	0	0.0
Зэрэггүй	181	100
Харьяа тасаг нэгж		
Амбулатори	53	29.3
Стационари	125	69.1
Бусад	3	1.6

Судалгаанд хамрагдсан сувилагчдын 125 (69.1) хэвтэн эмчлүүлэх тасаг нэгж буюу үйлчлүүлэгчтэй 24 цагаар тасралтгүй эмчилгээ сувилгаа явуулдаг тасаг нэгжийнх хамрагдсан бол 156 (86.2) 1-5 жил ажилласан сувилагч нар байв.

Хүснэгт 2. Ажил олгогчдын хүн ам зүйн мэдээлэл

Хувьсагч	Давтамж n=27	Хувь 100%
Албан тушаал		
Тасгийн эрхлэгч эмч	8	29.6
САД	19	70.4
Ажилласан жил		
1-5 жил	1	3.7
6-10 жил	2	7.4
11-15 жил	1	3.7
16-20 жил	6	22.2
21-25 жил	4	14.8
26-дээш жил	13	48.2
Харьяа тасаг нэгж		
Амбулатори	8	29.6
Стационари	14	51.9
Бусад	5	18.5

Сувилагчийн цогц чадамжийг үнэлэх ажил олгогчийн үнэлэмжид 26-аас дээш жил ажилласан буюу ажлын дадлага туршлага удирдах ажилтан 13 (48.2), тасралтгүй тусламж үйлчилгээ үзүүлдэг тасаг нэгжийн харьяаллынх 14 (51.9), сувилахуй хариуцсан албаны дарга, арга зүйч нар 19 (70.4) хувийг тус тус эзэлж байв.

Хүснэгт 3. Сувилагчдын цогц чадамжийн дэд бүлгүүдэд өгч буй үнэлгээ

Үзүүлэлт	N=181	Бага утга	Их утга	Дундаж	Стандарт хазайлт (±)
1 Цогц чадамж, ёс зүй ба хариуцлага	181	33.00	77.00	64.46	±9.09
2 Эмнэлзүйн ур чадвар	181	10.00	49.00	34.98	±7.43
3 Эмнэлзүйн мэдлэг, био-анагаах	181	12.00	35.00	24.67	±5.46
4 Сувилгааны оролцоо	181	18.00	42.00	35.39	±4.82
5 Шүүмжлэлтэй сэтгэх чадвар	181	10.00	28.00	22.32	±3.71

Сувилагчийн цогц чадамжийг үнэлэх шалгуурын дэд бүлэг болох цогц чадамж, ёс зүй ба хариуцлага 77.0 ± 9.09 , эмнэлзүйн ур чадвар дэд бүлгийн дундаж 49.2 ± 7.43 , эмнэлзүйн мэдлэг, био-анагаахын шинжлэх ухаан хүчин зүйлүүдэд бүлгийн дундаж 35.5 ± 5.46 сувилгааны дэд бүлгийн дундаж, 42 ± 4.82 шүүмжлэлтэй сэтгэх чадвар 28.0 ± 3.71 тус тус байв.

Хүснэгт 4. Ажил олгогчдын сувилагч нарын цогц чадамжид өгч буй үнэлгээ

Үзүүлэлт	N=27	Бага утга	Их утга	Дундаж	Стандарт хазайлт (±)
1 Цогц чадамж, ёс зүй ба хариуцлага	27	48.00	73.00	60.29	±6.64
2 Эмнэлзүйн ур чадвар	27	22.00	43.00	33.37	±5.05
3 Эмнэлзүйн мэдлэг, био-анагаах	27	14.00	28.00	22.62	±3.92
4 Сувилгааны оролцоо	27	26.00	37.00	32.25	±2.65
5 Шүүмжлэлтэй сэтгэх чадвар	27	15.00	27.00	21.55	±3.38

Ажил олгогчдын үнэлгээнд эд бүлэг болох цогц чадамж, ёс зүй ба хариуцлага 73 ± 6.64 , эмнэлзүйн ур чадвар дэд бүлгийн дундаж 43 ± 5.05 , эмнэлзүйн мэдлэг, био-анагаахын шинжлэх ухаан хүчин зүйлүүдэд бүлгийн дундаж 28 ± 3.92 , сувилгааны дэд бүлгийн дундаж, 37 ± 2.65 шүүмжлэлтэй сэтгэх чадвар 27 ± 3.38 тус тус байв.

Хүснэгт 5. Сувилагч болон ажил олгогчийн үнэлгээ

	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	95% итгэх интервал		t	df	Sig
				min	max			
Pair 1 Сувилагч-ажил олгогч	28.0740	39.73075	7.64619	12.35711	43.79104	3.672	26	.001

* $p=0.01 < \alpha=0.05$

Сувилагч, ажил олгогчийн 0.05-н түвшинд ач холбогдол бүхий ялгаатай байна (Хүснэгт 5).

Хүснэгт 6. Дисперс шинжилгээ

	Нийт	df	Дундаж	F	Sig.
Бүлэг доторх	17332.502	4	4333.126	3.794	.006
Бүлэг хоорондын	200990.824	176	1141.993		
Нийт	218323.326	180			

Хүснэгт 6-аас харахад сувилагчдын цогц чадамжийн дэд бүлгүүдэд өгч буй хүчин зүйлийн үр дүн $F(4,17)=3.79$, $P=.006$ ялгаатай байна. Мэргэжилтний үр чадварт онолын мэдлэг нь ($r=0.42$) бага хамааралтай байгаа нь мэргэжилтний цогц чадамж нь гардан үр чадвараас шалтгаалж байгааг харуулж байна.

Хэлцэмж

Дээд боловсролын сургалтын системд заах болон суралцах чанарт дэлхий нийтээр ихээхэн анхаарал хандуулж байна. Бидний судалгаа нь АНУ-д хийгдсэн сувилахуйн хөтөлбөрөөр төгсөн гарагчдын өөрийн үнэлгээний тойм судалгааны дүгнэлт болох сувилагч нар мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ур чадварын шаардлага нэмэгдэж байгаа тул тэднээс илүү их үүрэг хариуцлага, чиг үүрэг шаардагдаж байна. Сувилагчдад эмнэлзүйн мэдлэг, суурь ур чадвараас гадна шүүмжлэлтэй сэтгэх, шийдвэр гаргах чадвар зэрэг ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлтийг тодотгожээ. (Youngkwan Song, Linda L. McCreary Chicago, United States 2020).

Дүгнэлт

Сувилагчдын цогц чадамжийн өөрийн үнэлгээ нь дундаж үзүүлэлттэй байхад ажил олгогчдын сувилагч нарын цогц чадамжид өгч буй үнэлгээний дундаж сувилагчдын өөрийн үнэлгээний дунджаас бага байна.

Сувилагчдын цогц чадамжийн дэд бүлгүүдэд өгч буй хүчин зүйлийн үр дүн $F(4.17)=3.79$, $P=.006$ ялгаатай байна.

Талархал

“Сувилахуйн хөтөлбөрийн хэрэгжилтэд төгсөгч оюутнуудын цогц чадамжийг үнэлсэн байдал” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэхэд тусалцаа үзүүлсэн АШУУИС-ийн Сувилахуйн сургууль,

АШУУИС-ийн МЯЭ, ХӨСҮТ, ХСҮТ, ЭХЭМҮТ, Дорнод, Өвөрхангай аймгийн БОЭТ-ийн эмнэлгийн хамт олонд талархал илэрхийлье.

Ном зүй

1. Schwendimann, R., Fierz, K., Spichiger, E., Marcus, B., & De Geest, S. (2019). A Master of Nursing Science curriculum revision for the 21st century—a progress report. *BMC Medical Education*, 19(1), 1-11.
2. Davis, D., Maughan, E. D., White, K. A., & Slota, M. (2021). School nursing for the 21st century: Assessing scope of practice in the current workforce. *The Journal of School Nursing*, 37(5), 374-386.
3. Spady, W. G. (1994). *Outcome-Based Education: Critical Issues and Answers*. American Association of School Administrators, 1801 North Moore Street, Arlington, VA 22209 (Stock No. 21-00488).
4. Chen, H. C., & Lo, H. S. (2012). Development and psychometric testing of the nursing student satisfaction scale for the associate nursing programs. *Journal of Nursing Education and practice*, 2(3), 25.
5. Erdenekhuu, N. (2017). Methodological recommendations for determining educational goals and learning outcomes of the program Ulaanbaatar, Mongolia.
6. Valizadeh, S., Mohammadpour, Y., Parvan, K., & Lakdizaji, S. (2009). The Effect of Outcome-Based Education on Nursing Students' Clinical Competency. *Iranian Journal of Medical Education*, 9(2).

ASSESSMENT OF GRADUATE STUDENT COMPETENCY IN OUTCOMES-BASED NURSING PROGRAM IMPLEMENTATION

Keywords: Nurses, Employers, Comprehensive Competencies, Assessment

Short meaning: Nursing skills are a hot topic in many countries around the world, and employers in the industry are working to improve the quality of nursing care. prefer to employ skilled nurses. As a result, nurses are expected to expand their ability to adapt to new technologies, new roles, new workplaces, and new healthcare challenges. Professional competence is developed and achieved over time, and in fact, the acquisition of competence is a process, not an end point. Nurses are always challenged with how they can contribute to society as professionals, and nursing skills are includes the basic skills required to perform the duties of a nurse. They have professional responsibility for providing continuous direct care, protecting life, and supporting activities of daily living. There is an urgent need to evaluate the comprehensive competence of specialists in the framework of the development of a new curriculum according to the results-based educational methodology. Sof the mourners the factorial results for comprehensive competence subgroups differed $F(4.17)=3.79$, $p=.006$ and the mean of comprehensive competence ratings given by employers to nurses was lower than the mean of nurses' self-rating of comprehensive competence. Therefore, it is necessary to improve the comprehensive competence of the graduates of the program in order to implement the NDS.

Conclusion: Nurses' self-ratings of comprehensive competencies are average, while employers' ratings of nurses' comprehensive competencies are lower than nurses' self-ratings. Sof the mournersthe results of the factor given to subgroups of complex competence are different $F(4.17)=3.79$, $P=.006$.

“ХӨДӨЛМӨР ЗАСАЛ” ХӨТӨЛБӨРИЙН ТУСЛАХ ТЕХНОЛОГИЙН ЛАБОРАТОРЫН ХЭРЭГЦЭЭ

С.Булганчимэг¹, М.Эрдэнэцэцэг¹, Б.Солонго², Б.Оюунгоо¹

¹АШУУИС, Сувилахуйн Сургууль

²АШУУИС, Анагаах Ухааны Сургууль

bulganchimeg.s@mnumns.edu.mn

Товч утга

“Хөдөлмөр засалч” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулж, онолоор үзсэн мэдлэгээ практик үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд үр чадварын өрөө, лаборатори зайлшгүй шаардлагатай байна. Хүмүүсийг эрүүл, үр бүтээлтэй, бие даан, нэр төртэй амьдрах, боловсрол, хөдөлмөрийн зах зээл, иргэний амьдралд тэгш хамруулах, оролцох боломжийг туслах технологи олгодог. Чадварлаг хөдөлмөр засалчдыг бэлтгэхийн тулд хөдөлмөр заслын үр чадвар, туслах технологийн лабораторыг байгуулах арга замыг тодорхойлох зорилгоор тус судалгааг хийлээ. Оролцоот үйл ажиллагааны аргыг ашиглан чанарын судалгааны загвараар хөдөлмөр засалчид, оюутнууд, хөтөлбөрийн мэргэжлийн багш нар зэрэг нийт 40 хүнийг хамруулан судалгааг явуулсан. Оролцогчдыг оюутан, төгсөгч, багш нарыг багтаасан таван бүлэг болгон хуваарилсан. Тэгш эрхтэй оролцох, хамтран ажиллах, харилцан ярилцаж шийдэлд хүрэх зэргээр асуудалтай нөхцөл байдлыг талууд хэлэлцэн ойлгож, түүнийг өөрчилж илүү сайн болгох шийдлийг олохын төлөө судлаачид, оролцогчид хамтарч ажилладаг.

АШУУИС-ийн дэргэдэх “Хөдөлмөр заслын туслах технологийн боловсрол, үйлчилгээний төв”-ийг байгуулснаар хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын чадамжийг сайжруулахын зэрэгцээ төрөл бүрийн чадвар алдалттай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдын амьдралын чанарыг сайжруулахад чухал алхам болох юм. 3D хэвлэх технологийг ашиглан хямд өртөгтэй туслах технологийг бий болгосон Хонконгийн Политехникийн Их Сургуулийн хөдөлмөр заслын багш нарын багийн туршлагаас суралцах нь

Монгол улсын нөхцөл байдалд тохирсон өртөг багатай туслах технологийн шийдлүүдийн гаргах аргад хөдөлмөр заслын оюутнуудыг сурган гаршуулах ач холбогдолтой.

Түлхүүр үг: Сургалтын орчин, Туслах технологийн лаборатори, хөдөлмөр засалч

Удиртгал

АШУУИС-ийн Сувилахуйн сургуульд Хөдөлмөр засал хөтөлбөрийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж 6 дахь төгсөлтөө 2023 онд хийж 44 хөдөлмөр засалч эрүүл мэнд, боловсрол, нийгэм хамгаалмын салбарт хөдөлмөр заслын тусламж үйлчилгээг үзүүлж байна. Мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрт үнэлгээ хийх нь сургалтын хөтөлбөрөө хэрхэн сайжруулах талаар хөтөлбөрөөс авч байгаа мэдээлэл бөгөөд оюутан, төгсөгч, багш нар болон бусад оролцогч талуудаас өгсөн хөтөлбөрийн тухай үнэлгээ, санал хүсэлт нь хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотой байдаг.

Сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь үнэлдэг Стабилизм (2007) нарын боловсруулсан батлагдсан загвар болох CIPP2 (Context-нөхцөл байдал, Input- орчин, нөөц хэрэглэгдэхүүн, Process- үйл авц, Product- үр дүн) аргаар хөтөлбөрийн оролцогч талуудаар үнэлүүлсэн. “Хөдөлмөр засалч” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, сургалтын үйл явц, сургалтын үр дүнг суралцагчид хангалттай сайн гэж үзсэн хэдий ч сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн, орчин нь шаардлага бүрэн хангахгүй байна гэж үзэж байна. Улмаар сургуулийн орчин нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн ном сурах бичгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр заслын онолоор үзсэн мэдлэгээ практик үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд үр чадварын өрөө,

лаборатори зайлшгүй шаардлагатай гэсэн саналууд бидний судалгааны үр дүнгээр илэрсэн.³

Хүний үйл ажиллагааны хэрэгцээг үнэлэх, түүнийг нь хангахад чиглэсэн зохистой шийдлүүдийг тодорхойлох чадварыг хөдөлмөр засалч нар эзэмшсэн байх ёстой. Хөдөлмөр заслын ангийн оюутнууд хүний чадвар болон хязгаарлагдмал байдалд анхаарахын зэрэгцээ аливаа хэрэгсэл төхөөрөмжүүдийг хувь хүний шаардлагад нийцүүлэн тохируулах, өөрчлөх замаар үйлчлүүлэгчийг хүссэн хөдөлмөртөө оролцох боломж олгох арга барилд суралцдаг. Хүмүүсийг эрүүл, үр бүтээлтэй, бие даан, нэр төртэй амьдрах, боловсрол, хөдөлмөрийн зах зээл, иргэний амьдралд тэгш хамруулах, оролцох боломжийг туслах технологи олгодог. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, өвчин эмгэг осол гэмтлийн улмаас чадвар алдалттай болсон хүмүүсийн оролцоог идэвхжүүлдэг. Туслах бүтээгдэхүүний гол зорилго нь хүний үйл ажиллагаа, бие даасан байдлыг хадгалах, сайжруулах, улмаар тэдний сайн сайхан байдлыг дэмжих явдал юм.

ДЭМБ-ын тооцоолсноор өнөөдөр 2.5 тэрбум хүнд тэргэнцэр, сонсголын аппарат, харилцаа холбоо, танин мэдэхүйг дэмждэг программ зэрэг нэг буюу хэд хэдэн туслах бүтээгдэхүүн хэрэгтэй байна. Дэлхийн хүн ам хөгширч, халдварт бус өвчлөл нэмэгдэж байгаа энэ үед 2050 он гэхэд энэ тоо 3.5 тэрбумаас давж, олон ахмад настнууд нас ахих тусам хоёр ба түүнээс дээш төрлийн бүтээгдэхүүн хэрэглэх шаардлагатай болно.^[4]

Туслах бүтээгдэхүүний жишээнд сонсголын аппарат, тэргэнцэр, нүдний шил, протез гэх мэт хэрэгслээс гадна харилцааны чадварыг нөхөн орлуулах, санах ойг дэмжих, хөдөлгөөний хязгаарлагдмал байдлаа даван туулахад дэмжих төхөөрөмжүүд гэх мэт олон зүйлс ордог. Эдгээр бүтээгдэхүүн нь бие даасан байдал, сайн сайхан байдлыг дэмжихийн зэрэгцээ хүндрэл, хоёрдогчоор үүсч болох үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад нөлөөлдөг. Мөн асран хамгаалагчдын ачааллыг бууруулж, эрүүл мэнд, асаргааны үйлчилгээний хэрэгцээг багасгаж чадна. Түүгээр ч зогсохгүй, зохих туслах бүтээгдэхүүний хүртээмж нь олон нийтийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд асар их нөлөө үзүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Монгол улсын хүн амын 11 орчим хувийг эзэлж тархалт өндөр байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулахад зайлшгүй шаардагдах туслах технологи чухал хэрэгцээтэй байгааг харуулж байна.⁵ Гэвч хүмүүст таяг, тэргэнцэр өгөөд, чиг боолт тааруулснаар асуудлыг шийдэх боломжгүй юм. Эмнэлзүйн шийдвэр гаргах, хэмжих, тохируулах, сургах, дараа нь хяналт тавихын тулд хөдөлмөр засалч нар анатоми, физиологи, эмгэг судлал, үйлчлүүлэгчийн чадвар, зорилго, амьдрах орчныг ойлгодог байх шаардлагатай. Энэхүү хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуульд Хөдөлмөр заслын туслах технологийн анхны боловсрол, үйлчилгээний төвийг байгуулахаар Хонконгийн Политехникийн их сургуулийн Сэргээн засах анагаах ухааны тэнхимийн Хөдөлмөр заслын багш нартай хамтран ажиллаж байгаа нь Монгол Улсад хязгаарлагдмал байгаа энэ асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болж байна. Тус төв нь туслах технологийн үнэлгээ хийх, тохируулга, хэрэглээний талаар эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн, оюутнуудад сургалт явуулахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах технологийн үйлчилгээ үзүүлэх зорилготой юм. Энэхүү санаачилга нь Монгол улсын хүн амын дунд буй туслах технологийн мэдлэг, хүртээмжийн дутагдлыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулахад туслах болно. Ийнхүү чадварлаг хөдөлмөр засалчдыг бэлтгэхийн тулд сургалтын орчинг хэрхэн сайжруулах талаар нарийвчлан судлах шаардлагатай байгаа нь тус судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Хөдөлмөр заслын ур чадвар, туслах технологийн лабораторыг байгуулах арга замыг тодорхойлох

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааг оролцоот үйл ажиллагааны аргыг ашиглан чанарын судалгааны загвараар явуулсан. Судалгааны энэ аргаар ажиллахад асуудалтай нөхцөл байдлыг талууд хэлэлцэн ойлгож, түүнийг өөрчилж илүү сайн болгохын тулд судлаачид, оролцогчид хамтарч ажилладаг. Өөрөөр хэлбэл оролцогчид нь судалгааны явцад хамтрагчийн үүрэгтэй оролцож тэдний мэдлэг чадамж нь үнэтэй хувь нэмэр оруулдаг. Оролцогч талууд хамтарч үйл ажиллагааг төлөвлөх, үйл ажиллагаа явуулах, ажиглах, тусгаж авах гэсэн 4 циклээр

ярилцаж хэрвээ нэгдсэн шийдэлд хүрээгүй бол дахин төлөвлөх байдлаар бүлгийн ярилцлагыг 2-3 удаа давтан хийсний дараа боловсруулж дуусна. Бүлгээр ярилцаж төлөвлөхөд юуг хэрхэн хийх вэ? хэн юуг хийх вэ? гэх мэт асуултаар эхлүүлнэ, үйл ажиллагаа төлөвлөснөө хийж гүйцэтгэнэ, ажиглахад төлөвлөгөөг хэрхэн биелүүлснийг, юу нь сайн болсон, юу нь муу болсон зэргийг ажиглана, тусгаж авах нь энэ яагаад ингэв, бид төлөвлөгөөгөө өөрчлөх шаардлагатай юу зэрэг асуудлаар ярилцаж, эсвэл нэгдсэн шийдэлд хүрвэл ярилцлагыг зогсооно. Олон нийтийн зүгээс гарч буй санал хүсэлтийг дэмжин, тэдэнд асуудлаа тодорхойлох, дүгнэлт хийн шийдэл олох боломж олгох нь энэ аргын зорилго юм.^[9] Тэгш эрхтэй оролцох, хамтран ажиллах, харилцан ярилцаж шийдэлд хүрэх зэрэг нь оролцоот үйл ажиллагааны судалгааны (Participatory action research) аргын давуу тал болдог.^[10]

Судалгаанд хөдөлмөр засалчид, оюутнууд, хөтөлбөрийн мэргэжлийн багш нар зэрэг нийт 40 хүнийг 5 бүлэгт хуваан хөдөлмөр заслын олон төрлийн туслах технологи (3D принтер, 360 градусын скайнер, харилцааны унтраалгат удирдлагатай туслах технологи, нүдний хөдөлгөөнийг мэдрэгчтэй компьютерийн программ дээр суурилсан харилцааны нэмэлт хэрэгсэл гэх мэт)-ийг загварчлан үйлдвэрлэж эмнэлзүйн тохиолдлуудад ашиглах тухай сургалтад оролцуулан “Оролцоот үйл ажиллагааны судалгаа”-ны аргыг ашиглан мэдээлэл цуглуулаа.

Судалгааны ёс зүйн зөвшөөрөл: «Үр дүнд суурилсан сургалтын загвар боловсруулж, мэргэжлийн хөгжлийн ерөнхий зураглалыг тодорхойлсон нь (Хөдөлмөр засал хөтөлбөрийн жишээн дээр)” сэдэвт судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн №2020/3-05 тоот АШУҮИС-ийн Судалгааны Ёс зүйн Хяналтын Хорооны хурлын шийдвэрээр авсан.

Үр дүн

Сургалт судалгааны оролцогчдыг оюутан, төгсөгч, багш нарыг багтаасан таван бүлэг болгон хуваарилсан. Туслах технологийн лабораторын хэрэгцээг тодорхойлох сургалтын хүрээнд түгээмэл тохиолддог тохиолдлуудыг сонгон авсан. Үүнд:

1. Тархины саажилтын кейс дээр ажиллаж унтраалгат удирдлагатай туслах технологийн


хэрэглээний эмнэл зүйн үндэслэл гарган, унтраалгат удирдлага бүхий харилцааны нэмэлт болон орлуулах дижитал хэрэгслийн тохиргоог компьютер дээр гардан хийх

2. Амиотрофик хажуугийн хатуурал оноштой үйлчлүүлэгчийн тохиолдол дээр ажиллах, эмнэл зүйн үндэслэлийн хэлэлцүүлэг, бодит үзүүлэн, туршилт, нарийвчилсан нүдний хөдөлгөөн дагуулан хянах, кейс судалгаа, клиник үндэслэлийн хэлэлцүүлэг
3. Нугасны гэмтэлтэй хүний тохиолдол дээр ажиллах, 3D хэвлэх технологи бүхий туслах технологийн хэрэглээний клиник үндэслэл, гардан үйлдлээр нугасны гэмтэлтэй хүнд тохирсон 3D загвар зурах, 3D хэвлэгч ашиглах, хөдөлмөр засал эмчилгээнд ашиглах, 3D-ээр хэвлэсэн янз бүрийн хэрэгслийг туршиж үзэх
4. Бодит үзүүлэн, туршиж хийх, хүний биеийг 360 градусаар сканердан 3D дүрс үүсгэх, 3D хэвлэсэн миоэлектрик удирдлагатай хиймэл эрхтэнг мөчний тайралтад суулгасан хүнтэй харилцах.

Дээрх сэдэв тус бүрээр 30 минутын лекцээр онолын мэдлэгийг өгч, туслах технологийг хэрхэн хийхийг багш биечлэн хийж үзүүлэн зааж, дараа нь бүлгээр ярилцан ажиллаж, гишүүн тус бүр гардан хийж үр чадварыг эзэмшин өөрийн тусгаж авсан дүгнэлтээ хуваалцаж байв.



Зураг 1. Сургалтын онолын хэсэг



Зураг 2. Багш өөрөө хийж үзүүлж байна



Зураг 3. Оролцогч гардан үйлдэл эзэмшиж байна



Зураг 4. Бүтээгдэхүүн үйлдвэрлэн туршиж байна



Зураг 5. Бүх түвшиний оролцогч талуудын хамтын ажиллагаа



Зураг 6. Сургалт, судалгааны нийт оролцогчид

Хөдөлмөр заслын тусламж үйлчилгээнд орчин, хэрэгслийн тохируулгыг туслах технологийн 3D принтер болон 360 градусын скайнер зэргийг ашиглаж үйлчлүүлэгчийн биеийн хэмжээг авч хийх нь тухай хүнд тохирсон хүртээмжэй үйлчилгээ үзүүлэх боломж олгож байна. Энд зөвхөн үйлчлүүлэгчид тохирсон туслах хэрэгслийг үйлдвэрлэхээс гадна хэрхэн яаж хэрэглэж сурах, ялгаатай чадвар алдалт тус бүрт хэдий хугацаа тухайн хүнд хэрэгтэй болох зэрэг эмнэлзүйн сэтгэлгээгээ хөгжүүлж чадсан.

Туслах технологийн 3D принтер гарснаас эдийн засгийн хувьд хямд өртөг бүхий хэрэгслийг сэргээн засах тусламж үйлчилгээнд нэвтрүүлж чадсан. Үүний нэг жишээ нь хиймэл гар бөгөөд үйлдвэрийн аргаар хийсэн хиймэл гарнаас хэд дахин өртөг бага, булчингийн агшилтыг мэдрэгч электродуудын тусламжтай атгах, тэнийлгэх, чимхэх зэрэг үйлдлүүдийг хийдэг болсон нь давуу тал байв.

3D принтерийг ашиглан сэдвийн дагуу туслах технологийн хэрэгслүүдийг хөдөлмөр засалчид хийж, сурсан мэдлэг чадвараа дээшлүүлээ. Хөдөлмөр засалч мэргэжлээрээ бахархан урам зориг авч, эмнэлзүйн практикт нэвтрүүлэх бүрэн боломжтойг сургалтын дараах оролцогчдын сэтгэгдэл дүгнэлт харууллаа.

Хэлцэмж

Туслах бүтээгдэхүүн дэлхий даяар маш ихээр шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрдөг ч түүний ашиг тусыг үл харгалзан туслах бүтээгдэхүүний хүртээмж хязгаарлагдмал хэвээр, ялангуяа Монгол зэрэг хөгжиж буй орнуудад туслах технологийн талаарх мэдлэг ойлголт дутмаг байна. Энэхүү хангагдаагүй хэрэгцээг шийдвэрлэх нь Тогтвортой хөгжлийн зорилтууд, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенцийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

ДЭМБ-аас 2019 онд хийгдсэн Монгол улс дахь туслах технологийн чадавхийн үнэлгээний нэгдсэн тайланд туслах технологийн жагсаалтыг хянах, хүртээмжийг сайжруулах цогц стратеги зэрэг дараагийн алхмуудыг төлөвлөх зорилгоор оролцогч талуудын үндэсний семинарыг зохион байгуулах нь зүйтэй гэжээ. Тус судалгааны үр дүнд хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад хамгийн их сорилт үүсгэдэг туслах технологийг тодорхойлох, тэдгээрийг зах зээлийг төлөвшүүлэх зохих үйл ажиллагаагаар шийдвэрлэх шийдэл/стратегийг боловсруулах хэрэгтэй гэж үзсэн байв. АШУУИС-ийн дэргэдэх Хөдөлмөр заслын туслах технологийн боловсрол, үйлчилгээний төвийг байгуулах нь дээрх асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулж болох юм.¹¹

Дүгнэлт

Дүгнэж хэлэхэд, АШУУИС-ийн дэргэдэх Хөдөлмөр заслын туслах технологийн боловсрол, үйлчилгээний төвийг байгуулах нь хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын чадамжийг сайжруулахын зэрэгцээ төрөл бүрийн чадвар алдалттай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдын амьдралын чанарыг сайжруулахад чухал алхам болох юм. ЗД хэвлэх технологийг ашиглан хямд өртөгтэй туслах технологийг бий болгосон Хонконгийн Политехникийн Их Сургуулийн хөдөлмөр заслын багш нарын багийн туршлага нь Монгол улсын нөхцөл байдалд тохирсон боломжийн үнэтэй туслах технологийн шийдлүүдийн эрэлт хэрэгцээг хангах үнэ цэнэтэй нөөц юм. Тасралтгүй хүчин чармайлт, хамтын ажиллагааны үр дүнд АШУУИС-ийн дэргэдэх Хөдөлмөр заслын туслах технологийн төв нь Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хэрэгсэл шаардлагатай хүмүүсийн амьдралд чухал нөлөө үзүүлж, улс нийгмийн эдийн засагт өргөн хүрээний үр өгөөж, хувь нэмэр оруулах боломжтой.

Талархал

Судалгааны ажлыг дэмжин оролцсон АШУУИС-ийн СС-ийн удирдлага, Монголын Хөдөлмөр Заслын Холбоо, Хонконгийн Политехникийн Их Сургуулийн хөдөлмөр заслын багш нар, Хятадын Канмины «Бид тусалъя, Бид хуваалцъя» төслийн хөдөлмөр засалчид, туслах технологийн инженерүүдээ талархлаа илэрхийлье.

Ном зүй

1. Honorat D. Curriculum Evaluation of FSRL: An Occupational Therapy Program in Haiti. 2018
2. Aziz S, Mahmood M, Rehman Z. Implementation of CIPP model for quality evaluation at school level: A case study. Journal of Education and Educational Development. 2018;5(1):189-206.
3. С.Булганчимэг, М.Эрдэнэцэцэг, Б.Оюунгоо. “Хөдөлмөр засал” хөтөлбөрийн чанар хүртээмжийн үнэлгээ: ЭМШУ сэтгүүлийн тусгай дугаар Vol 17 №5 {61} 2021, хуудас 113-118
4. National Law on the Rights of Persons with Disabilities, Government of Mongolia, Ulaanbaatar, Mongolia, 05 February 2016
5. Assessment of implementation of social welfare programmes: Assistive products for elderly persons, adults with disabilities and children with disabilities, Labour & Social Protection Research Institute, Ministry of Labour and Social Protection, Ulaanbaatar, Mongolia, 2019
6. Project “Ensuring Inclusiveness and Service Delivery for Persons with Disabilities Project” (Proj. n. 48076-002), Asian Development Bank, Manila, Philippines, 2019
7. Mongolian National Rehabilitation Strategic Plan 2021–2026, Ministry of Health, Ulaanbaatar, Mongolia, 2021
8. World Health Organization. Assistive technology capacity assessment (ATA-C): instruction manual.
9. Zinkstok R, Schiller S, Engelen A-M. Het Community Development Framework. De elementen van het reflectiekader. 2016.
10. Gilchrist A, Taylor M. The Short Guide to Community Development 2e. Policy Press; 2016.
11. Deepak, Sunil. (2020). Assistive Technology Capacity Assessment (ATA-C) Survey Mongolia Report.

THE NEED FOR AN ASSISTIVE TECHNOLOGY LABORATORY FOR THE “OCCUPATIONAL THERAPY” PROGRAM

Abstract

In order to improve the training environment of the «Occupational Therapist» curriculum and introduce theoretical knowledge into practical activities a skill room and laboratory are necessary. Technologies that enable people to live healthy, productive, independent and dignified lives, and enable equal inclusion and participation in education, the labor market, and civic life. The purpose of the study was to determine the way to establish a laboratory of occupational therapy skills and assistive technologies for the training of skilled occupational therapists. The research was conducted with a total of 40 people, including occupational therapists, students, and professional teachers of the program, using a qualitative research model of participatory action research method. Participants were divided into five groups, containing students, graduates, and faculty. Researchers and participants work together to find solutions to improve the situation by discussing and understanding the problematic situation through equal participation, cooperation, and dialogue.

The establishment of the «Occupational Therapy Assistive Technology Education and Service Center» at MNUMS will be an important step in improving the quality of life of people with various impairments and disabilities and their caregivers, as well as improving the skills of students studying occupational therapy. Learning from the experience of the Hong Kong Polytechnic University’s team of occupational therapy teachers, who created low-cost assistive technology using 3D printing technology, is important for training occupational therapy students in how to create low-cost assistive technology solutions suitable for Mongolia’s conditions.

Keywords: Learning environment, Assistive technology laboratory, occupational therapist

ХӨХНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ТАЛААРХ СУВИЛАГЧИЙН МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Д.Болормаа¹, С.Наранчимэг², Д.Авирмэд³, Д.Солонго¹

¹АШУУИС-ийн Сувилахуйн сургууль

²АШУУИС-ийн БАС

³Ач АУИС

bolor3439@gmail.com

Товч утга

Зорилго: Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн талаарх сувилагчийн мэдлэгийг үнэлэхэд оршино.

Арга аргачлал: Агшингийн судалгааны загвараар 2022 оны 11-р сараас 2023 оны 1-р сарын хооронд хугацаанд нийт 274 сувилагчдыг хамруулан судлаач Chimezie Innocent-ийн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх сорилын дагуу мэдээллийг цуглуулав. Судалгааны боловсруулалтыг SPSS 24 программд гүйцэтгэв.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсдын насны дундаж нь 37.8 ± 11.2 , улсад ажилласан жил 14.2 ± 11.4 байв. Сувилагчдын 44.8% нь эмэгтэй хүн бүрд хөхний хорт хавдрын эрсдэл байдаг, 45.5% нь хөхний хорт хавдраас сэргийлэх боломжтой, 59% эрт илрүүлэх нь амьдралын чанарыг хадгалах, амьд үлдэх хугацааг уртасгах боломжтой гэж тодорхойлсон байна. Тэдний 59.4% хөхөө өөрөө тогтмол шалгадаг, 34.6% нь эмчийн үзлэгээр хөхөө шалгуулж байсан, 10.9% нь маммографийн шинжилгээг хийлгэсэн байв. Судалгаанд хамрагдсан сувилагчдын улсад ажилласан жил нь хөхөө өөрөө тогтмол шалгадаг дадалтай ($p < 0.028$), тэдний хүйс нь хөхөө өөрөө тогтмол шалгадаг дадалтай ($p < 0.0001$) тус тус хамааралтай байгаа нь статистик ач холбогдлын түвшинд байв.

Дүгнэлт: Бидний судалгаанд хамрагдсан сувилагч нарын хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн мэдлэг хангалтгүй, хөхөө өөрөө тогтмол шалгах болон маммографийн шинжилгээнд хамрагдах дадал, хандлага нь тэдний нас, хүйс болон ажилласан жилээс нь хамааралтай байна.

Түлхүүр үг: Хөхний хорт хавдар, эрт илрүүлэг, сувилагчийн мэдлэг

Удиртгал

Үндэслэл: Орчин үед хөхний хорт хавдрыг эрт илрүүлж, үе шатны дагуу эмчилгээ хийх боломж бүрдүүлж чадсан улс орнуудад өвчлөлөөс шалтгаалах нас баралт жилээс жилд буурч, эмчилгээний дараа 5 жил амьдрах хугацаа нэмэгдэж байгааг тодорхойлжээ^[1]. Эмэгтэйчүүдийн хөхний хавдрын талаарх мэдлэг дутмаг, хөхөө өөрөө шалгах арга барилын ойлголтгүй байдал нь хөхний хорт хавдар хожуу үедээ оношлогдож байгаагийн гол шалтгаан болдог^[2]. Хөхний хавдрын эрт илрүүлэгт тулгамдаж буй асуудал нь манай орны хувьд өрх, сумын эмнэлгийн түвшинд хүний нөөц тогтворгүй, хүн амыг илрүүлэгт урих, идэвхтэй хамруулах үйл ажиллагаа хангалтгүй, шинжилгээний хариу үйлчлүүлэгчид очих хугацаа урт, эрт илрүүлэгт өөрчлөлттэй гарсан хүнд тавих хяналт сул, ажлын ачааллын хуваарилалт буруу байх, бүх түвшинд ачаалал их, эрт илрүүлгийн хүн дагасан хяналт сул байна^[3]. Манай оронд хөхний хорт хавдрын онош хожимдолтоос шалтгаалсан нас баралт буурахгүй байгаа өнөөгийн нөхцөлд өвчлөлийн эрт илрүүлэг дахь сувилагчийн оролцоонд дүн шинжилгээ хийх нэн шаардлагатай байгаад судалгааны ажлын үндэслэл оршино. Хөхний хорт хавдрын онош хожимдлын шалтгаанд сувилагчийн мэдлэг хэрхэн нөлөөлж буйг судлахаараа шинэлэг ажил болно.

Зорилго: Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн талаарх сувилагчийн мэдлэгийг үнэлэхэд оршино.


Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй: Хөхний хорт хавдрын талаарх сувилагчийн мэдлэгийг үнэлэхдээ агшингийн судалгааны загвараар хийв. Сувилагчийн хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ хийдэг байдал, мэдлэг, чадвар,

хандлагын мэдлэгийг тодорхойлохын тулд ХСҮТ, хөдөө орон нутгийн 4 аймгийн (Хөвсгөл, Завхан, Дорнод, Дорноговь) 12 суманд ажиллаж буй 274 сувилагчийг хамруулав. Хөхний хорт хавдрын эрсдэлийн талаарх сувилагчийн мэдлэг үнэлэхдээ Нигер улсын судлаач Chimezie Innocent-ийн 2017 онд судалгаандаа ашигласан KAP test (Knowledge, Attitude, Practice) асуулгын хуудсыг ашиглав. Судалгааг 2022 оны 11-р сараас 2023 оны 1-р сарын хооронд хийж гүйцэтгэв. Судалгааны тоо баримтыг SPSS 24 программ ашиглан, P утга <0.05 тохиолдолд статистикийн үнэн магадлалтай гэж тооцов.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан 274 сувилагчдын насны дундаж нь 37.8 ± 11.2 , 72.4% нь гэрлэсэн байв. Тэдний 40.1% диплом, 55.5% бакалавр, 4% магистр зэрэгтэй, улсад ажилласан жил 14.2 ± 11.4 байна. Хөхний хорт хавдрын эрсдэлийн талаарх сувилагчдын мэдлэгийг үнэлэхэд: 73.5% нь ажлын ачаалал, хэвийн бус ажлын нөхцөл нөлөөлдөг, 10.9% нь угсаа гарлаас хамаардаг гэж хариулсан нь хамгийн бага хувь байв. Сувилагч нар хөхний хорт хавдрын талаарх мэдээллийг 37.8% нь эмнэлгээс, 35.2% нь олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, 9% ном зохиол, 9% аян хөтөлбөр, 4% хурал хэлэлцүүлгээс, 2% нь найз нөхөд ойр дотны хүмүүс, 3% бусад эх үүсвэрээс олж авсан гэж хариулжээ. (Зураг 1)

Судалгаанд оролцогчид нь хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн удирдамжид заагдсаны дагуух мэдлэгийг үнэлэхэд 85.4% нь хөхөө өөрөө шалгах аргын талаар, 81.3% хөхний эмнэл зүйн үзлэг

■ Эмнэлэг ■ ОНМХ ■ Аян/хөт
■ Хурал ■ Найз ■ Бусад



Зураг 1. Сувилагч нар ХХХ-ын тухай мэдээлэл авсан байдал

хэрхэн хийх аргыг, 68.4% хөхний рентген зураг авалт ба маммографийн шинжилгээ хийх талаар тус тус сонссон гэжээ. Судалгаанд хамрагдсан сувилагчдын 44.8% эмэгтэй хүн бүрд хөхний хавдар тусах эрсдэл байдаг, 45.5% нь ХЯХ-аас урьдчилан сэргийлэх боломжтой, 47.6% нь хөхөө өөрөө шалгахын ашиг тусыг мэддэг, 41% нь хувийн ариун цэврийн дэглэм баримтлах нь ХХХ-ын эрсдэлийг бууруулдаг, 59% ХХХ-ыг эрт илрүүлэх нь амьдралын чанарыг хадгалах, амьд үлдэх хугацааг уртасгах боломжтой гэж тодорхойлсон байна.

Хүснэгт 1. Сувилагчдын нийгэм хүн амзүйн үзүүлэлт болон ХХХ-ын эрт илрүүлгийн шинжилгээний талаарх мэдлэг хоорондын хамаарал

Нийгэм хүн амзүйн үзүүлэлтүүд (тоо / хувь)	Эрт илрүүлэгт үзлэг шинжилгээнүүд		
	Маммографи Тийм=30(10.7%) Үгүй=244(89%)	Хөхний эмнэлзүйн үзлэг Тийм=90(32.8%) Үгүй=184(67.1%)	Хөхөө өөрөө шалгах арга Тийм=170(62%) Үгүй=104(37.9%)
Нас SD (37.8 ±11.2)	0.0001	0.448	0.021
Хүйс Эрэгтэй 6 (2.2%) Эмэгтэй 268 (97.8%)	0.867	0.832	0.0001
Гэрлэлтийн байдал Гэрлэсэн 198 (72.4%) Бусад 76 (27.7%)	0.952	0.770	0.494

Оршин суугаа хаяг Улаанбаатар 106 (38.7%) Хөдөө, орон нутаг 168 (61.3%)	0.087	0.197	0.366
Улсад ажилласан жил SD (14.2±11.4)	0.0001	0.070	0.028
Боловсролын түвшин Диплом 110 (40.1%) Бакалавр 152 (55.5%) Магистр 11 (4%)	0.684	0.834	0.485

Тайлбар: Судалгаанд хамрагдсан сувилагч нарын нийгэм хүн амзүйн үзүүлэлт болон эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний мэдлэг, хэрэглээний хоорондох хамаарлыг шалгахдаа нэг талын ANOVA-ийн параметрийн бус хувилбарыг ашиглав. (Kruskal-Wallis test: The significance level is 0.05)

Судалгаанд хамрагдсан сувилагчдын улсад ажилласан жил нь хөхөө өөрөө тогтмол шалгадаг дадалтай ($p < 0.028$), маммографийн шинжилгээ хийлгэсэнтэй ($p < 0.0001$), тэдний нас нь маммографийн шинжилгээ хийлгэсэнтэй ($p < 0.0001$) болон хөхөө өөрөө тогтмол шалгадаг дадалтай ($p < 0.021$), тэдний хүйс нь хөхөө өөрөө тогтмол шалгадаг дадалтай ($p < 0.0001$) тус тус хамааралтай байгаа нь статистик ач холбогдлын түвшинд байв.

Хэлцэмж

Хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх талаар Газын зурвас дахь эрүүл мэндийн анхан шатны эмнэлгүүдэд ажилладаг 152 сувилагч нарын дунд хийгдсэн судалгаанд эмнэлзүйн шинж тэмдэг, эрсдэлт хүчин зүйлийн талаар сайн мэдлэгтэй гээ хариулсан бидний судалгаанд хамрагдагсдын эрсдэлийн болон эмнэлзүйн шинж тэмдгийн мэдлэгтэй ойролцоо байв^[4]. Судлаач Heena нарын 2019 онд хийсэн судалгаанд 395 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан ба тэдний 74.7% нь хөхөө өөрөө шалгадаг, 24.1% нь эмнэлзүйн үзлэгт хамрагдсан, 18.7% нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна^[5]. Meshkani, Z., Moradi, N нарын хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгийн аргуудын талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх сорилын (KAP) тухай мэдээлэл оруулсан 5574 нийтлэлээс нотолгоо өндөртэй 28 нийтлэлд хийгдсэн дүгнэлтээс үзэхэд эмэгтэйчүүдийн дундах хөхний хорт хавдрын талаарх мэдлэг муу, сөрөг хандлагатай, хөхөө шалгах дадал багатай байсан гэжээ. Энэ нь манай судалгааны дүнгээс харахад эрт илрүүлэгт орвол зохих насандаа хамрагдахгүй байгаатай ижил байна^[6].

Дүгнэлт

Бидний судалгаанд хамрагдсан сувилагч нарын хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн мэдлэг хангалтгүй, хөхөө өөрөө тогтмол шалгах болон маммографийн шинжилгээнд хамрагдах дадал, хандлага нас, хүйс, ажилласан жилтэй хамааралтай байгаа нь харагдлаа.

Ном зүй

- Ginsburg O, Yip CH, Brooks A, et al. Breast cancer early detection: A phased approach to implementation. *Cancer*. 2020;126 Suppl 10(Suppl 10):2379-2393. doi:10.1002/cncr.32887
- George Coleman C. Early Detection and Screening for Breast Cancer. *Semin Oncol Nurs*. 2017 May;33(2):141-155.
- Ундармаа Т. Хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх нь. Эрүүл мэндийн салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн. 2022. Улаанбаатар хот.
- Mansour, H. H., Shallouf, F. A., Najim, A. A., Alajerami, Y. S., & Abushab, K. M. (2021). Knowledge and Practices of Female Nurses at Primary Health Care Clinics in Gaza Strip-Palestine Regarding Early Detection of Breast Cancer. *Asian Pacific journal of cancer prevention: APJCP*, 22(11), 3679–3684. <https://doi.org/10.31557/APJCP.2021.22.11.3679>
- Heena, H., Durrani, S., Riaz, M., AlFayyad, I., Tabasim, R., Parvez, G., & Abu-Shaheen, A. (2019). Knowledge, attitudes, and practices related to breast cancer screening among female health care professionals: a cross sectional study. *BMC women's health*, 19(1), 122. <https://doi.org/10.1186/s12905-019-0819-x>
- Meshkani, Z., Moradi, N., Aboutorabi, A., Noman, S., Motlagh, A. G., & Langarizadeh, M. (2022).

Systematic review of women's knowledge, attitude, and practice towards breast cancer. *Journal of education and health promotion*, 11, 171. https://doi.org/10.4103/jehp.jehp_634_21

TO STUDY OF NURSES KNOWLEDGE OF BREAST CANCER SCREENING

Objective: To evaluate the knowledge of nurses about early detection of breast cancer.

Methodology: In the period between November 2022 and January 2023, a total of 274 nurses were collected according to the test of KAP(Knowledge, Attitude and Practice) of researcher Chimezie Innocent. Research processing was performed in SPSS 24 software.

Results: The average age of the respondents was 37.8 ± 11.2 , and the years of working in the country were 14.2 ± 11.4 . 44.8% of nurses stated that every woman is at risk of breast cancer, 45.5% said that breast cancer can be prevented, and 59% identified that early detection can maintain quality of life and prolong survival. 59.4% of them regularly self-examine their breasts, 34.6% had their breasts examined by a doctor, and 10.9% had a mammogram. The number of years of service in the country of the surveyed nurses was statistically significantly related to self-examination practices ($p < 0.028$), and their gender was associated with self-examination practices ($p < 0.0001$).

Conclusion: The knowledge of early detection of breast cancer among the nurses involved in our study is insufficient, and the practice and attitude of participating in regular breast self-examination and mammography is dependent on their age, gender, and years of work.

“ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖ” ЧИГЛЭЛЭЭР СУРАЛЦАГЧДЫН ДИНАМИКТ НӨЛӨӨЛӨХ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

Д.Алтайхүү

АШУУИС-ийн Дархан АУС, СШУ-ны тэнхим

altaikhuu@mnums.edu.mn

Товч утга

XXI зуунд дээд боловсролын системд бий болсон голлох чиг хандлагыг авч үзвэл их, дээд сургуулиуд үндэсний болон глобал судалгаанд суурилсан, тухайн мэргэжлийн дээд боловсролын эрэлтийн таамаглал (прогноз), түүний үр дүнд тулгуурласан стратегитай байдаг ба тэр тусмаа суралцагчдын динамикт нөлөөлөх хүн ам зүйн нөлөөллийн хугацаа болон давтамжийг урьдчилан тооцож, таамаглал хийхийг чухалчилдаг нь хяналтгүйгээр бий болох зөрчлүүд хуримтлагдаж, улмаар тухайн салбар, байгууллагын хөгжлийг чөдөрлөхөд хүргэж болзошгүйтэй холбоотой.

Тиймээс Дээд Боловсролын Сургалтын Байгууллагад (ДБСБ) “Эрүүл мэнд, нийгмийн халамж”-ийн чиглэлээр суралцагчдын динамикт нөлөөлөх хүн ам зүйн нөлөөллийн хугацаа болон давтамжийг урьдчилан тооцохын тулд өнгөрсөн 20 жилийн хугацаанд хүн ам зүйн болон нийт суралцагчдын хүчин зүйлд динамик эгнээ ба хандлагын шинжилгээ хийж, улмаар “эрүүл мэнд, нийгмийн халамж”-ийн чиглэлээр суралцагчдын динамикийг нийт хүн амын болон ДБСБ-д суралцагчдын тоо голлон тодорхойлж байгаа үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорилоо.

Мөн түүнчлэн нийт хүн амын болон ДБСБ-д суралцагчдын динамикт тулгуурлан “эрүүл мэнд, нийгмийн халамж”-ийн чиглэлээр суралцагчдын дунд хугацааны динамик таамаглалыг (прогноз) дэвшүүлсэн бөгөөд нийгэм-эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс эрс өөрчлөгдөөгүй тохиолдолд тус чиглэлээр суралцагчдын тоо нь цаашид тогтвортой өсөж 2022 оноос 2032 он хүртэлх хугацаанд 40 орчим хувиар нэмэгдэх төлөвтэй байна.

Түлхүүр үгс: Дээд боловсролын эрэлт, зах зээлийн сегмент.

Судалгааны үндэслэл

Хөгжлийн глобал хандлагын гадна үлдэхгүйн тулд олон улсын түвшинд дээд боловсролын системд бий болж буй үйл явцыг судлах, ямар чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөх шаардлагатайг анхаарах нь чухал юм.

Их, дээд сургуульд суралцагчдын динамикт нөлөөлөх хүн ам зүйн нөлөөллийн хугацаа болон давтамжийг урьдчилан тооцож, таамаглал хийхийг чухалчилдаг нь хяналтгүйгээр бий болох зөрчлүүд хуримтлагдаж, улмаар тухайн салбар, байгууллагын хөгжлийг чөдөрлөхөд хүргэж болзошгүйтэй холбоотой¹.

“Эрүүл мэнд, нийгмийн халамж”-ийн (ЭМНХ) чиглэлээр суралцагчдын динамикт нөлөөлөх хүн ам зүйн нөлөөллийн хугацаа болон давтамжийг урьдчилан тооцохын тулд боловсролын салбарын хүн ам зүйн хүчин зүйлд хандлагын шинжилгээ хийх нь ихээхэн ач холбогдолтой² бөгөөд улмаар тус мэргэжлээр суралцагчдын богино болон дунд хугацааны таамаглал нь тухайн зах зээлд үүсэж болзошгүй тэнцвэргүй байдлыг бууруулах, түүнээс сэргийлэх нэгэн төрлийн дохиолол болж, энэ талаарх судалгаа нь тухайн сургуулийн болон салбарын түвшинд бодлого, стратеги боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Зорилго

“Эрүүл мэнд, нийгмийн халамж”-ийн (ЭМНХ) чиглэлээр суралцагчдын динамикт нөлөөлөх боловсролын салбарын хүн ам зүйн хүчин зүйлийг судалж, улмаар дунд хугацааны таамаглал (прогноз) хийх.

Зорилт

1. “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын динамикт нөлөөлөх боловсролын салбарын хүн ам зүйн хүчин зүйлд динамик эгнээ ба хандлагын шинжилгээ хийж үнэлэлт өгөх
2. Тус чиглэлээр суралцагчдын дунд хугацааны динамик таамаглал (прогноз) хийх.

Судалгааны материал, арга зүй

ҮСХ-ны статистик мэдээллийн сангийн Монгол Улсын хүн амын тоо, 2000-2021, Монгол Улсын харьяат хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, дунд хувилбар 2Б, 2020-2050, БСШУСЯ-ны статистик мэдээллийн ДБСБ-д суралцагчид, “ЭМНХ”-ийн чиглэлээр суралцагчдын статистик өгөгдлүүд болон “Монголын ДБСБ-ын өсөлтийн байдал, түүнийг судалсан зарим үр дүн” сэдэвт диссертацийн үр дүн болох ДБСБ-д суралцагчдын динамик таамаглалын өгөгдлүүдийг ашиглан ЭМНХ-ийн чиглэлээр суралцагчдын динамик, түүний зүй тогтлыг танин мэдэхэд динамик эгнээ ба хандлагын шинжилгээний аргыг, түүнчлэн “таамаглал (прогноз) хийхэд математик статистикийн аргууд, корреляци, регрессийн шинжилгээний аргуудыг ашиглав.

Үр дүн

“Эрүүл мэнд, нийгмийн халамж” чиглэлээр суралцагчдын динамикт нөлөөлөх боловсролын салбарын хүн ам зүйн хүчин зүйл:

2010 он гэхэд манай орны дээд боловсролын зах зээл нь дотроо нийгэм, эдийн засаг, боловсрол, хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухаан, техник, технологи, хөдөө аж ахуй, анагаах ухаан болон бусад гэсэн 8 үндсэн сегментүүдтэй байсан бол 2014 оноос үндсэн сегмент нь 10 болж, 2003 оноос хойших 20 жилийн хугацаанд харьцуулан авч үзвэл ЭМНХ сегментийн эзлэх хувийн жин 2.24 дахин, боловсролын эзлэх хувийн жин 1.22 дахин тус тус хамгийн ихээр өссөн (хүснэгт 1) байна. Энэхүү өсөн нэмэгдэж буй эрэлт нь юуны өмнө хүн амын өсөлттэй болон тухайн мэргэжлийн эрэлттэй шууд холбоотой бөгөөд ЭМНХ чиглэлээр суралцагчдын эзлэх хувийн жингийн өсөлт нь нэг талаасаа хүн амын өсөлтөөр, нөгөө талаасаа нэг эмч, сувилагчид ноогдох хүний тоог бууруулах бодлогын хэрэгжилтээр тодорхойлогдож байна. ДБСБ-д суралцагчдын тооны өсөлтөд нөлөөлж буй шалтгаануудыг хүн ам зүйн, эдийн засгийн

болон улс төр-эрх зүйн үндсэн 3 хүчин зүйлд авч үздэг бөгөөд эдгээрийн голлох хүчин зүйл нь яах аргагүй хүн ам зүйн хүчин зүйл болж байна.2


“ЭМНХ” чиглэлээр суралцагчдын динамикт нөлөөлөх хүн ам зүйн нөлөөллийн хугацаа болон давтамжийг урьдчилан тооцохын тулд динамик ба хандлагын шинжилгээ хийхэд тус чиглэлээр суралцагчдын тоо нь 2003 оноос 2023 он хүртэлх 20 жилийн хугацаанд нийт суралцагчдын тооноос хамааран 2011-2012, 2015-2016, 2016-2017, 2019-2020 оны хичээлийн жилүүдэд өмнөх оноосоо буурч (Зураг 1) ирсэн хэдий ч бусад сегментүүдтэй харьцуулахад эзлэх хувийн жин тогтвортой төдийгүй аажим өсөлтийг агуулсан байна.

Харин нийт суралцагчдын дунд эзлэх хувийг нь 2003-2023 оны хугацаанд авч үзвэл 7.7-оос 17.9 хувь хүртэл өсөж, жилд дунджаар 11.39 хувийг эзэлж байсан ба 1993-2005 оны хооронд хүн амын төрөлт жилд дунджаар 0.88 хувиар буурсан хэдий ч өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт элсэгчдийн 61.4-92.4 хувийг буюу дунджаар 74.6 орчим хувийг тухайн жилийн ахлах сургууль төгсөгчид эзэлж байсан нь дээд боловсролын түгээмэлжих үзэгдэл буюу массификаци нийтийг хамарсантай холбоотой юм.

Харин ДБСБ-д суралцагчдын динамик богино хугацаанд тогтворгүй болж, 2015-2021 оны хичээлийн жилүүдэд буурч байсан нь ЕБС богино хугацаанд 11, 12 жилийн тогтолцоонд шилжсэн үйл явцтай холбоотой бөгөөд тэрээр нийт суралцагчдын динамикт хүчтэй нөлөөлсөн1 хэдий ч “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын динамик харьцангуй тогтвортой байж, улмаар нийт суралцагчдын дунд эзлэх хувь 2011 оноос хойш тасралтгүй өсөж 2021-2023 оны хичээлийн жилийн байдлаар 17.94 хувьд хүрсэн ба улмаар цаашид богино болон дунд хугацаанд үргэлжилнэ гэж үзлээ.

“Эрүүл мэнд, нийгмийн халамж” чиглэлээр суралцагчдын динамик таамаглал (прогноз):

“ЭМНХ” чиглэлээр суралцагчдын динамикийг 2023-2032 он хүртэл таамаглахын (прогнозчлох) тулд нийт хүн ам, ДБСБ-д суралцагчдын болон ЭМНХ чиглэлээр суралцагчдын динамик үзүүлэлтүүдийн хоорондын статистик хамаарлын хэлбэрийг тогтоож, түүнийг 2032 он хүртэлх таамаглах (прогнозчлох) олон хүчин зүйлийн



Зураг 1. “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын эзлэх хувийн жин. 2003-2023
(БШУЯ. статистик мэдээнд тулгуурласан судлаачийн тооцоолол)


регрессийн шинжилгээний үр дүнг авч үзвэл $R = 0.978903$ буюу маш нягт хамааралтай, харин F шинжүүрийн утга 183.624696845148 (F хүснэгт=3.52) байгаа нь судалгаа статистик ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн үл хамааран хувьсагчдын T тестийн утгууд 5.15067982 , 15.91508660 (T хүснэгт=2,0930) нь нөлөөлөхүйц хувьсагчууд байж чадаж байгаа бөгөөд тус чиглэлээрх суралцагчдын тоог тайлбарлах чадвартай ($p = 1.59673338646703E-09$), стандарт алдаа 0.0144056579 , 0.00086014597 буюу бага байгаа нь тухайн тэгшитгэлийн $(Y_{эмнх} = -34.0403824665 + 0.0741989316484 * X_{нс} + 0.013689297634 * X_{ха})$ найдвартай байдлыг хангаж байгаа бөгөөд ДБСБ-д суралцагчдын тоо нэг нэгжээр өөрчлөгдөхөд “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын тоо 0.0741989316 нэгжээр, хүн амын тоо нэг нэгжээр өөрчлөгдөхөд “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын тоо 0.0136892976

нэгжээр өөрчлөгдөх буюу эерэг, шууд хамаарал буйг илэрхийлж байна.

Харин автокорреляци байгаа эсэхийг шалгаж үзвэл $DW = 1.528962441$ байгаа бөгөөд Дурбин Ватсоны статистик хүснэгтийн өгөгдөлтэй ($n = 19$, $m = 2$) харьцуулан үзвэл $dl = 1,074 < 1.528 < du = 1,536$ нь автокорреляци байгааг үгүйсгэж байна.

Тус таамаглалын үр дүнд “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын тоо тогтвортойгоор аажим өсөж, 2031-2032 оны хичээлийн жилд 34.35 мянгад (17.71%) хүрэх (Зураг 2) төлөвтэй байна.

Энэхүү таамаглалыг тодорхой тооны хувьд авч үзэхээсээ илүү тухайн мэргэжлээр суралцагчдын тоо өсөн нэмэгдэж буй ирээдүйн төлөв гэж үзэн, тус мэргэжлийг бэлтгэн нийлүүлдэг сургуулиуд стратегийн бодлого, маркетингийн төлөвлөлтөд анхаарах нь чухал юм.



Зураг 2. “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын динамик таамаглал 2023-2032

Дүгнэлт

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд “ЭМНХ” чиглэлээр суралцагчдын динамик нь боловсролын салбарын хүн ам зүйн хүчин зүйлээс голлон хамаарсан байна.

“ЭМНХ” чиглэлээр суралцагчдын эзлэх хувийн жинг (7.8%-17.9%) бусад сегментүүдтэй харьцуулахад тогтвортой төдийгүй аажим өсөлттэй байгаа ба эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс эрс өөрчлөгдөөгүй тохиолдолд тус өсөлт нь дунд хугацаанд үргэлжлэх хандлагатай байна.

“ЭМНХ” чиглэлээр суралцагчдын тоо цаашид жилд дунджаар 3,8 хувиар өсөж, 2031-2032 оны хичээлийн жилд 34.35 мянга орчим болж, ДБСБ-д нийт суралцагчдын 17.71 хувийг хамрах төлөвтэй байна.

Ном зүй

1. Авдай Ч, Энхтуяа Д, Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. ШУТИС. УБ. 2007; 6-41, 137-156,
2. Алтайхүү.Д, Монголын дээд боловсролын өсөлтийн байдал, түүнийг судалсан зарим үр дүн. Дисс, МУБИС. УБ, 2018; 102-110
3. Алтайхүү.Д, “ДБСБ-д суралцагчдын хүн ам зүйн хүчин зүйлд тулгуурласан дунд хугацааны таамаглал (2018-2030)”. “Боловсрол судлал сэтгүүл”. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн. 2018; 148(2); 6-11
4. Петров ЮА, Петрова ГИ, Демографическое прогнозирование контингента студентов в ВУЗах Российской Федерации. 2017; 186-190. http://elar.ufrj.br/bitstream/10995/55703/1/8udf2_036.pdf. Created: October 10, 2019; Last Update: June. 26, 2022.
5. Савинков ВИ, Ключарев ГА, Анализ и прогноз численности студентов и преподавательского персонала учреждений профессионального образования. Москва; 2014; 6-7, 61-81.
6. Шинжилгээ судалгааны ажил хийхэд баримтлах арга зүйн нийтлэг зөвлөмж. ҮСХ, Сэлэнгэ пресс ХХК, УБ; 2010.
7. <http://www.nso.mn/> (Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо)
8. www.meds.gov.mn/Statistic (БШУЯ. Статистик)

THE IMPACT OF EDUCATIONAL DEMOGRAPHIC FACTORS ON THE STUDENT DYNAMICS IN THE “HEALTH AND SOCIAL CARE” SEGMENT

Abstract

Consider the main trends in the system of higher education in the XXI century, then since it prevents the buildup of uncontrollable conflicts that could obstruct the development of that educational sector or institution, it is crucial to determine the duration and frequency of the educational demographic factor's impact on the dynamics of students in Higher Education Institutions (HEI) and to forecast student dynamics.

As a result, it is crucial for the development of policy and strategy in that sector or institution to study the duration, frequency, and medium-term forecasting of the student dynamics in «Health and social care» segment. This research serves as a kind of signal to lessen and prevent any potential market imbalances.

Consequently, in order to calculate the duration and frequency of the demographic factor on the dynamics of students in the “health and social care” segment of higher education, using dates from the last 20 years, a dynamic analysis of the series and trends of educational demographic factors, is made, as well as attempted to estimates and conclusions that dynamics students in the “health and social care” segment are determined mainly by the number of all students in the HEI and the demographic factor.

Therefore, a medium term forecast was made of the number of students in the “health and social care” segment in higher educational institutions (HEI) of Mongolia, and if economic and political factors change dramatically, student numbers will continue to rise steadily and are expected to increase by about 40 percent between 2022 and 2032.

Keywords: Demand for higher education, professional segment.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХОЛБОО IX ХУРАЛ (2018.04.18)

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбоотой хамтран “Анагаахын Боловсролын Чанар-Магадлан Итгэмжлэл” сэдвээр МАУБХ-ны IX дүгээр хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр «Corporate Convention Center»- ийн Улаанбаатар танхимд амжилттай зохион байгуулсан.

Тус хуралд МАУБХ-ны гишүүн сургуулиуд болох “АШУИС”, “Ач” АУИС, “ЭЗШУИС”, “Оточ манрамба” АУИС, “Шинэ Анагаах Ухаан” ИС, “Энэрэл” ДС, “МҮИС”, Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл зэрэг байгууллагуудын төлөөлөн оролцож, илтгэл хэлэлцүүлж, харилцан туршлагаа солилцож,

хурлын үеэр ИЗОУИС-ийн Анагаах ухааны сургууль албан ёсоор холбооны гишүүн сургуулиар бүртгэгдэж батламжаа гардан авсан. Хурлаас гарсан санал, зөвлөмжийн дагуу Анагаахын сургуулиудад бэлтгэж байгаа мэргэжил тус бүрийн хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаар МАУБХ-ноос санаачлан нээлттэй хэлэлцүүлгүүдийг гишүүн сургуулиудыг хамруулан зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Монголын Анагаах Ухааны Боловсролы Холбооны дээд шагнал «Шилдэг боловсрол судлаач» өргөмжлөлөөр АУ-ны доктор, профессор Д.Отгонбаяр, АУ-ны доктор, дэд профессор Б.Оюунгоо нарыг шагнасан байна.



2019 World Federation for
Medical Education World Conference
WFME 2019
April 7(Sun) – 10(Wed), 2019
Grand Walkerhill Seoul, Seoul, Korea

ДЭЛХИЙН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХОЛБООНЫ ХУРАЛ (БНСУ, Сөүл хот, 2019.04.07-04.10)

2019 оны 4-р сарын 7-10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын нийслэл Сөүл хотноо “АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН БАТАЛГАА 21 ДҮГЭЭР ЗУУНД” сэдэвт Дэлхийн Анагаах Ухааны Боловсролын Холбооны хурал зохион байгуулагдлаа.

Тус хуралд Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн илтгэгчид, Дэлхийн анагаах ухааны боловсролын зөвлөхүүд, магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн шинжээчид, тэр дундаа энэ хөтөлбөрт амжилттай хамрагдсан Анагаах ухааны суурь боловсролын стандартыг боловсруулах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, төгсөлтийн дараах анагаах ухааны боловсролын магадлан итгэмжлэлийн эрх бүхий байгууллагуудын төлөөлмөөс бүрдсэн 57 орны 810 гаруй судлаачид оролцож, 12 салбар хуралдаанд 300 гаруй судалгааны илтгэл хэлэлцэгдэв.

Монголын Анагаах ухааны боловсролын холбооны гүйцэтгэх захирал, Ач Анагаах ухааны их сургуулийн Боловсрол хариуцсан дэд захирал АУ-ны доктор, профессор Д.Отгонбаяр тус хуралд оролцож дараах 5 сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн байна.

1. Otgonbayar.D1, Zol.B1, Khaliun.B1, Enkhzul T.2, Baasanjav.N2 “Item analysis on graduate exam performance” WORLD FEDERATION FOR

MEDICAL EDUCATION CONFERENCE (WFME 2019) will be held from April 7 to 10 in SEOUL KOREA, “Ach” Medical University of Mongolia

2. Otgonbayar.D1, Zol.B1, Khaliun.B1, Enkhzul T.2, Baasanjav.N2 “A study of factors affecting the implementation of the curriculum” WORLD FEDERATION FOR MEDICAL EDUCATION CONFERENCE (WFME 2019) will be held from April 7 to 10 in SEOUL KOREA, “Ach” Medical University of Mongolia

3. Otgonbayar.D1, Zol.B1, Khaliun.B1, Enkhzul T.2, Baasanjav.N2 “Item analysis of the basic clinical skills assessment” WORLD FEDERATION FOR MEDICAL EDUCATION CONFERENCE (WFME 2019) will be held from April 7 to 10 in SEOUL KOREA, “Ach” Medical University of Mongolia

4. Otgonbayar.D1, Gantugs.Yu, “Evaluate current situation of the residency training using focus group discussion among teachers involved in the training” WORLD FEDERATION FOR MEDICAL EDUCATION CONFERENCE (WFME 2019) will be held from April 7 to 10 in SEOUL KOREA

5. Otgonbayar.D1, Gantugs.Yu, “Evaluation of residency training in Mongolia” WORLD FEDERATION FOR MEDICAL EDUCATION CONFERENCE (WFME 2019) will be held from April 7 to 10 in SEOUL KOREA





**АЗИ НОМХОН ДЛАЙН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХУРАЛ
Монгол Улсаас оролцож, хэлэлцүүлсэн илтгэлүүд 2017-2023**

APMEC 2023

Organising E-Learning in Medical School During State Heightened Level of Readiness in Response to COVID-19 Pandemic

Baljinyam B, Undram M, Solongo B, Sumberzul N, Lkhagvasuren Ts, Oyungoo B

Assessment of Nursing Graduate's Core Competencies

Khishigdelger L, Gankhuyag G, Basbish Ts, Bayarbat G, Gantsatsral, Oyungoo B

Scholarship for Tuition Fees for Nursing Students in Mongolia

Bayarbat G, Usukhbayar M, Enkhbold D, Gantsatsral G, Oyungoo B

Result of Blended Learning in Communication Skills Lesson at Mongolian National University of Medical Sciences

Uzmee M, Narmandakh S, Naranchimeg S, Oyuntsetseg S

APMEC 2021

E-Learning in Higher Education During the COVID-19 Epidemic

Sumiyasuren T, Enkhtuguldur M, Oyungoo B

Survey on E-Learning Needs Among Healthcare Professionals in the Workplace

Baljinyam B, Gal-Erdene S, Solongo B, Oyungoo B, Sumberzul N, Lkhagvasuren Ts

An Assessment of the Effectiveness of E-Learning

Gantsetseg G, Baatarsuren L, Bayasgalanmunkh B

APMEC 2020

How Does Mongolian Traditional Medicine Bachelor Degree Curriculum Fare With Standards of National Certification Commission for Acupuncture and Oriental Medicine Requirements in the United States of America: A Comparative Study

Regzedmaa D, Usukhbayar M, Bayarbat G, Tserendagva D, Oyungoo B

Mongolian Traditional Medical Curriculum in Inner Mongolia, China and Mongolia: A Comparative Study

Regzedmaa D, Wu Qi Zhu, Amarsaikhan D, Tserendagva D, Oyungoo B

Comparative Study in the Results of Faculty Evaluation

Uzmee M, Sumiyasuren T, Oyuntsetseg S, Oyungoo B

APMEC 2019

Recognition of Full Online Master's Degree Programmes are Rapidly Growing Among Mongolian Healthcare Professionals

Ryenchindorj E, Chimedsuren O, Munkhzul Yo, Alimaa G, Oyungoo B

Applying Mixed Methods for Needs Assessment of Fellowship Training Programme for Mongolian Health Professionals

Nomin A, Jung M, Yoon HB, Shin JS

Usage of Cognitive Task Analysis on Development of Outcome Based Curriculum

Battamir U, Sumberzul N, Bayasgalanmunkh B, Oyunsuren E

Item Analysis of Graduates Exit Examinations and Medical Licensing Examination of Graduates in Mongolia

Oyungoo B, Ser-Od Kh, Sumberzul N, Alimaa G

APMEC 2017

Issues to Improve Undergraduate Midwifery Curriculum

Bayasgalanmunkh B, Tudevдорж E, Davaa Z, Sumberzul N

Development of Midwifery Curriculum

Bayasgalanmunkh B, Davaa Z, Sumberzul N

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ХӨГЖИЛ

Аливаа их сургуулийн үндсэн үйл ажиллагаа бол нийтэд дээд боловсролын үйлчилгээ үзүүлж, ажлын байрын шаардлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц чадамжтай мэргэжилтэн бэлтгэх явдал байдаг. Энэхүү үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй төлөвлөлт, бэлтгэн гаргасан хүний нөөцийн зохистой удирдлага, зохион байгуулалттай нягт уялдаатай явагддаг. Боловсролын олон улсын стандарт ангиллыг 2013 оноос Монгол Улсад мөрдөж буй бөгөөд тэрхүү олон улсын ангиллын Эрүүл мэнд ба Нийгмийн хамгаалал бүлгийн Эрүүл мэнд дэд бүлгийн Анагаах ухаан чиглэлд Анагаахын боловсрол бие даасан салбар болон бүртгэгдсэн байдаг. БШУ-ны Сайдын мэргэжлийн чиглэл индекс батлах тухай тушаалаар Анагаах ухааны боловсрол судлалаар магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг ЭМШУИС-д олгосноор энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх эрхзүйн орчин бүрэлдсэн юм. АШУУИС-ийн эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр өөрийн эрхгүй амьдралаас урган гарсан нотолгоонд суурилсан шинжлэх ухааны үндэслэлтэй шинэчлэл их сургуульд өрнөж асуудлыг үндэс сууриар нь өөрчилж шинэчлэхийн тулд анагаах ухааны боловсрол судлалын чиглэл бүрээр анхан шатнаас нь эхлэн гүнзгийрүүлсэн түвшний судалгааны ажил хийгдэх болжээ. Энэ нь хөтөлбөрийн агуулга, арга зүйн үнэлгээ, хэрэгжилтийг судлахын зэрэгцээ багш судлаачдын эрдэм судлалын ажил болсон юм. Боловсролын хөтөлбөрийн чиглэлээр судалгааны ажил өргөжин тэлснээр Анагаах ухааны эрдмийн зөвлөл болон Анагаах ухааны боловсрол судлалын эрдэмтдийн зөвлөл шинээр бий болж Боловсрол судлалын ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шүүн хэлэлцдэг болсон нь томоохон амжилт болсон. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн болохын зэрэгцээ Анагаах ухааны боловсрол судлаач болох болсон нь томоохон дэвшил болсон төдийгүй тус сургуулийн эрдэмтэн профессорууд анагаах ухааны боловсрол судлалыг хөгжүүлэхийн төлөө ихээхэн зүтгэж, маргалдаж, мэтгэлцэж, харилцан суралцаж, гадаад дотоодын эрдэмтэн судлаачдаас онолын шинэ концепци эрэлхийлэх замаар хөгжлийн шинэ түвшинд хүрсэн билээ.

Сайн мэргэжилтний бусдаас ялгарах онцлог нь аливаа асуудлыг системийн онол зарчмын дагуу

дэс дараалалтай бүхэлд нь авч үзэж шийдвэрлэх чадвар юм. Иймд шинэхэн мэргэжилтнийг бие дааж, өргөн хүрээнд сэтгэж ажиллах, задлан шинжлэх аливаа юмс үзэгдэл, салбарын бүтэц тогтолцоог таньж, тус бүрийнх нь үүрэг үйл ажиллагааг мэдэж авах явцад мэдлэг бүтээх болно. Харин асуудлыг шийдвэрлэхийн тулд оюуны задлан шинжилгээ болон системийг бүхэлд нь авч үзэх хэрэгтэй болдог. Энэ тохиолдолд зөвхөн мэдлэг хангалтгүй. Асуудлыг томьёолох, шийдвэрлэх явцад ойлгоц, ухамсарлал бий болгох чадвар чухал үүрэгтэй. Эдгээрээс үндэслэлд боловсролын салбарт өөрчлөлт шинэчлэл хийх үйл явцад өөрчлөлт шилжилтийн зурвас үеийг аль болох бага хохиролтойгоор давахад боловсрол, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа зэрэг өргөн хүрээний асуудлуудыг алхам алхмаар шийдвэрлэн тогтолцооны бүхэл хэсгүүдтэй нь уялдуулж, салбарын хүрээнд цогц ажиллагааг хангахыг зорьж ажилласан.

Монгол улсад эмч бэлтгэх анагаах ухааны боловсролын тогтолцоог судлан олон улсын түвшинд хүртэл өөрчлөн шинэчилж, боловсронгуй болгох ажлыг ШУ-ны үндэслэлтэйгээр удирдан зохион байгуулж, эрдэм судлалын ажлыг бодлогоор өрнүүлэн хөгжүүлж, анагаах ухааны боловсрол судлалын үндэсний эрдэмтдийг төрүүлж, Монголын анагаах ухааны боловсрол судлалын салбарыг анх үүсгэн байгуулсан АУБХ-ны тэргүүн Ц.Лхагвасүрэн 2006 онд АУБХ-ны хуралд хэлсэн үгэндээ “Монголын анагаах ухаан судалгааны үндсэн дээр хөгжих ёстой” гэж дүгнэсэн юм.

Дэлхий даяар XXI зуун эхлээд дээд боловсрол судлал, тэр дотроо анагаах ухааны боловсрол судлалын чиглэлээр судалгааны ажил эрчимтэй хийгдсэн бөгөөд тэдгээр нь ихэвчлэн их дээд сургуулийг түшиглэн хийгдэж ирлээ. Ялангуяа Хойд Америк, Европын Холбооны улсуудад анагаах ухааны боловсрол судлал өндөр хөгжсөн бөгөөд Ази тивийн хувьд Хонг Конг, БНСУ, Япон, Тайвань улсууд манлайлж байна. Монгол Улсын хувьд анагаахын боловсрол судлал харьцангуй шинэ салбар бөгөөд мөн л энэ зууны эхнээс судалгааны ажил эрчимжиж, бие даасан Анагаах ухааны боловсролын холбоо байгуулагдаж, АШУУИС-д энэ чиглэлээр Эрдмийн зөвлөл бий

болон ажиллаж байна. Анагаах ухааны боловсрол судлалын чиглэлээр ажилласан эрдэмтэн судлаачид, хийгдсэн эрдэм судлалын ажлыг нэгтгэн он дарааллаар нь жагсаавал:

1. **Анагаах ухааны доктор, профессор Содовсүрэнгийн Наранчимэг.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2002 он. Монгол улс дахь сувилахуйн боловсролын сургалтын агуулга, шаталсан сургалтын тогтолцоог боловсронгуй болгох нь. Улаанбаатар, АУИС.
 2. **Анагаах Ухааны доктор, дэд профессор Бямбаагийн Ганбат.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2003 он. Эмч нарын тасралтгүй сургалтын өнөөгийн байдал ба хэтийн төлөвийн асуудал. Улаанбаатар, АУИС.
 3. **Анагаах Ухааны доктор, профессор Дашцэрэнгийн Амарсайхан.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2003 он. Анагаахын сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох асуудал. Улаанбаатар, ЭМШУИС.
 4. **Анагаах Ухааны доктор, профессор Нямжавын Сүмбэрзул.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2003 он. Анагаахын оюутны мэдлэг чадварын үнэлгээг боловсронгуй болгох нь. Улаанбаатар, ЭМШУИС.
 5. **Анагаах Ухааны доктор, Санжаагийн Оюун.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2009 он. Анагаахын төгсөлтийн дараах зайны сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Улаанбаатар, ЭМШУИС.
 6. **Анагаах Ухааны доктор, профессор Дамдинбазарын Отгонбаяр.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2010 он. Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудал. Улаанбаатар, ЭМШУИС.
 7. **Анагаах Ухааны доктор, дэд профессор Бадамдоржийн Оюунгоо.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2010 он. Анагаахын оюутны эмнэлзүйн ур чадварын үнэлгээг боловсронгуй болгох зарим асуудал. Улаанбаатар, ЭМШУИС.
 8. **Анагаах Ухааны доктор, Энэбишийн Оюунсүрэн.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2012 он. Мэргэжүүлэх сургалтын хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ. Улаанбаатар, ЭМШУИС.
 9. **Анагаах Ухааны доктор, Омбоосүрэнгийн Болорсайхан.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2012 он. Анагаахын боловсролын байгууллагын чанарын үнэлгээ. Улаанбаатар, ЭМШУИС.
 10. **Анагаах Ухааны доктор, Сандагийн Оюунцэцэг.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2015 он. Анагаахын боловсролын хөгжилд магадлан итгэмжлэлийн үзүүлэх нөлөө. Улаанбаатар, АШУУИС.
 11. **Анагаах Ухааны доктор, Баатарын Баясгаланмөнх.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2016 он. Үр дүнд суурилсан эх барихуйн сургалтын загвар. Улаанбаатар, АШУУИС.
 12. **Анагаах Ухааны доктор, Гомбоогийн Алимаа.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2019 он. Хүний их эмч мэргэжлээр төгсөгчдийн мэдлэгийн үнэлгээг харьцуулан судалсан дүн. Улаанбаатар, АШУУИС.
 13. **Анагаах Ухааны доктор, Wu Qizhu.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2020 он. БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Монгол анагаах ухааны эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудал. Улаанбаатар, АШУУИС.
 14. **Анагаах Ухааны доктор, Aduqinfu.**
Анагаах Ухааны доктор (Ph.D), 2020 он. БНХАУ-ын Өвөр Монголын үндэстний их сургуулиар эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ. Улаанбаатар, АШУУИС.
- Анагаах Ухааны магистр**
1. **Анагаах ухааны магистр Н.Энхжаргал**
“Уламжлалт анагаахын бакалаврын боловсрол олгох сургалтын цөм төлөвлөгөө” 2005 он, ЭМШУИС.
 2. **Анагаах ухааны магистр Б.Баянмөнх**
“Уламжлалт анагаах ухааны оношилгооны аргуудыг программчлах асуудал” 2005 он, ЭМШУИС.

3. **Анагаах ухааны магистр П.Туул** “Анагаахын оюутны хандлагыг төлөвлөгдсөн зорилготой эмнэлзүйн шалгалтаар үнэлэх асуудалд” 2010 он, ЭМШУИС.
4. **Анагаах ухааны магистр Ч.Чинзориг** “Нэгдсэн шалгалтын үнэлгээг боловсронгуй болгох зарим асуудалд” 2010 он, ЭМШУИС.
5. **Анагаах ухааны магистр Б.Балжинням** “ЭМШУИС-ийн багшлах боловсон хүчин, багшийн ажлын үнэлгээнд хийсэн судалгаа” 2011 он, ЭМШУИС.
6. **Анагаах ухааны магистр Г.Баярбат** “Дээд боловсролын байгууллагын санхүүжилт, сургалтын төлбөрийн зарим асуудалд” 2011 он, ЭМШУИС.
7. **Анагаах ухааны магистр С.Оюунсүрэн** “Нүүр ам судлалын сургуулийн төгсөгчдийн эмнэлзүйн ур чадварын шалгалтын үнэлгээний асуудалд” 2012 он, ЭМШУИС.
8. **Анагаах ухааны магистр Т.Сумьяасүрэн** “ЭМШУИС-ийн ИСУМС-ийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ” 2012 он, ЭМШУИС.
9. **Анагаах ухааны магистр Э.Баярмаа** “Уламжлалт анагаахын сургуулийн төгсөлтийн шалгалтанд хийсэн үнэлгээ” 2013 он, ЭМШУИС.
10. **Анагаах ухааны магистр Д.Энхтуяа** “Сувилахуйн мэргэжил олгох сургалтын боловсронгуй болгох асуудалд” 2014 он, ЭМШУИС.
11. **Анагаах ухааны магистр Т.Жаргал** “Анагаахын оюутнуудын нарийн мэргэжлийн сонголтын байдал, түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийн судалгаа” Улаанбаатар, “Ач” АУИС, 2012.
12. **Анагаах Ухааны магистр, У.Баттамир** “Мэргэшигч эмч нарын бие хүний төлөвшлийн онцлог ба мэргэжил сонголт”, Улаанбаатар, ЭМШУИС, 2014.
13. **Анагаах Ухааны магистр, З.Баярцэнгэл** “Анагаахын ухааны судалгаанд онлайн мэдээллийн сангийн ашиглалын үнэлгээ” Улаанбаатар, ЭМШУИС, 2015.
14. **Анагаах Ухааны магистр, М.Энхтөгөлдөр** “Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын “Хамт олонд түшиглэсэн сэргээн засах” сургалтын хэрэгцээ” сэдэвт судалгааны ажлын явцыг хэлэлцэх” Улаанбаатар, АШУУИС, 2015.
15. **Анагаах Ухааны магистр, М.Өсөхбаяр** “Хүний их эмч бэлтгэх сургалтын нэгдмэл хөтөлбөрт өгөх төгсөгчдийн сэтгэл ханамж” Улаанбаатар, АШУУИС, 2015.
16. **Анагаах Ухааны магистр, М.Солонго** “Эрүүл мэндийн мэдээлэл зүйн мэргэжлээр төгсөгчдийн сэтгэл ханамж, ажил эрхлэлтийн өнөөгийн байдал” Улаанбаатар, АШУУИС, 2015.
17. **Анагаах Ухааны магистр Б.Нарангэрэл** “Эм зүйчийн эзэмших цогц чадамжийг тодорхойлох нь” Улаанбаатар, АШУУИС, 2016.
18. **Анагаах ухааны магистр И.Энхтуул** “Сэдэлжүүлэлт сурлагын амжилтад нөлөөлөх нь” Улаанбаатар, АШУУИС, 2017.
19. **Анагаах ухааны магистр Н.Мөнх-Учрал** “Анагаахын сургуульд элсэн суралцагчдын дасан зохицох байдал голч дүнд нөлөөлөх нь” Улаанбаатар, АШУУИС, 2017.
20. **НЭМУ-ы магистр Э.Хангай** “Сувилахуйн сургалтын орчинд хийсэн сэтгэл ханамжийн судалгаа” Улаанбаатар, АШУУИС, 2017
21. **НЭМУ-ы магистр Э.Бат-Өлзий** “Төгсөгчдийн ур чадварыг үнэлэх шалгалтын талаарх сэтгэл ханамжийн судалгаа” Улаанбаатар, АШУУИС, 2017
22. **НЭМУ-ы магистр С.Гал-Эрдэнэ** “Оюутны үнэлгээг боловсронгуй болгох асуудалд” Улаанбаатар, АШУУИС, 2017
23. **НЭМУ-ы магистр Г.Батболд** “АШУУИС-ийн багшийн хөгжлийн хэрэгцээг судалсан дүн” Улаанбаатар, АШУУИС, 2017
24. **НЭМУ-ы магистр Ж.Оргил** “Анагаахын суурь сургалтын үнэлгээ” Улаанбаатар, АШУУИС, 2018
25. **НЭМУ-ы магистр Б.Наранбат** “АШУУИС-д хэрэгжиж буй ИСУМС-д хийсэн үнэлгээ” Улаанбаатар, АШУУИС, 2018

- 26. Анагаах ухааны магистр З.Ужин** “Лекцийн хичээлийн арга хэлбэрүүд суралцагчийн сэтгэл ханамжид нөлөөлөх нь” Улаанбаатар, АШУУИС, 2018
- 27. Анагаах ухааны магистр П.Билэгсайхан** “Их сургуулийн хамтын ажиллагаа багшийн хөгжилд нөлөөлөх нь” Улаанбаатар, АШУУИС, 2019
- 28. Анагаах ухааны магистр С.Сэржням** “Гардан үйлдлийг дуураймал орчинд давтуулах зохистой хэмжээг судлах нь” Улаанбаатар, АШУУИС, 2019
- 29. Анагаах ухааны магистр Г.Ууганзаяа** “Боловсролын их өгөгдөл: суралцагчийн үнэлгээг өгөгдөл олборлолтын аргаар урьдчилан тодорхойлох нь” Улаанбаатар, АШУУИС, 2020

ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн даргын 2020 оны 04 сарын 13-ны өдрийн 05 тоот тушаалаар Эрүүл мэндийн мэргэжлийн зөвлөлийн Монголын Анагаах Ухааны Академийн ерөнхийлөгч, академич, Монголын анагаах ухааны боловсролын холбооны тэргүүн Ц.Лхагвасүрэн, орлогч даргаар Шинэ

анагаах ухааны сургуулийн захирал М.Амбага, нарийн бичгийн даргаар АШУУИС-ийн Хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга АУ-ны доктор, дэд профессор О.Болорсайхан нар, нийт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус зөвлөлөөр улсын хэмжээнд дараах хөтөлбөрүүд магадла итгэмжлэгдсэн. Үүнд:

Δ/д	Сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Индекс	МИ-ийн давтамж	Магадлан итгэмжлэлийн дуусах хугацаа
Анх удаагаа магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр					
1	АШУУИС	Нийгмийн ажил	D092301	I	2024.06.20
2	АШУУИС	Хөдөлгөөн засал	D091501	I	2024.06.20
3	АШУУИС	Эх барихуй	D091302	I	2025.06.04
4	Олон Улсын Улаанбаатарын их сургууль	Сувилахуй	D091301	I	2026.04.15
5	Оточ-манрамба	Уламжлалт анагаах ухаан	D091701	I	2026.07.02
6	Шинэ АУИС	Эмзүй	D091601	I	2026.07.02
7	АШУУИС	УАУ магистр	E09170101	I	2026.04.15
8	Ач АУИС	Нүүр ам судлал	D091101	I	2027.02.21
9	Этүгэн их сургууль	Сувилахуй	D091301	I	2027.02.21
10	Этүгэн их сургууль	Био-Анагаах ухаан	D091401	I	2027.02.21
11	Глобал Удирдагч Их сургуулийн Сувилахуйн сургууль	Сувилахуй	D091301	I	2023.04.13
12	АШУУИС Сувилахуйн сургууль	Хөдөлмөр засал	D091503	I	2027.06.17
13	АШУУИС Сувилахуйн сургууль	Сувилахуйн дипломын хөтөлбөр	C091301	I	2027.07.05
14	АШУУИС Дархан-Уул аймаг дахь АУС	Уламжлалт анагаах ухааны сувилагч	C091701	I	2027.07.05
15	АШУУИС Говь-Алтай аймаг дахь салбар АУС	Эх барихуй	C091308	I	2028.01.18
16	АШУУИС Дорноговь аймаг дахь салбар АУС	Сувилахуй	C091301	I	2024.01.18
17	Шинэ анагаах ухаан их сургууль	Анагаах ухаан	D091201	I	2028.01.18
18	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	“Уламжлалт анагаахын засал”	D091704	I	2028.05.24

19	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	“Зүү төөнө засал”	D091703	I	2024.05.24
20	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	Дүрс оношилгоо	C091203	I	2028.05.24
2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр					
21	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	Нийгмийн эрүүл мэнд	D091801	II	2023.06.20
22	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	Эм зүй	D091601	II	2023.06.20
23	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	Био-анагаах ухаан	D091401	II	2023.06.20
24	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн	Уламжлалт анагаах ухаан	D091701	II	2023.06.20
25	Шинэ анагаах ухаан их сургууль	Уламжлалт анагаах ухаан	D091701	II	2023.06.20
26	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль	Эм зүй	D091601	II	2026.04.15
27	Ач анагаах ухааны их сургууль	Анагаах ухаан	D091201	II	2027.07.05
28	АШУУИС	Лабораторийн техникч	C091401	II	2026.07.02
29	АШУУИС	Нүүр амны техникч	C091101	II	2027.02.21
30	ЭЗШУИС	Эмзүй	D091601	II	2026.04.15
3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр					
31	АШУУИС	Нүүр ам судлал	D091101	III	2024.06.20
32	АШУУИС Сувилахуйн сургууль	Сувилахуй	D091301	III	2027.06.17
Урьдчилсан магадлан итгэмжлэл					
33	Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль	Сувилахуй	091301	091-Эрүүл мэнд	2028.04.25
34	Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль	Эм найруулагч	091602	091-Эрүүл мэнд	2028.04.25
35	Этүгэн их сургууль	Уламжлалт анагаах ухаан	091701	091-Эрүүл мэнд	2028.04.25
36	Глобал удирдагч их сургууль	Сувилахуй	091301	091-Эрүүл мэнд	2024.04.25

ОЛОН УЛСЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР НЬ ОЛОН УЛСАД АМЖИЛТТАЙ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЛЭЭ.

АШУУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн “Нийгмийн Эрүүл Мэнд” бакалаврын хөтөлбөр нь Agency of Public Health Education Accreditation (APHEA) байгууллагаар 6 жилийн хугацаагаар амжилттай магадлан итгэмжлүүлэв.

Дэлхийн улс орнуудад APHEA буюу Нийгмийн эрүүл мэндийн Боловсролын Магадлан Итгэмжлэх Агентлаг нь НЭМ-ийн мэргэжлийн боловсролын чиглэлээр төрөлжсөн магадлан итгэмжлэл хийдэг ТЭРГҮҮЛЭГЧ байгууллага юм.

APHEA нь ДЭМБ-ын бүх бүсчлэлээс 168 хөтөлбөр, сургуулийг магадлан итгэмжлэсэн ба түүний нэг нь АШУУИС-ийн НЭМС-ийн Нийгмийн эрүүл мэндийн БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР боллоо.

APHEA нь Европын бүсийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулиудын холбоо ASPHER (The Association of Schools of Public Health in the European Region), Үндэсний Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгүүдийн Олон улсын холбоо (International Association of National Public Health Institutes (IANPHI), Европын Нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэг (EUPHA), Европын нийгмийн эрүүл мэндийн сүлжээ, European Public Health Alliance (EPHA) зэрэг байгууллагын салбар билээ.

НЭМ-ийн сургалтын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулснаар олон улсад хүлээн зөвшөөрч, уг хөтөлбөрийн суралцагч оюутан, төгсөгч нарт олон улсын түвшинд ажиллах, суралцах боломж нээгдэж байна.

Цаашид Монголын НЭМ-ийн ажиллах хүчийг дэлхий дахинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.



АШУУИС-ийн СУВИЛАХУЙН СУРГУУЛИЙН “СУВИЛАГЧ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР нь Accreditation Agency for Study Programmes in Engineering, Informatics, Natural Sciences and Mathematics (ASIIN e.V.) байгууллагаар амжилттай магадлан итгэмжлүүлээ.

ААSIIN нь инженерчлэл, байгалийн ухаан, математик, компьютерийн шинжлэх ухаан, анагаах ухаан, эдийн засгийн чиглэлээр дээд боловсролын байгууллага, хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх үндэсний болон олон улсад тэргүүлэгч агентлаг юм.

Тус байгууллага нь 2016 онд Германы магадлан итгэмжлэлийн зөвлөлийн (GAC German Accreditation Council) хөндлөнгийн үнэлгээгээр

ЕНЕА (European Higher Education Area) чанарын баталгаажуулалтын удирдамж, Европын стандартыг хангасан бөгөөд Европын дээд боловсролын чанарын баталгаажилтын холбоо (ENQA) ны гишүүн. ASIIN нь инженерчлэл (EUR-ACE®), мэдээлэл зүй (Euro-Inf®) болон химийн (Eurobachelor®/Euromaster®) зэрэг салбарт Европын чанарын шошго олгох эрхтэй агентлаг юм.

АШУУИС-ийн бренд болсон хөтөлбөрүүдийн нэг болох Сувилахуйн сургалтын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулснаар олон улсад хүлээн зөвшөөрч, уг хөтөлбөрөөр суралцагч оюутан, төгсөгч нарт олон улсын түвшинд ажиллах, суралцах боломж нээгдэж байна.



АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ОЛОН УЛСЫН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ /2023-2024/

Байгууллага	Хурал	Хугацаа	Байршил
AHE Network (Assessment in Higher Education)	Annual International AHE Conference	June 22-23, 2023	Manchester UK
ANZAHPE (Australian and New Zealand Association for Health Professional Educators)	Annual ANZAHPE Festival	June 26-29, 2023	Queensland
AMEE (International Association for Health Professions Education)	AMEE Annual Conference	Aug 26-30, 2023	Glasgow
SCFP (Saskatchewan College of Family Physicians)	Annual Family Medicine Conference	Sep 8, 2023	Regina, SK
CLIC (Consortium of Longitudinal Integrated Clerkships)	2023 CLIC Conference	Sep 19-24, 2023	Spokane, WA
RCPSC (Royal College of Physicians and Surgeons of Canada)	International Conference on Residency Education	October 19-21, 2023	Halifax, NS
WONCA (World Organization of Family Doctors)	World Conference	Oct 26-29, 2023	Sydney, Australia
NAPCRG (North American Primary Care Research Group)	Annual Meeting	Oct 30-Nov 3, 2023	San Francisco, California
CFPC (The College of Family Physicians of Canada)	FMF (Family Medicine Forum)	Nov 8-11, 2023	Montreal, QC
AAMC (Association of American Medical Colleges)	Learn Serve Lead: The AAMC Annual Meeting	Nov 3-7, 2023	Seattle, WA
EACH (International Association for Communication in Healthcare) & ACH (Academy on Communication in Healthcare)	International Conference on Communication in Healthcare (ICCH)	Nov 18-19, 2023	Paris, France
APMEC (Asian Pacific Medical Education Conference)	Annual Conference	Jan 17-21, 2024	University of Colombo, Sri Lanka
AMEE (International Association for Health Professions Education)	Ottawa Melbourne 2024	Feb 24-28, 2024	VIC, Australia
SACME (Society for Academic Continuing Medical Education)	Annual Meeting	TBA (typically occurs in March)	
CGEA (Central Group on Educational Affairs)	Regional Meeting	TBA (typically occurs in April)	
AFMC (The Association of Faculties of Medicine of Canada)	ICAM Annual Conference	April 11-15, 2024	Vancouver, BC
SRPC (Society of Rural Physicians of Canada)	Rural & Remote Annual Conference	April 18-20, 2024	Edmonton, AB
NOSM (Northern Ontario School of Medicine)	Northern Constellations Annual Faculty Development Conference	TBA (typically occurs in May)	
KT Canada (Knowledge Translation Canada)	KT Canada Annual Scientific Meeting	TBA (typically occurs in May)	

CSPL (Canadian Society of Physician Leadership)	Canadian Conference on Physician Leadership	TBA (typically occurs in May)	
STFM (Society of Teachers in Family Medicine)	Annual Spring Conference	May 4-8, 2024	Los Angeles, CA
RCPSC (Royal College of Physicians and Surgeons of Canada)	International Conference on Residency Education	Sep 19-21, 2024	Ottawa, ON
AMA / CMA / BMA	International Conference on Physician Health	October 17-19, 2024	Halifax, NS
NAPCRG (North American Primary Care Research Group)	52nd Annual Meeting	November 20-24, 2024	Quebec, QC

“АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ” СЭТГҮҮЛД ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВЧ НИЙТЛЭХ ЖУРАМ

НЭГ. ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Тухайн өгүүлэл нь өөр хэвлэлд хэвлэгдэж байгаагүй байх.
2. Эмнэлзүйн болон эмнэлзүйн бус, тархвар судлалын чиглэлээр хийгдсэн бол зохих журмын дагуу ёс зүйн хорооноос зөвшөөрөл авсан байна.
3. Өгүүлэл нь шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг санаа дэвшүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц арга ашиглан гарсан үр дүнг шинжлэх ухаанчаар тайлбарласан байна.
4. Сэтгүүлд ирэх материалыг сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга хүлээн авч, ерөнхий эрхлэгчид танилцуулна. Ерөнхий эрхлэгчийн томилсон шинжээч зөвшөөрсний үндсэн дээр өгүүллийг хэвлэлтэнд шилжүүлнэ.

ХОЁР. ӨГҮҮЛЭЛ БИЧИХ ЗААВАР

1. Өгүүлэл нь монгол хэлээр бичигдсэн, англи, монгол товчлолтой байна.
2. Өгүүлэл нь хэвлэмэл хуудас А4 хэмжээтэй цаасан дээр зүүн гар талаас 3.0 см, баруун гар талаас 2.0 см, дээр, доороос 2.0 см-ийн зайтай, үсгийн хэмжээ Arial 12, мөр хоорондын зай 1.5, нийт 3-5 хуудас байна.
3. Өгүүлэл нь дараах бүтэцтэй байна

Өгүүлэлийн нэр:

1-р зохиогч уг судалгааны ажлын үндсэн хэсгийг хийсэн байх, сүүлчийн зохиогч уг ажлыг удирдсан байх. Зохиогчийн нэрийн баруун дээд өнцөгт 1.2 гэх мэтээр тэмдэглэн, нэрсийн доор зохиогчийн албан газар, 1-р зохиогчийн e-mail хаягийг бичсэн байна.

Товч утга:

Зорилго, арга аргачлал, үр дүн, дүгнэлт гэсэн бүтэцтэйгээр 200-250 хүртэл үгэнд багтааж бичнэ.

Түлхүүр үг:

Өгүүлэлийн санааг илэрхийлэхүйц 4-5 үг байна.

Удиртгал:

Судалгааны ажлын үндэслэл, шинэлэг тал, зорилгыг тусгасан байна.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй:

Судалгааны хэрэглэгдэхүүн, хамрах хүрээ, судалгааны арга, мэдээ материал цуглуулсан арга, статистик боловсруулалтын талаар тодорхой бичсэн байна.

Үр дүн:

Судалгаанаас гарсан үр дүнг тодорхой бичих, үр дүнийн тайлбарыг хүснэгт болон зургаар илэрхийлэхдээ

давхардуулахгүй байх. Хүснэгтийн гарчгийг хүснэгтийн дээд талд, зураг дүрслэлийн гарчгийг зургийн доод талд тавина.

Хэлцэмж:

Судалгааны ажлын ач холбогдол, давуу болон сул талыг тусгахаас гадна судалгааны ажлаас гарсан үр дүнг гадаад, дотоодын бусад судлаачын ижил төстэй судалгааны үр дүнтэй харьцуулсан байна.

Дүгнэлт:

Үр дүнд тулгуурласан товч тодорхой байна.

Талархал:

1-2 өгүүлбэр байна. Судалгааны ажлын санхүүжүүлэгч, хамтрагчид болон судалгаанд оролцогчдоод хандсан байна.

Ашигласан хэвлэл:

Vancouver-ийн загвар ашиглан бичнэ.

Англи товчлол:

Өгүүллийн нэр, зохиогчийн нэр, албан газар, өгүүллийн товч утгыг англи хэлээр 200-250 үгэнд багтааж бичсэн байх/

Жич:

- Ишлэлийг [1] гэж тэмдэглэнэ. Ишлэл авсан номыг зөв дугаарлаж, тодорхой бичнэ.
- Өгүүлэлд нэр томъёог товчилж болохгүй.
- Өгүүлэлд хэрэглсэн хэмжигдэхүүнийг Олон улсын СИ системээр тэмдэглэнэ.
- Өгүүлэлд фото зураг, график, диаграммыг хар, цагаан тод ялгарах контрасттайгаар тайлбарын хамт ирүүлнэ. Фото зураг DPI 300, JPEG болон TIF өргөтгөлтэйгээр хүлээн авах ба зургийг Text box-оор засварлахыг хориглоно.

Хураамж:

Сэтгүүлд хэвлүүлэх өгүүлэлийн нэг нүүр тутамд 5000 төгрөгийн хураамж төлөх ба энэ нь сэтгүүлийн хэвлэлийн зардал болон редакторын ажлын хөлсөнд зарцуулагдана. Хураамжыг МАУБХ-ны Капитрон банкны төв салбарын 3053000178 тоот дансанд тушааж өгүүлэл ирүүлэхдээ хуулгыг авч ирнэ.

Удирдагчийн захидал

Судалгааны ажлын албан ёсны удирдагчаас өгүүллийг АУБС сэтгүүлд хэвлэхийг хүссэн захидал ирүүлсэн байна.

МАУБХ-ны гишүүнд үзүүлэх урамшуулал

Монголын анагаах ухааны боловсролын холбооны тухайн оны гишүүнчлэлд бүртгүүлсэн гишүүн АУБС сэтгүүлийн нэг дугаар үнэгүй авах эрхтэй.

“АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ” СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИД ГАРГАХ ХҮСЭЛТ

оны сарын өдөр

(Тухайн өгүүллийн зохиогчдын нэрсийн жагсаалтанд хамгийн сүүлд бичигдэх, эрдэм шинжилгээний ажлын удирдагч энэхүү захидлыг бичнэ.)

..... (хаана)-д ажилтай (хэн) овогтой (хэн) миний бие бусад хамтран зохиогчидоо төлөөлөн (судалгааны ажлын нэр)СЭДЭВТ өгүүлийг “Анагаах Ухааны Боловсрол Судлал” сэтгүүлд хэвлүүлэхээр илгээж байна.

(1) Энэхүү өгүүлэл нь “Анагаах Ухааны Боловсрол Судлал” сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх журмын дагуу бичигдсэн болно.

(2) Бидний илгээж буй өгүүлэл(он/сар/өдөр).....-.....(он/сар/өдөр)..... хооронд(хэдэн жил/сар).....-н хугацаанд(хаана).....-нд хийгдсэн(судалгааны ажлын нэр)..... СЭДЭВТ судалгааны ажлын үр дүнгийн хэсэг бөгөөд (3) өөр сэтгүүлд урьд өмнө нь нийтлэгдэж байгаагүй болно.

(4) Өгүүллийн ач холбогдол нь(өгүүлэлийн шинжлэх ухааны болон практикийн ач холбогдлыг товч бичнэ).....-д оршино.

(5) Би болон бусад хамтран зохиогчид болох.....(бүх хамтран зохиогчдын нэр, ажлын газрыг бичнэ).....нар энэхүү өгүүлэлтэй танилцсан, агуулгыг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа болно.

(6) Бид сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх журмыг хүлээн зөвшөөрч байгаа ба сэтгүүлийн редакцын зөвлөлөөс ирүүлсэн саналыг талархан хүлээн авч холбогдох засварыг заагдсан хугацаанд хийж ирүүлэх болно.

Хүсэлт гаргасан:


Нэр/гарын үсэг:

Байгууллага:

Албан тушаал:

Холбогдох утасны дугаар:

Цахим шуудан:



ЭМ ЗҮЙН СУРГУУЛЬ

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

1942



АШУУИС-ИЙН ЭМ ЗҮЙН СУРГУУЛИЙН “СУДРЫН ТУН” ХХК

01

2014 оны IX сар

02

2014 оны XII сар

03

2015 оны VI сар

04

2018 оны I сар



АШУУИС-ийн захирлын А/16 тоот тушаалаар үйл ажиллагааг эхлүүлэв. БШУЯ-ны ШУТС болон Эм зүйн сургуулийн хөрөнгө оруулалтаар эмийн үйлдвэрийн 3 шугамын тоног төхөөрөмжийг суурилуулав

Үйлдвэрийн үйл ажиллагаа





ХУВЬСАЖ БҮЙ ДЭЭД БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖИЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ

Монголын Анагаах Ухааны Боловсролын Холбооны Х хурал

Хаяг: Зоригийн гудамж-3, Ш/Х-48-111, Улаанбаатар-210648, Монгол улс

Утас: 7013-1372

Албан ёсны вэб хуудас: www.mmea.mn

Цахим шуудан: otgonbayar@mmea.mn